



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим худас: www.mongolia.gov.mn

2026. 01.08 № 3г-1/09
танай -ны № -т

Г Асуудал зөвшилцөх тухай

Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Цөмийн энергийн тухай хуулийн 30.3-т заасны дагуу Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хороотой зөвшилцөхөөр хүргүүлж байна.

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ӨЮУН-ЭРДЭНЭ



000254000456

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны 2 дугаар тэмдэглэлд:

“7.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хороотой зөвшилцөх тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг хэлэлцээд Цөмийн энергийн тухай хуулийн 30.3-т заасны дагуу Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтов.” гэжээ.



ТАНИЛЦУУЛГА

“Бадрах энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч
Орано Майнинг С.А.С компанийтай байгуулах
Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн талаар

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 10 дугаар сард Бүгд Найрамдах Франц Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсын Засгийн газар болон Орано Майнинг САС хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулах Ажлын хэсгийн хэлэлцээний протоколд 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр талууд гарын үсэг зурсан.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Орано Майнинг САС компани хооронд байгуулах уран олборлох төслийн Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд санал, дүгнэлт боловсруулах, хэлэлцээ хийх, эцэслэн боловсруулсан хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 27 дугаар захирамжаар, тус ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх ажлын дэд хэсгүүд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2024 оны 93 дугаар тушаал, 2024 оны 140 дүгээр тушаалаар тус тус байгуулагдан ажиллаж байна. Салбарын сайдуудаар ахлуулсан ажлын дэд хэсгүүд мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаач, хөндлөнгийн төлөөллийг оролцуулан өргөн бүрэлдэхүүнтэй байгуулагдаж энэхүү гэрээг Монгол улсын эрх ашигт нийцсэн, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа дийлэнх үр өгөөж ард түмэнд ногдож байх, талуудын хүртэх өгөөжийг тэнцвэртэй хангах суурь зарчмуудыг хатуу баримтлан ажилласан болно.

Мөн энэ чиглэлээр олон улсад нэр хүнд бүхий мэргэшсэн мэргэшсэн санхүү, хууль, байгаль орчны зөвлөхүүд (гэрээ, эрх зүйн чиглэлээр Английн White & Case олон улсын хуулийн фирмтэй 2024 оны 02 дугаар сарын 5-ны өдрөөс, татвар, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын чиглэлээр АНУ-ын Charles River Associates олон улсын зөвлөх компанийтай 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс, байгаль орчны чиглэлээр ХБНГУ-ын GeoEnergy Consult компанийтай 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн)-ийг улсын аюулгүй байдлыг хариуцсан байгууллага (Тагнуулын ерөнхий газар)-тай зөвлөлдсөний үндсэн дээр авч ажиллуулсны дээр дотоодын хуулийн болон санхүүгийн зөвлөхүүдийг ажиллуулж тэдгээрийн мэргэжлийн байр суурь, санал дүгнэлтийг гэрээнд тусгаж Монголын талаас гэрээний төслийн шинэчилсэн хувилбарыг боловсруулан хөрөнгө оруулагч талд хүргүүлсэн бөгөөд хөрөнгө оруулагчаас саналаа тусган ирүүлснийг ажлын хэсэг нарийвчлан судалж хэлэлцээг хийлээ. Ингэхдээ хэлэлцээрийг олон улсын жишиг арга аргачлал, нэгдэн орсон конвенц, гэрээ хэлэлцээг чухалчлан үзсэний дээр Монгол Улсын хууль тогтоомжид нийлүүлэхэд онцгой анхаарч олон талаас нь асуудалд дүн шинжилгээ хийж, ирээдүйд аливаа эрх зүйн үр дагаваргүй, жишиг гэрээ болон хэрэгжихэд анхаарч эдгээр ажлын хэсгүүдийн төлөөлөл нягт уялдаж ажилласан.

2023 оны 10 дугаар 12-ны өдөр Монгол Улсын Засгийн газар болон Орано Майнинг САС компанийн хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулах ажлын хэсгийн хэлэлцээний протоколд талууд гарын үсэг зурсан бөгөөд протоколд тогтвортжуулалт, төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаа, ашигт

малтмалын нөөц ашигласны суурь, өсөн нэмэгдэх, тусгай төлбөр, бус нутгийн хөгжил, байгаль орчныг хамгаалах, хөрөнгө оруулалтын гэрээний урьдчилсан нөхцөлүүд зэрэг асуудлыг урьдчилан зөвшилцсөн байдаг.

Энэхүү төсөл нь гуравдагч орны хоёр дахь томоохон хөрөнгө оруулалтын гэрээ болох бөгөөд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх улс орон нутгийн төсөвт жилд 520 тэрбум, төслийн нийт хугацаанд 17,1 их наяд төгрөг, Үндэсний баялгийн санд жилд 61,5 тэрбум, төслийн нийт хугацаанд 2 их наяд төгрөгийг төвлөрүүлж валютын орох урсталыг нэмэгдүүлэх, 1600 орчим ажлын байр бий болгох ач холбогдолтойн дээр, шинэ технологи нутагшуулж, шинэ төрлийн үйлдвэр (хүхрийн хүчлийн үйлдвэр)-үүд баригдах боломжийг бүрдүүлэх юм.

Ажлын хэсэг өнгөрсөн хугацаанд Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11, 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар тус тус өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хөрөнгө оруулалтын гэрээ, хэлэлцээний явцыг танилцуулж ажилласан. Улмаар Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон дагах хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, цацраг идэвхт ашигт малтмалыг эдийн засгийн эргэлтэд оруулах эрх зүйн орчныг боловсронгуй болголоо.

Түүнчлэн ажлын хэсгийн өргөтгөсөн хурлыг хэд хэдэн удаа зохион байгуулж талуудын хооронд байгуулсан протокол, Цөмийн энергийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэлэлцээрийн бэлтгэлийг хангаж хөрөнгө оруулагчтай нийт 18 удаагийн хэлэлцээг хийж талуудын байр суурийг нэгтгэн шинэчилсэн гэрээний төслийг урьдчилан тохиролцоод байна. Тус Хөрөнгө оруулалтын шинэчилсэн гэрээний төсөл нь 18 бүлэг 86 зүйл 355 заалттай бөгөөд Талууд хэлэлцээний үр дүнд дараах үндсэн нөхцөлүүдийг харилцан ойлголцлоо. Үүнд:

Эдийн засаг, хөрөнгө оруулалтын чиглэлээр:

- Анхны хөрөнгө оруулалтын хэмжээ нь ойролцоогоор 500,000,000 ам.доллар байх бөгөөд гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс хойш 4 жилийн хугацаанд хийхээр тусгаж, хөрөнгө оруулагчийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой хугацаатай зааж өгсөн.
- Хөрөнгө оруулагч тал анхны хөрөнгө оруулалтын санхүүжилтийг зээл, түүнтэй адилтгах санхүүгийн хэрэгслээр бүрдүүлэхгүй өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тохирсон ба төслийн хугацаанд хувь нийлүүлэгчийн зээлийг хязгаарлаж, зээл авах зайлшгүй онцгой шаардлага үссэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын 100% шийдвэрээр шийдвэрлэхээр тохирлоо. Энэ нь хөрөнгө оруулагч тал санхүүгийн үр ашигтай ажиллаж, ногдол ашгаараа хөрөнгө оруулалтаа нөхөх хөшүүргийг бүрдүүллээ.
- Засгийн газар төсөлд ямар нэгэн байдлаар хөрөнгө оруулалт хийх үүрэг хүлээхгүй байхаар тохирлоо.
- Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө Төсөл хэрэгжүүлэгч компанийд олгосон Хувьцаа эзэмшигчийн зээлийг Төсөл хэрэгжүүлэгч компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд шилжүүлэхээр тохирлоо.

- Хөрөнгө оруулагч талаас ирүүлсэн санхүүгийн тооцооллыг шууд ашиглахаас илүүтэй, Техник, эдийн засгийн үндэслэлд тулгуурлан, олон улсын FAST (Flexible, Appropriate, Structured, Transparent) стандартын дагуу өөрийн талын санхүүгийн тооцооллын загварыг Монголын тал боловсруулж, хөрөнгө оруулагчтай тулган баталгаажуулалт хийсний үндсэн дээр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын үр өгөөжийн дийлэнх хэсэг буюу 51-ээс доошгүй хувийг Монгол Улс хуримтлагдсан дүнгээр жил бүр хүртэх тооцооллыг баталгаажууллаа.
- Гэрээний төсөлд Засгийн газрын үр өгөөжийг илүү хязгаарлагдмал хүрээнд тодорхойлж, хөрөнгө оруулагч талд ногдох үр өгөөжийг өргөн хүрээгээр тусгайлан дурдаж, хэрэв Монголын талын шууд үр өгөөж 51 хувьд хүрэхгүй тохиолдолд Хөрөнгө оруулагч болон Төсөл хэрэгжүүлэгч компани нь хуримтлагдсан дүнгээр үр өгөөжийг 51 хувьд хүргэхэд шаардлагатай үр өгөөж тохируулах нэмэлт төлбөрийг Засгийн газарт нөхөн төлөх үүрэгтэй байхаар тохиролцлоо.
- Засгийн газар төсөл хэрэгжүүлэгч компанийн эздийн өмчийн 10 хувьтай тэнцэх “Төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаа”-г үнэ төлбөргүй, шууд эзэмших ба хувь хэмжээг буурахгүй, энгийн хувьцаа эзэмшигчдээс тэргүүн ээлжид ногдол ашиг хүртэх, давуу эрхийн хувьцааны ногдол ашиг хуваарилагдаагүй тохиолдолд энгийн хувьцаа эзэмшигчид ногдол ашиг авахгүй байхаар тохирлоо.
- Засгийн газар нь бүтээгдэхүүний 10 хүртэл хувийг Хөрөнгө оруулагчтай ижил нөхцөл, болзлын дагуу худалдан авахаар гэрээний төсөлд тусгалаа.
- Засгийн газар нь компанийн дүрэмд өөрчлөлт орох, тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах, баталгаа гаргах өөрчлөлт оруулах асуудлаар хориг тавих эрхтэй байх заалтыг тусгалаа.

Татвар, санхүүгийн чиглэлээр:

- Хөрөнгө оруулагч талаас нийт 27 төрлийн татварыг тогтвортжуулах саналыг ирүүлснийг хэлэлцээрийн явцад бууруулан, зөвхөн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, НӨАТ, АМНАТ, Гаалийн тариф гэсэн 4 төрлийн татварыг тогтвортжуулахаар тохирлоо.
- Татвар тооцох аргачлалыг өргөн утгаар нь тогтвортжуулах саналыг ирүүлснийг хэлэлцэн, зөвхөн татварын төрөл, хувь хэмжээ, элэгдэл, хорогдол тооцох хугацаа, алдагдал ирээдүйд шилжүүлэн тооцох хугацаа гэсэн 3 үзүүлэлтийг тогтвортжуулахаар тохирлоо.
- АМНАТ-ийг үндсэн болон нэмэгдүүлсэн хувиар тооцох бөгөөд тусгай төлбөрийг бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс хасагдуулга, инфляци тооцохгүйгээр, бүрэн төлөхөөр тусгалаа.
- Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн (BEPS) эсрэг зарчим болон дотоодын хуулийг бүрэн дагаж мөрдөхөөр гэрээний төсөлд тусгав.
- Маркетингийн төлбөрийг татварын болон санхүүгийн тайлангийн зорилгоор хасагдах зардалд зардлаар бүртгэхгүй болохыг хэлэлцээрийн явцад хөрөнгө оруулагч талаар зөвшөөрүүлэв.
- Засгийн газрын 2010 оны 11 дүгээр сарын 10-ний өдрийн 286 дугаар тогтоолоос хойш өнөөг хүртэл шар нунтгийг ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүнд тооцож экспортод “0” хувийн НӨАТ ногдуулан буцаан олгохоор заасныг өөрчлөхөөр хатуу байр суурийг баримтлан хэлэлцээр хийв. Хөрөнгө оруулагч талаас зөвхөн ураны төсөлд зориулж тогтоол өөрчлөхийг зөвшөөрөх боломжгүй гэсэн байр суурийг илэрхийлж байсан. Улмаар хэлэлцээрийн явцад Засгийн газар эцсийн

бүтээгдэхүүнд “0” хувийн НӨАТ ногдуулах асуудлаар нэгдсэн бодлогоор бүх уул уухайн компанийд ижил хандсан тохиолдолд НӨАТ төлөхийг зөвшөөрөх боломжтой талаар хөрөнгө оруулагч талтай харилцан сийлголцолд хүрч гэрээний төсөлд тусгалаа.

Олборлолт, үйлдвэрлэл, технологийн чиглэлээр:

- Бүтээгдэхүүнд ураны ислээс гадна бусад дагалдах байгалийн баялаг, ашигт малтмалыг оруулж, АМНАТ тооцох нөхцөлийг бүрдүүлсэн.
- Хөрөнгө оруулалтын тэрээг төсөл хэрэгжүүлэгчийн эзэмшиж байгаа З тусгай зөвшөөрлийн хүрээнд авч үзэх, бусад ирээдүйд авч болох тусгай зөвшөөрлүүдийг хамруулахгүй байхаар тохирсон.
- Үйлдвэрлэлийн нөөцийг бүрэн ашиглаж, үйлдвэрлэлийн хэмжээг батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх, хэт бууруулах, нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг үндэслэлгүйгээр түр зогсоохоос сэргийлэх зохицуулалтыг тусгасан.
- Технологийн үндсэн материал буюу элементийн хүхрийг Монгол Улс дотооддоо үйлдвэрлэсэн тохиолдолд тэргүүн ээлжид худалдан авахаар тохирсон.
- Олборлолт, үйлдвэрлэл нь үндэсний лабораторийн хяналтад байх ба Олон улсын байгууллага (Олон улсын атомын энергийн агентлаг)-аар З жил тутам тогтмол аudit хийлгэх зэрэг асуудлуудыг тохирлоо.

Байгаль орчныг хамгаалах чиглэлээр:

- Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүдийн илэрхийлсэн байр суурь, гаргасан саналыг үндэслэн байгаль орчны салбарын хууль тогтоомжийг тогтвортжуулахгүй бөгөөд тухайн үеийн хууль тогтоомж, олон улсын стандартын дагуу үйл ажиллагаа явуулах нөхцөлийг тусгасан.
- Олон улсын сайн туршлагыг хэрэгжүүлж, байгаль орчны хяналт, мониторингийг гүйцэтгэх;
- Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын стандартын дагуу хангах;
- Усны нөөц, горим, чанарын төлөв байдлын өөрчлөлтөд байнгын ажиглалт, хяналт-шинжилгээ хийж, хяналт тавих;
- Энгийн болон аюултай хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхдээ Хог хаягдлын хуульд заасны дагуу ангилан ялгаж, дахин боловсруулах болон бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Цацраг идэвхт хаягдлыг уурхайн талбайд ангилах, ялгах, боловсруулах, аюулгүй булслах, эдгээр үйл ажиллагаатай холбоотойгоор байгаль орчныг нөхөн сэргээх асуудлыг бүрэн хариуцаж гүйцэтгэх;
- Уурхай, үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлт, хаалтын дараах засвар арчилгаанд зарцуулах мөнгөн хөрөнгийг Цөмийн энергийн тухай хуульд нийцүүлэн тооцож, бүрдүүлэх;
- Мөн байгаль орчныг хамгаалах, цөмийн болон цацрагийн ослоос сэргийлэх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааг Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу байршуулах;
- Гурван жил тутамд төслийн үйл ажиллагаа болон технологидоо Олон улсын атомын энергийн агентлагийн шинжээчдээр хөндлөнгийн аudit хийлгэх;
- Техник, эдийн засгийн үндэслэл, Байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон суурь үзүүлэлтүүдийг ашиглан Төслийн

бүх үе шатанд байгаль орчны мониторинг, геоэкологийн судалгаа, цацрагийн хяналтыг хэрэгжүүлэх;

- Төсөл хэрэгжүүлэгч компани нь байгаль орчин, усны хяналт мониторингийн үйл ажиллагаанд олон нийтийн төлөөллийн оролцоог хангахаар тус тус тохиролцлоо.

Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр:

- Төсөл хэрэгжүүлэгч компани нь Дорноговь аймгийн Засаг дарга, Төсөл хэрэгжих Улаанбадрах сумын Засаг даргатай гурван талт хамтын ажиллагааны гэрээ байгуулж, орон нутгийн хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэхээр тохирлоо.
- Төсөл хэрэгжүүлэгч хамтын ажиллагааны гэрээний хүрээнд Бүтээн байгуулалтын үе шатанд 300,000 ам.доллар, Уурхайн ашиглалтын үе шатанд 1,000,000 ам.доллар, Уурхайн ашиглалтын үе шат дууссанас арван жилийн хугацаанд жил бүр 1,100,000 ам.долларын хөрөнгө оруулалт хийнэ.
- Ажлын байрны сул орон тоо (удирдах албан тушаалыг оролцуулан)-д мэргэжлийн шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг тэргүүн ээлжид ажиллуулна. Ижил үнэлэмж бүхий хөдөлмөрт адил цалин, хөлс, урамшуулалт олгохоор тохирлоо.
- Уурхайн ашиглалтын үе шатанд Төсөл хэрэгжүүлэгч компанийн нийт ажилчдын 90 ба түүнээс дээш хувь нь Монгол Улсын иргэн байна. Төсөл хэрэгжүүлэгч компанийн авч ажиллуулах гадаад ажилтны тоо нийт ажилтны 10 хувиас хэтэрсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гадаад ажилтны ажлын байрны төлбөр төлнө. Бүтээн байгуулалтын үе шатанд Төсөл хэрэгжүүлэгч компанийн нийт ажилчдын хамгийн багадаа 60% нь Монгол Улсын иргэн байхаар тус тус тохирсон.
- Уурхайн ашиглалтын үе шатанд Төсөл хэрэгжүүлэгч компани нь төсөл дээр ажиллаж байгаа нийт Монгол ажилчдын 5 ба түүнээс дээш хувийг Дорноговь аймгийн, болон холбогдох сумын оршин суугч байх шаардлагыг хангаж ажиллана.
- Төсөл хэрэгжүүлэгч компани нь уурхайн ашиглалтын үе шатанд нийт туслан гүйцэтгэгчдийн 60%-аас доошгүй, жилийн нийт худалдан авалтын үнийн дүнгийн 40%-аас доошгүй нь Монгол Улсад бүртгэлтэй, татвар төлөгч хуулийн этгээд байхаар тохирсон.

Гэрээ, эрх зүйн чиглэлээр:

- Хөрөнгө оруулалтын гэрээнд хууль тогтоомжийг тогтвортжуулахгүй бөгөөд зөвхөн хуульд орсон өөрчлөлт нь төслийн компанийн үйл ажиллагаанд сэргэөр нөлөөлөх буюу 5 жилийн хугацаанд хуульд орсон өөрчлөлт нь төсөл хэрэгжүүлэгч компанийн зардлыг 10 хувиар өсгөсөн тохиолдолд талууд хэлэлцээрт орохоор тусгалаа.
- Хөрөнгө оруулагчид гаргаж байгаа баталгаа, хамгаалалтын хүрээнд 1991 онд байгуулсан Монгол Улс, Бүгд Найрамдах Франц Улсын хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээнээс давсан амлалт, баталгааг гэрээнд тусгахгүй байх үл ялгаварлах зарчмыг баримталсан.
- Хөрөнгө оруулалтын гэрээг 20 жилээр байгуулж, гэрээг тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд хуульд заасан хугацаагаар сунгаж байхаар гэрээнд тусгалаа.

- Хөрөнгө оруулагч гэрээнд заасан нөхцөлийн дагуу хөрөнгө оруулалт хийхгүй, төсөл хэрэгжүүлэх үүргээ зөрчсөн тохиолдолд Засгийн газар гэрээг цуцлах эрхтэй байхаар тусгалаа.
- Талуудын хооронд татварын маргаан үүсвэл дотоодын хууль тогтоомжийн дагуу маргаан шийдвэрлэх бүх процессыг дуустал олон улсын арбитрт хандах эрхгүй байхаар тохиролцлоо.

oOo

Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл
2025 оны 1-р сарын 8

**Investment Agreement
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ**

between / хооронд байгуулсан

**The Government of Mongolia
as the Government
Монгол Улсын Засгийн газар
(Засгийн газар)**

and/болон

**Orano Mining S.A.S
as the Investor
Орано Майнинг С.А.С
(Хөрөнгө оруулагч)**

and/болон

**Badrakh Energy LLC
as the Project Company
Бадрах Энержи ХХК
(Төсөл хэрэгжүүлэгч компани)**

ГАРЧИГ

CONTENTS	4
ҮНДЭСЛЭЛ	
1. НЭР ТОМЬЁО БОЛОН ТАЙЛБАР	7
1. DEFINITIONS AND INTERPRETATION	7
2. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	24
2. GENERAL PROVISIONS	24
3. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	26
3. PROJECT OPERATIONS	26
4. ТӨСЛИЙН ШУУД ҮР ӨГӨӨЖ	38
4. DIRECT BENEFITS OF THE PROJECT	38
5. ТАТВАР	47
5. TAXATION	47
6. САНХҮҮГИЙН ГОРИМ	54
6. FINANCIAL REGIME	54
7. ТӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ХУВЬЦАА	57
7. STATE-OWNED SHARES	57
8. БАЙГАЛЬ ОРЧИН, ЭРҮҮЛ АХУЙ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА	61
8. ENVIRONMENT, HEALTH, AND SAFETY	61
9. ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ	72
9. WASTE MANAGEMENT	72
10. УУРХАЙН ХААЛТ БОЛОН ХААЛТЫН ДАРААХ МОНИТОРИНГ, ЗАСВАР АРЧИЛГАА	74
10. MINE CLOSURE, POST-CLOSURE MONITORING AND MAINTENANCE	74
11. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ	78
11. LOCAL DEVELOPMENT	78
12. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, СУРГАЛТ	84
12. EMPLOYMENT AND TRAINING	84
13. АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ	90
13. PREVENTION OF CORRUPTION	90
14. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ ЦУЦЛАХ	97
14. TERMINATION OF THE AGREEMENT	97
15. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС	103
15. FORCE MAJEURE	103
16. МЭДЭГДЭЛ БА БАТАЛГАА	109
16. REPRESENTATIONS AND WARRANTIES	109
17. ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ	112

17. TRANSFER OF RIGHTS	112
18. ҮЙЛЧЛЭХ ХУУЛЬ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ	115
18. GOVERNING LAW AND DISPUTE RESOLUTION	115
19. БУСАД	122
19. MISCELLANEOUS	122
ХАВСРАЛТ 1 / APPENDIX 1.	128
ХАВСРАЛТ 2 / APPENDIX 2	129

<p>Энэхүү Хөрөнгө оруулалтын гэрээг (цаашид "Гэрээ" гэх) 2025 оны [●] өдөр:</p> <p>(1) МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР-аас олгосон зөвшөөрөл, бүрэн эрхийн дагуу Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж МОНГОЛ УЛСЫН ЦӨМНИЙ ЭНЕРГИЙН КОМИСС, хаяг: [●] (цаашид "Засгийн газар" гэх);</p> <p>(2) Бүгд Найрамдах Франц Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, бүртгэлийн 501 493 605 АрСиЭс Нантерре дугаартай, Франц Улс, Шатийон 92320 Авнью де Парис 125 хаягт албан ёсны бүртгэлтэй хуулийн этгээд болох ОРАНО МАЙНИНГ С.А.С (цаашид "Хөрөнгө оруулагч" гэх);</p> <p>(3) Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, регистрийн 5502977 дугаартай, Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамъян гүний гудамж, ICC Tower, 5 давхар хаягт албан ёсны бүртгэлтэй хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БАДРАХ ЭНЕРЖИ ХХК (цаашид "Төсөл хэрэгжүүлэгч компани" гэх)</p> <p>(цаашид Засгийн газар, Хөрөнгө оруулагч болон Төсөл хэрэгжүүлэгч компани (болон тэдгээрийн аливаа эрх залгамжлагч, эрх хүлээн авагч)-ийг хамтад нь "Талууд", тус тусад нь "Тал", гэх), нар нь харилцан тохиролцож Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд байгуулав.</p>	<p>This Investment Agreement (the "Agreement") is dated [●] 2025 and made under the Mongolian Law by and between:</p> <p>(1) THE NUCLEAR ENERGY COMMISSION OF MONGOLIA, for and on behalf of the Government of Mongolia, pursuant to the authorization and authority granted by THE GOVERNMENT OF MONGOLIA, having its address [●] (the "Government")</p> <p>(2) ORANO MINING S.A.S., a legal entity established under the laws of France with registration number 501 493 605 RCS Nanterre, having its registered office located at 125 avenue de Paris 92320 Chatillon France (the "Investor"); and</p> <p>(3) BADRAKH ENERGY LLC, a limited liability company established under the laws of Mongolia with registration number 5502977, having its registered office located at 5th Floor, ICC Tower, Jamyan Gunii Street, Khoroo 1, Sukhbaatar District, Ulaanbaatar, Mongolia (the "Project Company")</p> <p>The Government, the Investor and the Project Company (and their respective successor and assigns, if any) shall together be referred to as the "Parties" and individually as a "Party".</p>
<p>ҮНДЭСЛЭЛ</p> <p>Дор дурдсан зүйлсийг харгалзан үзсэний үндсэн дээр Талууд энэхүү Гэрээг байгуулсан болно:</p>	<p>PREAMBLE</p> <p>The Parties enter into this Agreement having regard to the following:</p>
<p>(A) Хөрөнгө оруулагч болон түүний Хамаарал бүхий этгээдүүд нь Монгол Улсад 20 (хорь) гаруй жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулж, Төсөл хэрэгжүүлэгч компанийар дамжуулан ашигт малтмалын хайгуулын ажилд болон Төсөлд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн.</p>	<p>(A) The Investor and its Affiliates have been present in Mongolia for more than 20 (twenty) years and have invested a significant amount of capital in the exploration of mineral resources and in the Project through the Project Company.</p>

(B)	Төсөл хэрэгжүүлэгч компани нь дараах нэр бүхий хоёр ордод гурван ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг болно.Үүнд: Дулаан Уул ордод (i) MV-018916 дугаартай "Дулаан-Уул", (ii) MV-018914 дугаартай "Өмнөт", Зөөвч-Овоо ордод (iii) MV-018915 дугаартай "Зөөвч-Овоо" нэртэй тусгай зөвшөөрлийг тус тус эзэмшдэг.	(B)	The Project Company holds three mining licenses for two deposits named: For the Dulaan-Uul deposit (i) MV-018916 named "Dulaan-Uul" , and (ii) MV-018914 named "Umnut", and as for the Zuuvch-Owoo deposit (iii) MV-018915 named "Zuuvch-Owoo", respectively.
(C)	2016 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны газар болон Төсөл хэрэгжүүлэгч компани (өмнө нь APEVA Майнс ХХК нэртэй байсан бөгөөд Орд ашиглах Гэрээнд "Орд ашиглагч" тал гэж заасан)-ийн хооронд Орд ашиглах гэрээ байгуулагдсан.	(C)	The Deposit Development Agreement was executed between the Mineral Resources and Petroleum Authority of Mongolia and the Project Company (formerly known as AREVA Mines LLC and referred to as the "Deposit Developer" in the Deposit Development Agreement) on 15 September , 2016.
(D)	Орд ашиглах гэрээ болон тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулсан Хувьцаа эзэмшигчдийн гэрээний дагуу Засгийн газар (Мон-Атом ХХК болон Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны газраар тус тус дамжуулан) болон Төсөл хэрэгжүүлэгч компани нар Төслийн хэрэгжилтийг дэмжих үүднээс хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахаар тохиролцсон.	(D)	Under the Deposit Development Agreement and the Shareholders' Agreement, as amended from time to time, the Government (acting through Mon-Atom LLC and the Mineral Resources and Petroleum Authority of Mongolia) and the Project Company committed to enter into an investment agreement to support the implementation of the Project.
(E)	2023 оны 10 дугаар сарын 12-ний өдөр энэхүү Гэрээний зарим үндсэн нөхцөлүүд болон энэ Гэрээг байгуулах цаг хугацааг тусгасан Монгол Улсын Засгийн Газар болон Орано Майнинг С.А.С хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулах Ажлын хэсгийн хэлэлцээний протоколыг Бүгд Найрамдах Франц Улсын нийслэл Парис хотод үйлдсэн ("Протокол").	(E)	On 12 October 2023, a Negotiation Protocol of the Working Group for Drafting an Investment Agreement between the Government of Mongolia and Orano Mining SAS was executed in Paris, France setting out certain key terms of this Agreement and the timeframe for entering into the Agreement ("Protocol").

(F)	Монгол Улсын Их Хурал [●] оны [●] сарын [●]-ний өдрийн [●] тоот тогтоолоор Төсөл хэрэгжүүлэгч компани дахь төрийн эзэмшлийн 34 хувийн хувьцааг Хавсралт 1-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон 10 хувийн төрийн эзэмшлийн давуу зөрхийн хувьцаанд хөрвүүлж, орлуулахаар шийдвэр гаргасан. Энэхүү Гэрээг Монгол Улсын Үндсэн хуульд заасан шаардлагуудыг харгалzan байгуулсан болохыг Талууд хүлээн зөвшөөрч байна.	(F)	The Parliament of Mongolia, through Resolution No. [●] dated [●], approved to convert and replace the State owned 34%(thirty-four percent) shares in the Project Company into special royalties set forth in Annexure 1 and 10% state owned preferred shares in the Project Company. The Parties agree that this Agreement is made taking into consideration the requirements of the Constitution of Mongolia.
(G)	Орд ашиглах гэрээнд заасанчлан Төсөл хэрэгжүүлэгч компани нь 2022 оны сүүлээр 10 (арав) тонн ураны исэл олборлох, боловсруулах туршилтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн. Хуульд заасан хяналт, шалгалтуудаас гадна туршилтын төсөл нь туршилтын үйл ажиллагааг эхлэхээс өмнө болон дараа Монгол Улсын Шинжлэх ухааны академи, мөн Олон улсын атомын энергийн агентлагийн (цаашид "ОУАЭА" гэх) шинжээчдийн 2022 оны тавдугаар сард хийсэн Уран боловсруулах аюулгүй ажиллагааны үнэлгээний багийн (УБАҮБ) айлчлалын хүрээнд ОУАЭА-ийн бие даасан аудит, хяналт шалгалтад хамрагдсан.	(G)	In accordance with the requirements of the Deposit Development Agreement, the Project Company successfully completed a pilot operation by the end of 2022, which involved the extraction and processing of 10 (ten) tons of uranium oxide. In addition to statutory controls and audits, the pilot project was subject to independent audits and inspections by the Academy of Sciences of Mongolia both before and after the completion of pilot operations, and by the International Atomic Energy Agency ("IAEA") as part of a Uranium Production Safety Assessment Team (UPSAT) mission conducted by IAEA experts in May 2022.
(H)	Цөмийн Энергийн Комисс нь Засгийн газрын [●] өдрийн [●] тоот тогтоолын дагуу энэхүү Гэрээнд гарын үсэг зурах эрхтэй.	(H)	The Nuclear Energy Commission has been duly authorized to execute this Agreement in accordance with resolution [●] of the Cabinet, dated [●].
(I)	Монгол Улс нь ураны зах зээлийн гол тоглогчдын нэг болж, олон улсад нүүрсхүчлийн хий (CO_2) ялгаруулдаггүй эрчим хүчиний эх үүсвэрийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулахыг эрмэлзэж буй болно.	(I)	Mongolia intends to become a significant player in the uranium market and contribute to the global development of a CO_2 free source of electricity.
(J)	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 1 дүгээр Хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан 14 мега төслийн нэг болох Монгол, Францын хамтарсан Ураны төслийг хэрэгжүүлэхээр тусгасан.	(J)	The Government of Mongolia Action Program for 2024-2028, approved by Annex 1 of Resolution No. 21 of the State Great Khural of Mongolia dated August 27, 2024, includes provisions for the implementation of the Mongolia-France joint uranium project, which is one of the 14 mega projects.

(К) Энэхүү Гэрээ нь нийтэд нээлттэй байна.	(К) This Agreement shall be made public.
Иймд Төсөл хэрэгжүүлэх болон Бүтээгдэхүүн борлуулахад ил тод, тогтвортой эрх зүйн болон татварын орчинтой холбогдуулан харилцан эдлэх эрх, хүлээх үүргээ тогтоох зорилгоор Талууд заавал биелүүлэх, хуулийн хүчин төгөлдөр хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах хүсэлтэй байна.	Now, therefore, the Parties wish to enter into a legally binding and fully effective investment agreement to confirm the rights and obligations of the Parties, including in relation to a transparent and stable legal and tax environment to implement the Project and sell the Products.
1. НЭР ТОМЬЁО БОЛОН ТАЙЛБАР 1.1 Тодорхойлсон нэр томьёо ба түүний тайлбар Энэхүү гэрээнд тусгагдсан нэр томьёо нь дараах утгыг илэрхийлнэ: “Бүтээн байгуулалтын үе шат” гэдэгт энэ Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс эхэлж, дараалсан 60 (жар) хоногийн хугацаанд үйлдвэрлэлийн туршилт, тохируулгын зорилгоор үйлдвэрлэл явуулж, улсын комисс хүлээн авсан өдрөөр дуусгавар болно.	1. DEFINITIONS AND INTERPRETATION 1.1 Definitions and its interpretation The terms used in this Agreement shall have the following meanings: “Construction Phase” shall commence on the Effective Date of this Agreement and conclude upon completion of 60 (sixty) consecutive days production for testing and adjustments purposes followed by state commission official acceptance.
“Хамаарал бүхий этгээд” гэж аль нэг Талын хувьд тухайн Талыг шууд болон шууд бусаар Хянадаг, эсхүл тухайн Тал нь өөрөө шууд болон шууд бусаар Хянагддаг, эсхүл тухайн Талын хамт нэгдсэн Хяналт дор байдаг аливаа компани, нехөрлөл, корпорац, холбоо болон бусад хуулийн этгээдийг хэлэх бөгөөд тухайн Талын охин компани эсхүл толгой компани мөн хамаарна.	“Affiliate” means, in relation to a Party, a company, partnership, corporation, association, or other legal entity, including the Party's subsidiaries or parent companies, that directly or indirectly Controls, or is Controlled by, or is under common Control with, a Party.
“Хянах” болон “Хяналт” гэдэгт тухайн хуулийн этгээдийн саналын эрхийн 50 (тавь) болон түүнээс дээш хувийг шууд, эсхүл нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдээр дамжуулан шууд бусаар эзэмшихийг ойлгоно. Хөрөнгө Оруулагч болон Төсөл хэрэгжүүлэгч компанийн Хамаарал бүхий этгээдэд дараах хуулийн этгээдүүдийг тооцох ба үүгээр хязгаарлагдахгүй:	“Control” means the direct or indirect ownership of at least 50% (fifty percent) of the voting capital of such legal entity, whether through a single entity or through one or more legal entities in the continuous chains. The following legal entities are considered Affiliates of the Investor and the Project Company, including but not limited to:

<p>(a) Орано С.А;</p> <p>(b) Орана Майнинг Экспаншн С.А.С;</p> <p>(c) Компани Францез Дэ Мин Э Мэто;</p> <p>(d) Арева Монгол ХХК; болон</p> <p>(e) Кожеговь ХХК.</p> <p>Татварын зорилгоор харилцан хамааралтай этгээдийг тогтооход энэ заалт хамаарахгүй бөгөөд Монгол Улсад хучин төгөлдөр үйлчилж буй татварын хууль тогтоомжийг баримтална.</p>	<p>(a) Orano S.A.;</p> <p>(b) Orano Mining Expansion S.A.S;</p> <p>(c) Compagnie Francaise De Mines Et Metaux;</p> <p>(d) Areva Mongol LLC; and</p> <p>(e) Cogegobi LLC.</p> <p>This provision shall not be used to determine related parties for tax purposes, and the tax laws in force in Mongolia shall apply for this purpose.</p>
"Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль" гэж 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан Нягтлан бodoх бүртгэлийн тухай Монгол Улсын хууль, түүнд орсон болон цаашид орох аливаа нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг хэлнэ.	"Accounting Law" means the Law of Mongolia on Accounting, enacted on 19 June 2015, together with any amendments or revisions from time to time.
"ОУИТБС" гэдэгт Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгыг ойлгоно.	"EITI" means Extractive Industries Transparency Initiative.
"Хувьцаа эзэмшигчдийн гэрээ" гэдэгт 2013 оны 10 дугаар сарын 6-ны өдөр "Арева Монгол" ХХК болон "Мон-Атом" ХХК-ийн хооронд байгуулж, тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулсан гэрээг хэлнэ.	"Shareholders Agreement" means the agreement entered into between "Areva Mongolia" LLC and "Mon-Atom" LLC on 6 October 2013, as amended from time to time.
"Бодит үнэ тодорхойлох зарчим" гэдэгт Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д заасныг, түүнд орсон аливаа нэмэлт, өөрчлөлтийг ойлгоно.	"Arm's length principle" has the meaning set forth in Section 6.1.6, Article 6 of the General Tax Law, together with any amendments or revisions from time to time.
"Хувьцаа эзэмшигчийн зээл" гэдэгт энэ Гэрээ хучин төгөлдөр болох өдрөөс өмнө Төсөл хэрэлжүүлэгч компанийн нягтлан бodoх бүртгэлд хуримтлагдсан өр гэж бүртгэгдсэн, Хөрөнгө оруулагчаас Төсөл хэрэлжүүлэгч компанид олгосон бүх зээлийг ойлгоно.	"Shareholder Loan" means all loans granted by the Investor to the Project Company and recorded as accrued debt in the Project Company's accounting records prior to the Effective Date.
"Нууц мэдээлэл" гэдэгт энэхүү Гэрээний 13.4(b)-д заасныг ойлгоно.	"Confidential Information" has the meaning set forth in Clause 13.4(b) of this Agreement.

<p>“Хаалтын дараах хяналт, мониторинг, засвар арчилгаа” гэж Уурхайн хаалтын дараах нөхөн сэргээлт хийсэн талбайг урт хугацааны туршид хянаж, засвар арчилгааг хийхэд шаардлагатай бүх ажиллагааг хэлнэ. Үүнд газрын доорх усны хяналт, шинжилгээ, мониторинг, цацраг идэвхт хаягдлын гадаргуу орчмын булшлалтын нөхцөл байдлыг үнэлэх, түүний хүн ам, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тогтмол давтамжтай хянах, арчлах үйл ажиллагааг мөн хамруулах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.</p>	<p>“Post-Closure Control, Monitoring and Maintenance” refers to all actions necessary for the long-term monitoring, surveillance and maintenance of a reclamation site following Mine Closure. This includes, but is not limited to, controlling, testing, monitoring groundwater and assessing the condition of near-surface disposal of radioactive waste, and the regular monitoring, surveillance and maintenance of its impact on the population and the environment.</p>
<p>“Хөрөнгө оруулалт” гэдэгт Гэрээний 3.1(а)-д заасныг ойлгоно.</p>	<p>“Investment” has the meaning set forth in Clause 3.1(a) of this Agreement.</p>
<p>“Уурхай” гэж Төсөл хэрэгжүүлэгч компанийн ашиглах, бүтээн байгуулалт хийх болон үйл ажиллагаа явуулахаар шийдвэрлэсэн Уурхайн талбайг буюу Бүтээгдэхүүнийг олборлох, боловсруулахад шаардлагатай барилга байгууламжууд болон Уурхайн ашиглалтын үе шатыг хэрэгжүүлэхэд шаардлагатай байгууламж болон бусад дэд бүтэц хамаарна.</p>	<p>“Mine” means the Mine Area decided to be used, developed, and operated by the Project Company, the buildings and structures necessary for the extraction and processing of the Product, and the facilities and other infrastructure necessary for the implementation of the Mining Operation Phase.</p>
<p>“Уурхайн ашиглалтын үе шат” гэдэгт Бүтээн байгуулалтын үе шатны дараагийн үе шатыг хэлэх бөгөөд энэ үе шат нь улсын комисс уурхайг байнгын ашиглалтад авсан өдрөөс эхлэн Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн үе шат хүртэлх хугацааг хэлнэ.</p>	<p>“Mining Operation Phase” means the phase that follows the Construction Phase, which starts from the date the state commission officially commissions the Mine into permanent operation and continues until the commencement of the Mine Closure and Rehabilitation Phase.</p>

“Монгол Улсын Үндсэн хууль” гэж 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хууль, түүнд орсон болон цаашид орох аливаа нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг хэлнэ.	“Constitution of Mongolia” means the Constitution of Mongolia enacted on 13 January 1992, together with any amendments or revisions from time to time.
“Хамтын ажиллагааны гэрээ” гэж энэ Гэрээний 11.1(а)-д заасныг ойлгоно.	“Cooperation Agreement” has the meaning set forth in Clause 11.1(a) of this Agreement.
“Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль” гэж 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай Монгол Улсын хууль, түүнд орсон болон цаашид орох аливаа нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг хэлнэ.	“Corporate Income Tax Law” means the Law of Mongolia on Corporate Income Tax enacted on 22 March 2019, together with any amendments or revisions from time to time.
“Орд” эсхүл “Ордууд” гэдэгт Тусгай зөвшөөрлүүдээр олгогдсон талбайд хийгдсэн хайгуулын ажлын үр дүнд тогтоосон нөөцийг хэлнэ.	“Deposit” or “Deposits” mean the reserves determined as a result of exploration work carried out in the area granted under the Licenses.
“Орд ашиглах гэрээ” гэж Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны газар болон Төсөл хэрэгжүүлэгч компани (өмнө нь AREVA Майнс ХХК оноосон нэртэй байсан бөгөөд орд ашиглах гэрээнд “Орд ашиглагч” тал гэж заасан) нарын хооронд 2016 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр байгуулж, энэ Гэрээг байгуулагдсан өдөр эсхүл түүнтэй ойролцоо өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан орд ашиглах гэрээ, түүнд тухай бүр оруулсан нэмэлт, өөрчлөлт, эсхүл шинэчлэн байгуулсан гэрээг хэлнэ.	“Deposit Development Agreement” means the Deposit Development Agreement entered into between the Mineral Resources and Petroleum Authority of Mongolia and the Project Company (formerly known as AREVA Mines LLC and referred to in the Deposit Development Agreement as the “Deposit Development Party”) on 15 September 2016, as amended or modified on or about the date of this Agreement, and as amended or modified or newly entered into from time to time.
“Маргаан” гэдэгт Гэрээний 18.2(а)-д тодорхойлсон утгыг ойлгоно.	“Dispute” has the meaning set forth in Clause 18.2(a) of this Agreement .
“Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр” гэдэгт Гэрээний 19.1(д)-д заасныг ойлгоно.	“Effective Date ” means the date set forth in Clause 19.1(d).
“Байгаль орчны нэлөөллийн үнэлгээ” гэдэгт Байгаль орчны нэлөөллийн ерөнхий үнэлгээ, Байгаль орчны нэлөөллийн нарийвчилсан үнэлгээг ойлгоно.	“Environmental Impact Assessment” means the General Environmental Impact Assessment and the Detailed Environmental Impact Assessment.
“Байгаль орчны нэлөөллийн ерөнхий үнэлгээ” гэдэгт Байгаль орчинд нэлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасан шаардлага, журмын дагуу боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулсан баримт бичгийг хэлнэ.	“General Environmental Impact Assessment” means a document prepared in accordance with the requirements and procedures specified in the Environmental Impact Assessment Law and approved by a competent authority.

<p>“Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ” гэдэгт Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасан шаардлага, журмын дагуу боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулсан баримт бичгийг хэлнэ.</p>	<p>Detailed Environmental Impact Assessment means a document prepared in accordance with the requirements and procedures specified in the Environmental Impact Assessment Law and approved by a competent authority.</p>
<p>“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль” гэдэгт 2012 оны оны 5 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, түүнд орсон болон цаашид орох аливаа нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг хэлнэ.</p>	<p>“Environmental Impact Assessment Law” means the Law of Mongolia on Environmental Impact Assessment, enacted on 17 May 2012, and any amendments and revisions from time to time.</p>
<p>“Цацрагийн хамгаалалтын хөтөлбөр” гэж уурхайн ашиглалт, хаалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг байгаль орчин, хүн ам болон ажилтнуудыг аливаа сөрөг нөлөө, цацрагийн осол болон эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах, цацрагийн хэмжилт, мониторинг хийх зэрэг арга хэмжээг төлөвлөж, хүн, мал, амьтны эрүүл мэнд, агаар, ус, хөрс, ургамлыг хамгаалах арга хэмжээнүүд, холбогдох хууль тогтоомж, үндэсний болон Олон улсын стандарт, дүрэм, ОУАЭА-аас гаргасан дүрэм, зөвлөмжийн дагуу шаардсан бусад асуудлыг тусгасан баримт бичгийг хэлнэ.</p>	<p>“Radiation Protection Program” means a document that reflects the measures to ensure that mine operation, closure, and rehabilitation activities are carried out so as to prevent any negative impact, radiation accident or risks to the environment, public, and workers, to ensure radiation protection and safety, radiation measurement and monitoring, and to protect human, livestock and animal health, and air, water, soil, and plants, and other matters required by applicable laws, national and International Standards and regulations, and guidelines and recommendations issued by the IAEA.</p>
<p>“Байгаль орчны менежментийн төлөвлөгөө” гэдэгт Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасан шаардлага, журам, болон ОУАЭА-аас гаргасан дүрэм, зөвлөмж, стандартын дагуу боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулсан баримт бичгийг хэлнэ.</p>	<p>“Environmental Management Plan” means a document prepared in accordance with the requirements and procedures specified in the Environmental Impact Assessment Law, as well as the guidelines, recommendations, and standards issued by the IAEA and approved by a competent authority.</p>
<p>“Зөвшөөрөл” гэдэгт Зөвшөөрлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.1-д тодорхойлсон утгаар ойлгоно.</p>	<p>“Permit” has the meaning defined in Section 1.1 of Article 1.4 of the Permit Law.</p>
<p>“Зөвшөөрлийн тухай хууль” гэдэгт 2022 оны 6-р сарын 17-ны өдөр батлагдсан Зөвшөөрлийн тухай Монгол Улсын хууль, түүнд орсон болон цаашид орох аливаа нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг хэлнэ.</p>	<p>“Permit Law” means the Law of Mongolia on Permits enacted on 17 June 2022, together with any amendments or revisions from time to time.</p>

<p>"Техник, эдийн засгийн үндэслэл" гэж Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 074 дугаар тушаал болон тухай бүр шинэчилсэн хувилбарт болон бусад баримт бичигт тодорхойлсны дагуу Улсын бүртгэлд бүртгэгдсэн нөөцийн эдийн засгийн хэсэгт тулгуурлан ашигт малтмалыг олборлох, боловсруулах төслийг хэрэгжүүлэхэд чиглэсэн техник технологийн сонголт, инженерийн шийдэл, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хүний нөөц, удирдлага зохион байгуулалт, дэд бүтэц, хангамж, нийгэм, ахуй үйлчилгээ, эдийн засгийн үр ашгийн тооцоо болон холбогдох бусад хүчин зүйлийг нарийвчлан тооцсон зураг, тооцоолол, тайлбар бүхий техникийн цогц баримт бичиг, түүний тодотголыг хэлнэ.</p>	<p>"Feasibility Study" means a comprehensive technical document and its revisions with detailed drawings, estimation, and explanation of technical and technological options, engineering solutions, environment, labor safety, hygiene, human resources, management and organization, infrastructure, supply, social and utility services, estimation of social and economic efficiency viability and other relevant factors, aimed at the implementation of mineral extraction and processing projects based on the economic part of the resources registered in the state register in accordance with Decree No. 074 of the Minister of Mineral Resources and Energy of 2012, its revisions made from time to time, and other documents.</p>
<p>"Давагдашгүй хүчин зүйл" гэдэгт энэ Гэрээний 15.1(а)-д тодорхойлсон үйл явдлыг ойлгоно.</p>	<p>"Force Majeure Event(s)" means the events defined in Clause 15.1(a) of this Agreement.</p>
<p>"Татварын ерөнхий хууль" гэж 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан Монгол Улсын Татварын ерөнхий хууль, түүнд орсон болон цаашид орох аливаа нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг хэлнэ.</p>	<p>"General Tax Law" means the General Law on Taxation of Mongolia enacted on 22 March 2019, together with any amendments or revisions from time to time.</p>
<p>"Тогтвортжуулах хугацаа" гэдэгт Гэрээний 5.3-д заасан хугацааг ойлгоно.</p>	<p>"Stabilization Period" means the period specified in Clause 5.3 of this Agreement.</p>
<p>"ОУАЭА" гэж Олон Улсын Атомын Энергийн Агентлагийг хэлнэ.</p>	<p>"IAEA" means the International Atomic Energy Agency.</p>
<p>"Олон улсын аудит" гэдэгт Гэрээний 8.5(а)-д заасныг ойлгоно.</p>	<p>"International Audit" has the meaning set forth in Clause 8.5(a) of this Agreement.</p>
<p>"Газрын доор уусган олборлох арга" эсхүл "ГДУО арга" гэж Бүтээгдэхүүнийг газрын гүнд хүдрээс уусмалд уусган, уг уусмалыг гадаргад гарган ирж, боловсруулан Бүтээгдэхүүнийг олборлох аргыг хэлнэ.</p>	<p>"In-Situ Recovery Method" or "ISR Method" means the method of extracting products by leaching ore underground into a solution, retrieving that solution to the surface, and processing it to extract the Product.</p>
<p>"Өгөөж тохируулах төлбөр" гэдэгт Гэрээний 4.1(b)-д заасныг ойлгоно.</p>	<p>"Benefit Adjustment Payment" has the meaning set forth in Clause 4.1(b) of this Agreement.</p>

<p>"Уул уурхай, металын олон улсын зөвлөлөөс гаргасан зарчим, зөвлөмж" гэж Уул уурхай, металын олон улсын зөвлөл (англиар "International Council on Mining and Metals" (ICMM))-еес Гарын үсэг зурсан өдрийн байдлаар гаргасан болон цаашид нэмж гаргах зарчим, зөвлөмж агуулсан аливаа баримт бичгийг хэлнэ.</p>	<p>"Principles and Guidelines Issued by the International Council on Mining and Metals" means any document that contains principles and recommendations issued by the International Council on Mining and Metals (ICMM) at the Date of Signature and any principles and recommendations that may be issued subsequently.</p>
<p>"Хөрөнгө оруулалтын тухай хууль" гэж 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдөр батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хууль, түүнд орсон болон цаашид орох аливаа нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг хэлнэ.</p>	<p>"Investment Law" means the Law of Mongolia on Investment enacted on 3 October 2013, together with any amendments or revisions from time to time.</p>
<p>"Ноу-Хауны төлбөр" гэдэгт хайгуул, олборлолтын арга, аргачлал, туршлага, Олон улсын стандарт, эрүүл мэнд, аюулгүй байдал болон байгаль орчны (HSE)-ийн удирдлагын тогтолцоо, компанийн нийгмийн хариуцлагын шилдэг туршлага, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналт, комплайнс болон аудитын журам зэрэг төрөл бүрийн хүрээ/салбарт хөгжүүлэх, хэрэгжүүлэх, тасралтгүй сайжруулах зорилгоор Хөрөнгө оруулагч болон Хамаарал бүхий этгээдийн зүгээс Төсөл хэрэгжүүлэгч компанид ноу-хау хуваалцсаны хариуд нэхэмжлэх ноу-хауны төлбөр, шимтгэлийг ойлгоно. Техник, эдийн засгийн үндэслэл, санхүүгийн шууд өгөөж тооцох гэх мэт татварын бус зорилгоор Ноу-Хауны төлбөрийг жилийн нийт үйл ажиллагааны зардал (OPEX) болон жилийн нийт хөрөнгийн зардлын (CAPEX) дөрвөн (4) хувиар тооцож хэрэглэнэ.</p>	<p>"Know-How Fee" means the know-how fee to be paid by the Project Company to the Investor in return for the assistance provided by the Investor and Affiliates to the Project Company in terms of development, implementation and continuous improvement for various fields such as exploration, mining methods, procedures, practices and International Standards, HSE management systems, corporate social responsibility good practices, accounting, internal control, compliance and audit procedures. The corresponding annual fee equal to 4% (four percent) of total annual operating expenses (OPEX) and total annual capital expenditures (CAPEX) shall constitute the Know-How Fee for non-tax purposes such as the Feasibility Study and the calculation of the economic direct benefit.</p>
<p>"Төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаа" гэж Гэрээний 7.1(b)-д тодорхойлсныг ойлгоно.</p>	<p>"State-Owned Preferred Shares" has the meaning set forth in Clause 7.1(b) of this Agreement.</p>

<p>"Тусгай зөвшөөрөл" эсхүл "Тусгай Зөвшөөрлүүд" гэдэгт Ашигт малтмал, газрын тосны газраас 2015 оны 6-р сарын 12-ны өдөр олгосон, Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутаг дэвсгэрт байрлах Хавсралт 2-д тусгасан талбай бүхий, цацраг идэвхт ашигт малтмал ашиглах дараах тусгай зөвшөөрлүүдийг ойлгоно:</p> <ul style="list-style-type: none"> (a) MV-018916 тусгай зөвшөөрлийн дугаартай Дулаан-Уул; (b) MV-018915 тусгай зөвшөөрлийн дугаартай Зөөвч-Овоо; болон (c) MV-018914 тусгай зөвшөөрлийн дугаартай Өмнөт. 	<p>"License" or "Licenses" means the following licenses for the use of radioactive mineral resources granted by the Mineral Resources and Petroleum Authority on 12 June 2015, pertaining to the areas specified in Appendix 2 located in the Ulaanbadrakh soum, Dornogovi aimag:</p> <ul style="list-style-type: none"> (a) License number MV-018916 for Dulaan-Uul; (b) License number MV-018915 for Zuuvch-Ovoo; and (c) License number MV-018914 for Umnut.
<p>"Маркетингийн төлбөр" гэж Ураны исплийн (U_3O_8) олон улсын спот зах зээлийн үнэ буюу Бүтээгдэхүүнийн борлуулалт хийхээс өмнөх зургаан (6) долоо хоногийн UxC болон Tradetech-ийн долоо хоног бурийн индексүүдийн дундаж үнийн хоёр (2) хувь байна. Энэхүү төлбөр нь зах зээлийн богино хугацааны савлагааг нөхөх, хувьцаа эзэмшигчдийн худалдан авагчийн хувиар авсан Бүтээгдэхүүнийг цааш борлуулах нехцөлийг бий болгох зорилготой.</p>	<p>"Marketing Fee" means two (2) percent of the international spot market price for uranium oxide (U_3O_8) being the average of the weekly indices of UxC and Tradetech during the previous six (6) weeks preceding the sale of the Product. This fee is intended to compensate for short-term market fluctuations, and to enable the shareholders, as buyers, to resell the Product on the market.</p>
<p>"Монгол Улсын хууль тогтоомж" гэдэгт дараахыг ойлгоно:</p> <ul style="list-style-type: none"> (a) Монгол Улсын хууль тогтоомж: Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол; (b) Дүрэм журам: Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, сайдын тушаал, засаг даргын захирамж, орон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэр, акт, хэм хэмжээ, бусад дүрэм журмыг; болон (c) Олон улсын гэрээ: 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т тодорхойлсон Монгол Улсын нэг тал нь болж байгуулсан олон улсын гэрээнүүдийг ойлгоно. 	<p>"Mongolian Law" mean the following:</p> <ul style="list-style-type: none"> (a) Mongolian Laws: laws of Mongolia and parliamentary resolutions. (b) Regulations: presidential decrees, governmental resolutions, ministerial orders, governor's ordinances, and resolutions, acts and norms and rules issued by the local government and other national or local regulations and rules; and (c) International Treaties: the international treaties to which Mongolia is a party, as defined in Article 3.1.1 of the Law of Mongolia on International Treaties enacted on 1 December 2016.

"Ашигт малтмалын тухай хууль" гэж 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай Монгол Улсын хууль, түүнд орсон болон цаашид орох аливаа нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг хэлнэ.	"Minerals Law" means the Law of Mongolia on Minerals enacted on 8 July 2006, together with any amendments or revisions from time to time.
"Уурхайн ашиглалтын үйл ажиллагаа" Тесэл хэрэгжүүлэгч компани өөрөө эсхүл түүний нэрийн өмнөөс Уурхайн ашиглалтын үйл ажиллагааны үе шатанд авч хэрэгжүүлэх Бүтээгдэхүүнийг олборлох, боловсруулах, тээвэрлэх болон борлуулахад шаардлагатай бүхий л үйл ажиллагааг ойлгоно.	"Mining Operations" means all activities carried out by or on behalf of the Project Company during the Mining Operations Phase and necessary to extract, process, transport and sell the Products.
"Уурхайн талбай" гэж Тусгай зөвшөөрлүүдээр олгогдсон, Хавсралт 2-д харуулсан талбайг хэлнэ.	"Mine Area" means the area granted under the Licenses, as shown in Appendix 2.
"Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн үе шат" гэдгийг Гэрээний 10.1-д зохицуулсны дагуу ойлгоно.	"Mine Closure and Rehabilitation Phase" has the meaning set forth in Clause 10.1 of this Agreement.
"Уурхайн хаалтын төлөвлөгөө" гэж холбогдох хууль, дүрэм журам, Олон улсын стандартад заасан шаардлага, нөхцөлийн дагуу үйлдвэрлэлийн нөөцийн ашиглалт, хог хаягдал, барилга байгууламжийн татан буулгалт, байгаль орчны хяналт мониторинг, хаалт, нөхөн сэргээлтэд шаардлагатай хийгдэх үйл ажиллагаа, хэрэгжүүлэх зардлыг тусган Гэрээний 10.1(d)-д заасны дагуу боловсруулж, төрийн эрх бүхий байгууллагаар тухай бүр хянуулж, батлуулсан баримт бичгийг хэлнэ.	"Mine Closure Plan" means the document reflecting the activities and implementation costs necessary for the utilization of production resources, waste disposal, decommissioning of structures, environmental monitoring, closure, and rehabilitation prepared in accordance with the requirements and conditions stipulated by relevant laws, rules, regulations, and International Standards and reviewed and approved by the relevant State Authority in accordance with Clause 10.1(d) of this Agreement.
"төгрөг" гэж Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн товчлолыг хэлнэ.	"MNT" means the abbreviation for the national currency of Mongolia, the tugrik.
"Цөмийн энергийн тухай хууль" гэж 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан Цөмийн энергийн тухай Монгол Улсын хууль, түүнд орсон болон цаашид орох аливаа нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг хэлнэ.	"Nuclear Energy Law" means the Law of Mongolia on Nuclear Energy enacted on 16 July 2009, together with any amendments or revisions from time to time.
"Цөмийн энергийн комисс" гэж Цөмийн энергийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасан Монгол Улсын төрийн байгууллагыг хэлнэ.	"Nuclear Energy Commission" means the governmental organization of Mongolia defined in Article 10.1 of the Nuclear Energy Law.

<p>“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль” гэж 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай Монгол Улсын хууль, түүнд орсон болон цаашид орох аливаа нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг хэлнэ.</p>	<p>“Labor Safety and Hygiene Law” means the Law of Mongolia on Labor Safety and Hygiene enacted on 22 May 2008, together with any amendments or revisions from time to time..</p>
<p>“Бүтээгдэхүүн” гэж Ордуудаас олборлосон ураны исэл буюу шар нунтаг (U_3O_8), болон бусад дагалдах байгалийн баялаг, ашигт малтмалыг хэлнэ.</p>	<p>“Product” means uranium oxide (U_3O_8) or yellow cake and any co-located natural resources and minerals extracted from the Mine Area.</p>
<p>“Үйлдвэрлэлийн төлөвлөгөө” гэж Техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдсан Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх хуваарийг хэлнэ.</p>	<p>“Production Plan” means the production schedule for the Product contained in the Feasibility Study.</p>
<p>“Төсөл” гэдэгт:</p> <ul style="list-style-type: none"> (a) Монгол Улсын Дорноговь аймаг дахь Уурхай; (b) Уурхайн талбайд Бүтээгдэхүүнийг газрын доор уусган олборлох үйл ажиллагаа; (c) үйл ажиллагаанд ашиглаж буй болон Уурхайн талбайд байгаа бүх зам, эрчим хүч үйлдвэрлэх байгууламж, цахилгаан дамжуулах шугам, боловсруулах байгууламж болон холбогдох бусад дэд бүтэц; болон (d) Уурхайн талбай болон бусад газар явагдаж буй холбогдох судалгаа шинжилгээ, туршилт, нөхөн сэргээлт, маркетинг, борлуулалт, орон нутгийн хамтын ажиллагаа зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүтэц, үйл ажиллагааг ойлгоно. 	<p>“Project” means:</p> <ul style="list-style-type: none"> (a) Mine in Dornogovi aimag of Mongolia; (b) The activity of extracting Products using the in-situ leaching method within the Mine Area; (c) all roads, power generation facilities, transmission lines, processing facilities and any other infrastructure used in the operations and located within the Mine Area; and (d) the organizational structure and operations for conducting research, testing, rehabilitation, marketing, sales, and local cooperation activities within the Mine Area and other locations.
<p>“Гэрээний хугацааг сунгах хүсэлт” гэдэгт Гэрээний 2.3(а)-д тодорхойлсныг ойлгоно.</p>	<p>“Request for Extension” has the meaning set forth in Clause 2.3(a) of this Agreement.</p>
<p>“Төлөвлөгөөт зогсолт” гэж Төсөл хэрэгжүүлэгч компанийн зүгээс Олон улсын стандартын дагуу өрдийн үйл ажиллагааны явцад засвар үйлчилгээ хийх, тоног төхөөрөмж солих эсхүл шалгалт хийх зэрэг зорилгоор үйлдвэрлэлийг зогсоохыг хэлнэ.</p>	<p>“Routine Shutdown” means a shutdown of production by the Project Company in the ordinary course of business in accordance with International Standards for purposes including maintenance, repair, equipment replacement or inspection.</p>

“Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр” гэж Цөмийн энергийн тухай Монгол Улсын хуулийн 20 ¹ дүгээр зүйлд заасны дагуу Гэрээний Хавсралт 1 (Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр)-т тодорхойлсон төлбөрийг хэлнэ.	“Royalties” means the payment specified in Appendix 1 (Royalties) of this Agreement in accordance with Article 20 ¹ of Nuclear Energy Law.
“Ам. доллар” гэж Америкийн Нэгдсэн Улсын хууль ёсны мөнгөн тэмдэгтийг хэлнэ.	“USD” means the lawful currency of the United States of America.
“НӨАТ” гэдэгт Нэмэгдсэн өргтийн албан татварын тухай хуулийн дагуу ногдуулах албан татварыг ойлгоно.	“VAT” means value added tax under the Value Added Tax Law.
“Нэмэгдсэн өргтийн албан татварын тухай хууль” гэдэгт 2015 оны 7-р сарын 9-ны өдөр батлагдсан Монгол Улсын нэмэгдсэн өргтийн албан татварын тухай хууль, түүнд орсон болон цаашид орох аливаа нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг хэлнэ.	“Value Added Tax Law” means the Law of Mongolia on Value Added Tax enacted on 9 July 2015, together with any amendments or revisions from time to time.
“Үнэлгээний өдөр” гэдэгт Гэрээний 3.2(c)-д тодорхойлсныг ойлгоно.	“Valuation Date” has the meaning set forth in Clause 3.2(c) of this Agreement.
“Ажлын өдөр” гэж Монгол Улсад банкнууд банкны үндсэн үйл ажиллагаагаа нээлттэй явуулдаг өдөр (Бямба, Ням гариг болон бүх нийтээр амрах баярын өдрүүдээс бусад)-ийг хэлнэ.	“Business Day” means a day in Mongolia when banks are open for conducting their regular operations (excluding Saturdays, Sundays, and public holidays).
“Авлигын эсрэг хууль” гэж 2006 оны 7 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Авлигын эсрэг Монгол Улсын хууль, түүнд орсон болон цаашид орох аливаа нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг хэлнэ.	“Anti-Corruption Law” means the Law of Mongolia on Anti-Corruption enacted on 6 July 2006, together with any amendments or revisions from time to time.
“Уулын ажлын төлөвлөгөө” гэж төрийн эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан тухайн жилийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ, үндсэн үзүүлэлтүүдийг тусгасан баримт бичгийг хэлнэ.	“Mining Work Plan” means the document approved by the State Authority that outlines the Production Volume and key indicators for the relevant year.

<p>“Төрийн эрх бүхий байгууллага” гэдэгт:</p> <ul style="list-style-type: none"> (a) Засгийн газар, аймгийн засаг захиргааны байгууллагууд, тэдгээрийн болон аливаа орон нутгийн засаг захиргааны байгууллагын аливаа салбар нэгж; (b) Засгийн газар, аймгийн болон аливаа орон нутгийн засаг захиргааны байгууллагын (эргэлзээг арилгах үүднээс тодруулахад Дорноговь аймаг болон Дорноговь аймгийн Улаанбадрах сумын засаг захиргааны байгууллагууд үүнд хамаарах боловч эдгээрээр хягаарлагдахгүй), хэлтэс, газар, эрх бүхий байгууллага, агентлаг, салбар; (c) шийдвэр гүйцэтгэх байгууллагууд; (d) дээр дурдсан байгууллага тус бурд хамаарах гүйцэтгэх, хууль тогтоох, татварын, зохицуулах эсхүл захиргааны эрх мэдэл, чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн, бус нутгийн болон орон нутгийн хэмжээний аливаа хороо, зохицуулах агентлаг, эрх бүхий байгууллага, болон бусад этгээд; болон (e) дээр дурдсан байгууллагуудын бүхий л албан тушаалтан, төлөөлөгч болон итгэмжлэгдсэн төлөөлөгчид. 	<p>“State Authority” means:</p> <ul style="list-style-type: none"> (a) the Cabinet, aimag governments, any subdivisions thereof or of any other local administrative organizations; (b) department, division, authority, agency, branch of the Cabinet, aimag governments or any local administrative organizations (for the avoidance of doubt, including, but not limited to the administrative organizations of Dornogovi aimag and Ulaanbadrakh soum of Dornogovi aimag); (c) enforcement agencies; (d) any state, regional or local commission or regulatory agency, authority or other entity exercising executive, legislative, taxing, regulatory or administrative powers or functions of each of the above; or (e) all officials, agents, and representatives of each of the foregoing.
<p>“ЭЗХАХБ” гэдэгт Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагыг хэлнэ.</p>	<p>“OECD” means the Organization for Economic Cooperation and Development.</p>

<p>“Бүтээгдэхүүний борлуулалтын үнэ” нь ураны ислийн (U_3O_8) олон улсын спот зах зээлийн үнээс Маркетингийн төлбөрийг хассан үnэтэй тэнцүү байна. Ураны ислийн (U_3O_8) олон улсын спот зах зээлийн үнэ нь борлуулалт хийхээс өмнөх зургаан (6) долоо хоногийн UxC болон Tradetech-ийн долоо хоног бүрийн индексүүдийн дундаж байна. Төсөл хэрэгжүүлэгч компани болон бүх хувьцаа эзэмшигчидтэй байгуулах худалдах, худалдан авах гэрээнд энэхүү Гэрээнд тодорхойлсон Бүтээгдэхүүний борлуулалтын үнэ гэсэн тодорхойлолтыг тусгана. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулахад энэ үнийг ашиглахгүй бөгөөд Цөмийн энергийн тухай хуульд заасныг баримтална.</p>	<p>“Product Sales Price” is equal to the international spot market price for uranium oxide (U_3O_8) minus the Marketing Fee, the international spot market price for uranium oxide (U_3O_8) being the average of the weekly indices of UxC and Tradetech during the previous six (6) weeks preceding the sale. The sale and purchase agreement to be concluded between the Project Company and its shareholders shall include the same definition of the Product Sales Price as used in this Agreement. This price shall not be used for the calculation of Royalties, and the provisions of the Nuclear Energy Law shall apply.</p>
<p>“Гэрээний хугацаа” гэдэгт энэ Гэрээний 2.2(b)-д заасныг ойлгоно.</p>	<p>“Term of the Agreement” has the meaning set forth in Clause 2.2(b) of this Agreement.</p>
<p>“Стандарт үйл ажиллагааны журмууд” гэдэгт Төсөл хэрэгжүүлэгч компаниас гаргасан түүний болон гэрээт байгууллагын ажилтнуудын Төслийг хэрэгжүүлэх бүхий л үйл ажиллагаанд өдөр тутамд дагаж мөрдөх заавар, дүрэм, журам, стандартуудыг ойлгоно.</p>	<p>“Standard Operating Procedures” means the instructions, rules, regulations, and standards issued by the Project Company that must be followed daily by the employees of the Project Company and its subcontractors in all Project implementation activities.</p>
<p>“Цацраг идэвхт хаягдлын менежментийн төлөвлөгөө” гэж Төслийн үйл ажиллагаанаас үүсэх цацраг идэвхт хаягдлыг цуглуулах, ангилах, ялгах, боловсруулах, аюулгүй булшлах, мониторинг хийх, хаалтын дараа засвар арчилгаа хийх үйл ажиллагааг олон улсын болон үндэсний хууль, дүрэм, стандартын дагуу гүйцэтгэх цогц арга хэмжээ, зохион байгуулалт, инженерийн дэвшилтээ шийдэл, технологи, хэрэгжүүлэх зардал зэргийг тусгасан, Уурхайн амьдралын мечлэгийн бүх үе шатанд тасралтгүй хэрэгжүүлэхээр боловсруулж, Төрийн холбогдох эрх бүхий байгууллагаар хянуулж, батлуулсан баримт бичгийг хэлнэ.</p>	<p>“Radioactive Waste Management Plan” means a document reviewed and approved by the relevant State Authority, detailing comprehensive measures, organization, advanced engineering solutions, technology, and implementation costs for the collection, classification, sorting, processing, safe disposal, monitoring, and post-closure maintenance of radioactive waste generated from the Project operations, to be executed in accordance with international and national laws, regulations and standards, and designed to be continuously implemented throughout all stages of the Mine's lifecycle.</p>
<p>“Тамшгийн эрсдэлийн үнэлгээний тайлан” гэдэгт 2017 оны 02 сарын 02 өдөр батлагдсан Гамшгаас хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлд заасан үнэлгээний тайланг ойлгоно.</p>	<p>“Disaster Risk Assessment Report” means the assessment report specified in Article 7 of the Law of Mongolia on Disaster Protection, enacted on 2 February 2017.</p>
<p>“Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний тайлан” гэдэгт 2016 оны 2 дугаар сарын 04-ний өдөр батлагдсан Эрүүл ахуйн тухай Монгол Улсын хуулийн 9 дүгээр зүйлд заасан үнэлгээний тайланг ойлгоно.</p>	<p>“Health Impact Assessment Report” means the assessment report specified in Article 9 of the Law on Hygiene of Mongolia, which was enacted on 4 February 2016.</p>

“Гарын үсэг зурсан өдөр” гэж Талууд энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан өдрийг ойлгоно.	“ Date of Signature ” means the date when this Agreement is signed by the Parties.
“Анхны хөрөнгө оруулалт” гэдэгт Гэрээний 3.1(d)-д заасныг ойлгоно.	“ Initial Investment ” means has the meaning set forth in Clause 3.1(d) of the Agreement.
“Үйлдвэрлэлийн хэмжээ” гэдэгт Гэрээний 3.5(a)-д тодорхойлсныг ойлгоно.	“ Production Volume ” has the meaning set forth in Clause 3.5(a) of the Agreement.
“Төслийн нийт шууд үр өгөөж” гэдэгт Гэрээний 4.2(b)-д заасныг ойлгоно.	“ Total Direct Benefits of the Project ” has the meaning set forth in Clause 4.2(b) of the Agreement.

<p>“Олон улсын стандарт” гэдэгт цацраг идэвхт ашигт малтмал хийх, олборлох, үйлдвэрлэх, борлуулах, уурхайн хаалтын үйл ажиллагаанд хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, тусгаарлах, боловсруулах, маркетинг хийхтэй холбоотой цацрагийн сэргэг нөлөөллийг бууруулах, аюулгүй байдлыг хангах зорилгоор, болон уурхайн хаалтын үйл ажиллагаа, засгийн газарт ирэх үр өгөөж, нягтлан бодох бүртгэл, аудиттай холбоотой олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, дэлхий нийтийн хэмжээнд мөрдөгддөг, олон улсын байгууллагаас гаргасан, дүрэм, журам, стандарт, удирдамж, зөвлөмж, шилдэг туршлагыг хэлэх бөгөөд үүнд дараах зүйлс хамаарах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй:</p> <ul style="list-style-type: none"> (a) ОУАЭА-аас гаргасан дүрэм, стандарт, зөвлөмж, техникийн баримт бичгүүд; (b) Уул уурхай, металлын олон улсын зөвлөлөөс гаргасан зарчим, зөвлөмжүүд; (c) ISO стандартууд; (d) Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт; (e) ОСИТБС-ын тайлагналын стандартууд; (f) ЭЗХАХБ-ын Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн эсрэг удирдамж болон арга хэмжээний зөвлөмжүүд; болон (g) Төслийн үйл ажиллагаанд хамаарал бүхий, дэлхий нийтийн хэмжээнд хүлээн зөвшөөрч, дагаж мөрддөг бусад журам, зөвлөмж, стандартууд. 	<p>“International Standards” mean the rules, regulations, standards, guidelines, recommendations, and best practices recognized internationally and issued by international organizations, aimed at protecting human, livestock and animal health, protecting and restoring the environment, and reducing the negative impacts of radiation related to the exploration, extraction, production, marketing of radioactive minerals, mine closure activities, governmental benefit, disclosure, accounting and auditing. This includes, but is not limited to, the following:</p> <ul style="list-style-type: none"> (a) Guidelines, standards, recommendations, and technical documents by IAEA; (b) Principles and recommendations released by the International Council on Mining and Metals; (c) ISO standards; (d) International Financial Reporting Standards; (e) EITI reporting standards; (f) Guidelines and Actions of the Base Erosion Profit Shifting (BEPS) by the OECD; and (g) Other internationally recognized and adhered procedures, recommendations, and standards relevant to the Project operations.
---	---

<p>“Үндэсний стандарт, дүрэм, журам” гэж цацраг идэвхт ашигт малтмал хайх, олборлох, боловсруулах, үйлдвэрлэх, борлуулах, уурхайг хаах, нөхөн сэргээх үйл ажиллагааг аюулгүй гүйцэтгэх, тэдгээр үйл ажиллагаанаас хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй аливаа сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх, хяналт, мониторинг хийх, аюулгүй байдлыг хангах зорилгоор Монгол Улсын эрх бүхий төрийн болон бусад байгууллагаас гаргасан үндэсний хэмжээнд заавал дагаж мөрдөх хүчинтэй дүрэм, журам, стандарт, удирдамж, заавар зэрэг баримт бичгийг хэлнэ.</p>	<p>“National Standards, Regulations, and Rules” means the rules, regulations, standards, guidelines, and instructions issued by competent governmental and other authorities in Mongolia that are mandatory at the national level for safely carrying out activities related to the exploration, extraction, processing, production, marketing of radioactive minerals, closure, and rehabilitation of mines, aimed at reducing, preventing, protecting from, and monitoring any potential negative impacts on human, livestock and animal health, and the environment.</p>
<p>“Авлигын эсрэг хууль тогтоомж” гэдэгт Гэрээний 13.1-д тодорхойлсныг ойлгоно.</p>	<p>“Anti-Corruption Laws and Regulations” has the meaning set forth in Clause 13.1 of the Agreement.</p>
<p>1.2 Энэхүү Гэрээнд дараах тайлбаруудыг хэрэглэнэ:</p> <ul style="list-style-type: none"> (a) Гарчгууд: гарчгууд нь зөвхөн эш татах зорилготой бөгөөд энэхүү Гэрээг тайлбарлахад ашиглагдахгүй; (b) Энэ Гэрээ: энэ Гэрээ хэмээн эшилсэн буюу заасан нь энэ Гэрээнд тухай бүр оруулсан нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг ойлгоно; (c) Зүйл, хэсэг, Хавсралт болон Үндэслэл: Аливаа зүйл, хэсэг, Хавсралт болон Үндэслэл хэсгийг эш татсаныг энэ Гэрээний зүйл, хэсэг, Хавсралт болон Үндэслэл хэсэг гэж ойлгох ба Хавсралтууд нь энэхүү Гэрээний салшгүй хэсэг байна; болон (d) Энэ Зүйл: тухайн зүйлийн тодорхой хэсгийн дугаарыг заагаагүй тохиолдолд энэ Зүйл гэдгийг тус Зүйлийг бүхэлд нь заасан гэж үзнэ. 	<p>1.2 In this Agreement the following interpretations apply:</p> <ul style="list-style-type: none"> (a) Headings: headings are for ease of reference only and to be ignored when interpreting this Agreement; (b) This Agreement: references to this Agreement as varied, novated, supplemented or replaced from time to time; (c) Clause, paragraph, Appendix or Preamble: references to any Clause, paragraph, Appendix or Preamble that are contained in this Agreement. All the Appendices are an integral part of this Agreement; and (d) This Clause: the expression this Clause, unless followed by the number of a specific part of the Clause, refers to the whole Clause in which it occurs.

1.3 Нэр томьёоны тайлбар	1.3 Interpretations of Terms
(a) “оролцуулаад” эсхүл “оролцуулан”, “үүнд” гэдгийг “үүгээр хязгаарлагдахгүйгээр оролцуулаад” эсхүл “үүгээр хязгаарлагдахгүйгээр оролцуулан” гэж ойлгоно.	(a) The terms “including” and “includes” mean “including without limitation” and “includes without limitation”.
(b) Энэ Гэрээнд ганц тооны, эсхүл эр хүсийг заасан, эсхүл саармаг утгатай үг ашигласан тохиолдолд үүнийг тухайн агуулгаас хамаарч олон тооны, эсхүл эм хүсийг заасан утгаар ойлгож тайлбарлана.	(b) Whenever the singular or masculine or neutral is used in this Agreement, it shall be interpreted as meaning the plural or feminine, and vice versa, as the context requires.
(c) Тухайн зүйлийн агуулга нь өөрөөр тайлбарлахыг шаардсанаас бусад тохиолдолд аливаа нэр томьёог нь энд тодорхойлсон бол тухайн нэр томьёоноос үүссэн үүсмэл нэр томьёо нь түүнтэй адил утгыг илэрхийлнэ.	(c) Where a term is defined herein, a derivative of such term shall have a corresponding meaning unless the context otherwise requires.
(d) Өөрөөр тусгайлан заагаагүй бол өдрийн тухай бүх эшлэл нь хуанлийн өдрийг илэрхийлнэ.	(d) Unless specifically stated otherwise, all references to days shall mean calendar days.
(e) Энэ Гэрээ болон Орд ашиглах гэрээ хоорондоо зөрчилдсэн эсхүл үл нийцсэн тохиолдолд Орд ашиглах гэрээг энэхүү Гэрээний дагуу тайлбарлана.	(e) Contradictions or inconsistencies between this Agreement and the Deposit Development Agreement shall be interpreted in favour of this Agreement.
(f) Энэ Гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын хууль, дүрэм, журам, Монгол Улсын соёрхон баталсан аливаа олон улсын гэрээг эш татсан нь Гарын үсэг зурсан өдрийн байдлаар хүчин төгөлдөр Монгол Улсын хууль, дүрэм, журам, Монгол Улсын соёрхон баталсан аливаа олон улсын гэрээг эш татсан гэж ойлгоно.	(f) Unless otherwise provided in this Agreement, any reference to a law, rule, regulation or treaty of Mongolia in this Agreement means a reference to such law, rule, regulation or treaty of Mongolia as in force on the Date of Signature.

<p>2. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</p> <p>2.1 Гэрээний зорилго</p> <p>Энэхүү Гэрээг байгуулах болсон зорилго нь:</p> <ul style="list-style-type: none"> (a) Ил тод бөгөөд тогтвортой хууль эрхэйн болон татварын орчинтой холбоотой эрх, олон улсын зах зээлийн үнээр Бүтээгдэхүүнийг борлуулах болон борлуулалтаас бий болсон орлогыг өөрийн үзэмжээр захиран зарцуулах эрх зэргийг оролцуулан Хөрөнгө оруулагчийн болон Төсөл хэрэгжүүлэгч компанийн эдлэх тодорхой эрхүүдийг баталгаажуулах болон тогтоо; (b) Хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд Төсөл хэрэгжүүлэгч компанийн тогтвортой үйл ажиллагааг хангах, Хөрөнгө оруулагчийн өөрийн хөрөнгийг удирдах эрх хэрэгжүүлэх боломжийг олгохоо баталгаажуулах, хууль ёсны дагуу олсон орлого болон хөрөнгөө гадаад улс руу шилжүүлэх болон Талуудад харилцан ашигтай хамтын ажиллагааны бусад нөхцөлийг заах; (c) Хөрөнгө оруулалттай холбоотой Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг болон энэхүү Гэрээний дагуу Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны нөхцөлийг тогтоох; болон (d) Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтууд, олон улсын жишиг болон Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн Монгол Улсын эдийн засаг болон нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор Талуудын хамтран ажиллах зарчмууд, тэдний эрх, үргийг тодорхой болгохыг хангах зэрэг байна. 	<p>2. GENERAL PROVISIONS</p> <p>2.1 Purpose of the Agreement</p> <p>The purpose of this Agreement is to:</p> <ul style="list-style-type: none"> (a) Confirm and establish certain rights of the Investor and the Project Company, including their rights to a transparent and stable legal framework and tax environment, to sell the Products at international market prices; and to manage the income derived from its sales at its own discretion; (b) Ensure sustainable operation of the Project Company within the scope permitted by law, guarantee the Investor's right to manage its assets, to transfer legal income and profits abroad, and specify other conditions for mutually beneficial cooperation among the Parties, (c) Establish the rights and obligations of the Parties with respect to the Investment, and conditions of the Investment activities under this Agreement; and (d) Ensure that the principles of cooperation between the Parties, their rights and obligations are clearly established with the aim of contributing to the economic and social development of Mongolia, in line with its sustainable development goals international benchmarks and the Constitution of Mongolia.
---	---

<p>2.2 Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр, Гэрээний хугацаа</p> <p>(a) Энэхүү Гэрээ нь Гэрээний 19.1(d)-д заасан Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.</p> <p>(b) Гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгоогүй бол Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн 20 (хорь) жилийн хугацаанд хүчинтэй байна (“Анхны хугацаа”).</p>	<p>2.2 Effective Date and the Term of the Agreement</p> <p>(a) This Agreement shall be effective from the Effective Date set forth in Clause 19.1(d) of this Agreement.</p> <p>(b) The Agreement shall be valid for a period of 20 (twenty) years from the Effective Date unless terminated earlier (the “Initial Term”).</p>
<p>2.3 Гэрээний хугацааг сунгах</p> <p>(a) Хөрөнгө оруулагч нь Гэрээний хугацаа дуусахаас сарын 12 (арван хоёр) сарын өмнө Гэрээний хугацааг сунгах хүсэлтийг Засгийн газарт гаргах эрхтэй (цаашид “Гэрээний хугацааг сунгах хүсэлт” гэх).</p> <p>(b) Талууд нь энэ Гэрээг 10 (арв) хүртэл жилээр сунгаж болно. Сунгалт тус бүр нь Цөмийн энергийн тухай хуулийн дагуу хийгдэх бөгөөд дараах нөхцөлүүд хангагдсан байна:</p> <p>(i) Төслийн үйл ажиллагаа тасралтгүй явагдаж байгаа (Төлөвлөгөөт зогсолт болон Гэрээний 3.6(а)-д заасан үндэслэлээр түр зогссон хугацаа хамаарахгүй);</p> <p>(ii) Хөрөнгө оруулагч болон Төсөл хэрэгжүүлэгч компани нь энэхүү Гэрээгээр хүлээсэн үндсэн үүргээ зөрчөөгүй;</p>	<p>2.3 Extension of the Term of the Agreement</p> <p>(a) The Investor has the right to submit a request to the Government for extension of the Term of the Agreement 12 (twelve) months before its expiration (“Request for Extension”).</p> <p>(b) The Parties may extend the Agreement for up to 10 (ten) years. Each extension shall be pursuant to the Nuclear Energy Law, provided that:</p> <p>(i) The Project activities are ongoing without interruption (excluding the duration of Routine Shutdowns and interruptions specified in Clause 3.6(a) of the Agreement);</p> <p>(ii) The Investor and Project Company have not materially breached their obligations under this Agreement.</p>

	<p>(c) Гэрээний хугацааг сунгахаар шийдвэрлэсэн тохиолдолд, Талууд шаардлагатай гэж үзсэн Гэрээний зарим нэхцелүүдийг дахин хэлэлцэж, бичгээр харилцан тохиролцсоны үндсэн дээр Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.</p> <p>(d) Талууд тусгайлан бичгээр харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулснаас бусад тохиолдолд сунгагдсан хугацаанд Гэрээний анхны нэхцелүүд хэвээр мөрдөгднө.</p>	<p>(c) If a decision is made to extend the Term of the Agreement, the Parties may re-negotiate certain conditions of the Agreement as deemed necessary and may make additions or changes to the Agreement based on mutual written agreement.</p> <p>(d) Except for cases where the Parties specifically agree in writing to make amendments or changes, the original terms and conditions of the Agreement shall remain in effect during the extended term.</p>
3.	ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	3. PROJECT OPERATIONS
3.1	Хөрөнгө оруулалт	3.1 Investment
	<p>(a) Хөрөнгө оруулалт гэдэгт Төсөл хэрэгжүүлэгч компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайландаа тусгагдсан биет болон биет бус хөрөнгийг ойлгоно.</p>	<p>(a) Investment shall mean tangible and intangible assets included in the equity of the Project Company and reflected in its financial statements.</p>
	<p>(b) Хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалт хийж буй зорилго нь Хөрөнгө оруулагч, Төсөл хэрэгжүүлэгч компани болон түүний хувьцаа эзэмшигчдэд эдийн засгийн хувьд ашигтай байх нэхцэлд Ордуудыг ашиглах явдал юм.</p>	<p>(b) The purpose of the Investor's investment is to utilize the Deposits in a manner that is economically beneficial to the Investor, the Project Company and its shareholders.</p>
	<p>(c) Техник эдийн засгийн үндэслэлд заасан хугацаа болон төлөвлөгөөний дагуу Төсөл хэрэгжих хугацаанд ойролцоогоор нэг тэрбум зургаан зуун тавин сая (1,650,000,000) ам.долларын Хөрөнгө оруулалт хийгдэнэ.</p>	<p>(c) The Investment of approximately USD one billion six hundred fifty million (1,650,000,000) shall be made during the Project implementation period, according to the timeframe and plans specified in the Feasibility Study.</p>

(d)	Техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан нийт Хөрөнгө оруулалтын нэг хэсэг болох анхны хөрөнгө оруулалт (“Анхны хөрөнгө оруулалт”)-ыг Хөрөнгө оруулагч Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс хойш дөрвөн (4) жилийн хугацаанд хийх бөгөөд Анхны хөрөнгө оруулалтын хэмжээ нь ойролцоогоор 500,000,000 (таван зуун сая) ам.доллар байна.	(d) The initial investment to be made by the Investor over four (4) years (“Initial Investment”), starting from the Effective Date, shall be approximately USD500,000,000 (five hundred million), which shall constitute a part of the total Investment referred to in the Feasibility Study.
(e)	Дээрх 3.1(d) дүгээр зүйлд тусгасан Анхны хөрөнгө оруулалтын хувьд Төслийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны санхүүжилтийг Төсөл хэрэгжүүлэгч компани эргэн төлөх үүрэг хүлээх зээл эсхүл бусад зээлтэй адилтгах санхүүгийн хэрэгслээр бүрдүүлэхгүй бөгөөд зөвхөн Анхны хөрөнгө оруулалтыг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.	(e) In respect of the Initial Investment described in Article 3.1(d) only, the investment and operational financing for the Project shall not be financed by loans or other debt-like financial instruments that the Project Company will be obligated to repay, and shall be financed through equity financing.
(f)	Төслийн хугацаанд хувьцаа эзэмшигчдээс аливаа зээл авахыг зөвшөөрөхгүй. Хэрэв урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдалд энэ төрлийн санхүүжилт шаардлагатай бол, Талууд харилцан тохиролцож, хувьцаа эзэмшигчдийн 100% (нэг зуун хувийн) санал нэгтэй шийдвэрээр батлах ёстой. Төсөл хэрэгжүүлэгч компанийн хувьцаа эзэмшигчид 100% (нэг зуун хувийн) саналаар хувьцаа эзэмшигчийн зээл авах шийдвэрийг гаргаж чадаагүй тохиолдолд, гуравдагч этгээдээс зээл, санхүүжилт авахад шаардагдах зөвшөөрлийг олгоно.	(f) Any loans from the shareholders shall not be permitted during the Project period. If unforeseen circumstances require such financing, the Parties shall mutually agree, and it must be approved by a unanimous resolution of 100% (one hundred percent) of shareholders' votes. Unless the shareholders of the Project Company unanimously approve a shareholder loan resolution, the necessary approvals shall be granted to secure loans and financing from third parties.
(g)	Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө Төсөл хэрэгжүүлэгч компанийд олгосон Хувьцаа эзэмшигчийн зээлийг Төсөл хэрэгжүүлэгч компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд шилжүүлэхээр Талууд тохиролцов.	(g) The Parties have agreed that any Shareholder Loans provided to the Project Company before the Effective Date shall be transferred to the Project Company's equity.

<p>3.2 Хөрөнгө оруулалтыг хамгаалах баталгаа</p> <p>(a) Хөрөнгө оруулагч, Төсөл хэрэгжүүлэгч компани болон түүний хувьцаа эзэмшигчид нь Монгол Улсын Үндсэн хууль, Цөмийн энергийн тухай хууль, бусад хууль тогтоомж болон Монгол Улсын олон улсын гэрээгээр баталгаажсан эрх зүйн хамгаалалтыг оролцуулан Монгол Улсын хуулиар олгосон бүхий л хамгаалалтыг эдэлнэ.</p> <p>(b) Хөрөнгө оруулагч болон Төсөл хэрэгжүүлэгч компани болон тэдгээрийн Хамаарал бүхий этгээдүүдийн хөрөнгө, үл хөдлөх болон бусад эд хөрөнгийг Цөмийн энергийн тухай хууль болон Монгол Улсын олон улсын гэрээний дагуу үл ялгаварлах зарчмын үндсэн дээр хуульд заасан журмыг баримтлан нөхөх олговрыг нь Засгийн газраас бүрэн хэмжээгээр төлөх, гагцхүү дор дурдсан нөхцөлүүд нэгэн зэрэг бүрдэхээс бусад нөхцөлд нийгэмчлэх, хураан авах, дайчлан авахгүй бөгөөд хураан авахтай төстэй арга хэмжээ авахгүй:</p>	<p>3.2 Guarantees for Protecting Investment</p> <p>(a) The Investor, the Project Company and its shareholders shall benefit from all protections afforded by Mongolian Law, including the legal protections afforded by the Constitution of Mongolia, Law on Nuclear Energy, other laws and regulations and international treaties to which Mongolia is a party.</p> <p>(b) The Investor, the Project Company and their Affiliates' property immovable and other assets shall not be nationalized, confiscated, expropriated or subject to measures tantamount to expropriation except in accordance with due process of law on a non-discriminatory basis and with full compensation by the Government according to Law on Nuclear Energy and any international treaties to which Mongolia is a party and only when the following conditions are fulfilled at the same time:</p> <table border="0" style="width: 100%;"> <tr> <td style="vertical-align: top;"> (i) нийтийн эрх ашгийн төлөө; </td><td style="vertical-align: top;"> (i) in the public interest; </td></tr> <tr> <td style="vertical-align: top;"> (ii) үл ялгаварлах зарчмын дагуу; </td><td style="vertical-align: top;"> (ii) is not discriminatory; </td></tr> <tr> <td style="vertical-align: top;"> (iii) хууль заасан журмын дагуу; болон </td><td style="vertical-align: top;"> (iii) is carried out under due process of law; and </td></tr> <tr> <td style="vertical-align: top;"> (iv) Хөрөнгө оруулагчид бүрэн хэмжээгээр нөхөн олговортоойгоор. </td><td style="vertical-align: top;"> (iv) is accompanied by the payment of full compensation to the Investor. </td></tr> </table>	(i) нийтийн эрх ашгийн төлөө;	(i) in the public interest;	(ii) үл ялгаварлах зарчмын дагуу;	(ii) is not discriminatory;	(iii) хууль заасан журмын дагуу; болон	(iii) is carried out under due process of law; and	(iv) Хөрөнгө оруулагчид бүрэн хэмжээгээр нөхөн олговортоойгоор.	(iv) is accompanied by the payment of full compensation to the Investor.
(i) нийтийн эрх ашгийн төлөө;	(i) in the public interest;								
(ii) үл ялгаварлах зарчмын дагуу;	(ii) is not discriminatory;								
(iii) хууль заасан журмын дагуу; болон	(iii) is carried out under due process of law; and								
(iv) Хөрөнгө оруулагчид бүрэн хэмжээгээр нөхөн олговортоойгоор.	(iv) is accompanied by the payment of full compensation to the Investor.								
<ul style="list-style-type: none"> (i) нийтийн эрх ашгийн төлөө; (ii) үл ялгаварлах зарчмын дагуу; (iii) хууль заасан журмын дагуу; болон (iv) Хөрөнгө оруулагчид бүрэн хэмжээгээр нөхөн олговортоойгоор. 	<ul style="list-style-type: none"> (i) in the public interest; (ii) is not discriminatory; (iii) is carried out under due process of law; and (iv) is accompanied by the payment of full compensation to the Investor. 								

(c)	Хөрөнгө оруулагчид олгох нөхөх олговрын хэмжээг Төслийн, үүнд дайчлан гаргуулсан эд хөрөнгө эсхүл хөрөнгийг оролцуулан, дайчлан гаргуулахаас, эсхүл энэ тухай нийтэд мэдэгдэхээс шууд өмнөх үеийн (цаашид “Үнэлгээний өдөр” гэх) зах зээлийн бодит үнэ цэнийг үндэслэн тогтоох бөгөөд уг зах зээлийн бодит үнэ цэнэ нь дайчлан гаргуулсныг үл хамааран тогтоосон үнэ цэнэ байх бөгөөд бүрэн хэмжээгээр даруй төлнө.	(c)	The amount of compensation to be paid to the Investor shall be determined on the basis of the fair market value of the Project, including the property and/or assets expropriated, and on the basis that such fair market value disregards the expropriation itself, to be determined immediately prior to the expropriation, or notice of the expropriation becoming public (the “Valuation Date”), and shall be promptly paid in full.
(d)	Хөрөнгө оруулагчийн хүсэлтээр зах зээлийн бодит үнэ цэнийг үнэлгээг тухайн валютын Үнэлгээний өдрийн зах зээлийн ханшийг үндэслэн чөлөөтэй хөрвөх валютаар (ам.доллар) илэрхийлнэ.	(d)	Such fair market value shall, at the request of the Investor, be expressed in a freely convertible currency (USD) on the basis of the market rate of exchange existing for that currency on the Valuation Date.
(e)	Хөрөнгө оруулагч, Төсөл хэрэгжүүлэгч компани болон тэдгээрийн Хамаарал бүхий этгээдүүд оруулсан хөрөнгө оруулалтаяа эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбоотой бүхий л асуудалд үл ялгаварлах зарчмыг баримтлах ба үүнд үндэсний эсхүл нэн тааламжтайг дэглэм (аль илүү тааламжтайг нь сонгон) хамаарна.	(e)	The Investor, the Project Company and their Affiliates shall be accorded non-discriminatory treatment, including national treatment or most-favoured nation treatment (whichever is more favourable) with respect to all matters, including in relation to possession, enjoyment and disposal of its investments.

<p>3.3 Төслийн үйл ажиллагаа</p> <ul style="list-style-type: none"> (a) Төсөл хэрэгжүүлэгч компани нь Техник, эдийн засгийн үндэслэлд заасны дагуу Төслийг хэрэгжүүлэх онцгой эрхтэй болохыг Засгийн газар хүлээн зөвшөөрч байгаа болно. (b) Төсөл хэрэгжүүлэгч компани нь Төсөл хэрэгжих бүх үе шатны үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох Олон улсын стандарт болон Үндэсний стандарт, дүрэм, журмыг дагаж мөрдөх үүрэгтэй. (c) Хөрөнгө оруулагч нь хувьцаа эзэмшигчийн хувьд Төсөл хэрэгжүүлэгч компанийг энэ Гэрээ болон Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх явдлыг хангахуйц зохистой удирдлагыг хэрэгжүүлнэ. 	<p>3.3 Project Operations</p> <ul style="list-style-type: none"> (a) The Government acknowledges that the Project Company has exclusive rights to implement the Project according to the Feasibility Study. (b) The Project Company shall comply with the laws of Mongolia and relevant International Standards, National Standards, Regulations, and rules in its activities at all stages of the Project implementation. (c) The Investor as shareholder shall exercise the proper governance to ensure that the Project Company shall fulfil its obligations under this Agreement and the Mongolian Law.
<p>3.4 Төсөл хэрэгжих үе шат</p> <ul style="list-style-type: none"> (a) Төслийн үйл ажиллагаа нь дараах үе шатуудад хуваагдана: <ul style="list-style-type: none"> (i) Бүтээн байгуулалтын үе шат; (ii) Уурхайн ашиглалтын үе шат; болон (iii) Уурхайн хаалт, нехэн сэргээлтийн үе шат. (b) Хөрөнгө оруулагч болон Төсөл хэрэгжүүлэгч компани нь Бүтээн байгуулалтын үе шатыг дөрвөн (4) жилийн дотор дуусгахыг эрмэлзэнэ. 	<p>3.4 Project Implementation Phases</p> <ul style="list-style-type: none"> (a) The Project operations shall be divided into the following phases: <ul style="list-style-type: none"> (i) Construction Phase; (ii) Mining Operation Phase; and (iii) Mine Closure and Rehabilitation Phase. (b) The Investor and the Project Company shall endeavor to complete the Construction Phase within four (4) years.

3.5 Үйлдвэрлэлийн хэмжээ	3.5 Production Volume
<p>(a) Төсөл хэрэгжүүлэгч компанийн явуулах жилийн үйлдвэрлэлийн нэрлэсэн хэмжээг Техник, эдийн засгийн үндэслэлд үндэслэн тогтоох бөгөөд Уулын ажлын жилийн төлөвлөгөөгөөр баталгаажуулна (цаашид "Үйлдвэрлэлийн хэмжээ" гэх).</p>	<p>(a) The nominal annual production volume shall be determined based on the Feasibility Study and confirmed by the Mining Work Plan annually. ("Production Volume").</p>
<p>(b) Төсөл хэрэгжүүлэгч компани нь аливаа жилд Үйлдвэрлэлийн хэмжээг Техник, эдийн засгийн үндэслэлд төлөвлөснөөс 20% (хорин хувь)-аас дээш хэмжээгээр өөрчлөх тохиолдолд энэ талаар Засгийн газарт бичгээр тайлбар хүргүүлэх үүрэгтэй бөгөөд тус тайлбарт дараах мэдээлэл, баримтыг хавсаргана:</p> <ul style="list-style-type: none"> (i) Үйлдвэрлэлийн хэмжээг мөрдөж ажиллах боломжгүй болсон шалтгаан, түүнийг нотлох баримт; мөн (ii) Төсөл хэрэгжүүлэгч компанийн авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, Үйлдвэрлэлийн хэмжээг хангах түвшинд үйлдвэрлэлийг явуулахад шаардагдах хугацаа. 	<p>(b) If the Project Company alters the Production Volume by more than 20% (twenty percent) from what was planned in the Feasibility Study in any given year, it must submit a written explanation to the Government, accompanied by the following information and documents:</p> <ul style="list-style-type: none"> (i) Reasons for failing to achieve Production Volume, accompanied by supporting evidence; and (ii) Measures being implemented by the Project Company, along with the estimated time required to reach production levels that meet the Production Volume.

(c)	Гэрээний 3.5(b)-д зааснаас бусад тохиолдолд, Төсөл хэрэгжүүлэгч компани нь Ашиглалтын үе шатанд явагдах Үйлдвэрлэлийн хэмжээг холбогдох хууль тогтоомжид зассан журмын дагуу Техник, эдийн засгийн үндэслэлд нийцүүлэн боловсруулсан тухайн жилийн Уулын ажлын төлөвлөгөөнд тусгаж, эрх бүхий байгууллагаар батлуулсны үндсэн дээр өөрчилж болно.	(c)	Except as provided in Article 3.5(b) of the Agreement, the Project Company may adjust the Production Volume during the Mining Operation Phase, subject to the approval of a competent authority. Such changes must be incorporated into the annual Mining Work Plan, developed in accordance with the Feasibility Study and following the procedures outlined in the relevant regulations.
(d)	Төсөл хэрэгжүүлэгч компани нь Техник, эдийн засгийн үндэслэлд заасан ашигт малтмалын бүх нөөцийг олборлоно.	(d)	The Project Company shall mine all of the mineral reserves specified in the Feasibility Study.
(e)	Төсөл хэрэгжүүлэгч компани нь ураныг газар доор уусган олборлох явцад нэгэн зэрэг уусган, олборлож болох эдийн засгийн хувьд ашигтай аливаа элементийн агуулгад үнэлгээ хийнэ.	(e)	The Project Company shall assess the content of any economically useful elements that can be simultaneously leached and extracted during the underground leaching of uranium.

3.6 Үйлдвэрлэлийг түр зогсоох	3.6 Temporary Suspension of Production
<p>(a) Төсөл хэрэгжүүлэгч нь дараах тохиолдолд үйлдвэрлэлийг түр хугацаагаар зогсоож болно:</p> <ul style="list-style-type: none"> (i) Гэрээний 15.1-д заасан Давагдашгүй хүчин зүйлийн улмаас үйлдвэрлэлийг түр хугацаагаар зогсоо шаардлага бий болсон бөгөөд Засгийн газарт энэ талаар мэдэгдэл хургуулсэн; (ii) Төсөлд сөргөөр нөлөөхүйц техникийн, логистикийн, болон захиргааны нехцел байдалд өөрчлөлт орсон; (iii) Төлөвлөгөөт зогсолт; болон (iv) Бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх ханшийн уналтын улмаас үйлдвэрлэлийг түр зогсоо талаар Талууд харилцан тохирсон. <p>(b) Төсөл хэрэгжүүлэгч компани нь үйлдвэрлэлийг түр хугацаагаар зогсоо тохиолдолд холбогдох Төрийн эрх бүхий байгууллагад мэдэгдэх бөгөөд дээрх 3.6(а)-д зааснаас бусад тохиолдолд үйлдвэрлэлийг түр зогсоохыг хориглоно.</p> <p>(c) Дээрх 3.6(a)(i) болон (iv)-д заасан шалтгаанаар түр зогсолт хийсэн тохиолдолд Төрийн аливаа байгууллагаас аливаа тorgууль, алданги, шийтгэл, хураамж, нөхөн олговор нэхэмжлэхгүйгээр энэхүү Гэрээг тухайн зогсолтын үргэлжлэх хугацаагаар сунгана.</p>	<p>(a) The Project Company may temporarily suspend production under the following circumstances:</p> <ul style="list-style-type: none"> (i) Due to a Force Majeure Event as defined in Clause 15.1 of the Agreement, which necessitates a temporary suspension of production, and notification to the Government has been made; (ii) Due to material change in technical, logistical or administrative conditions that would adversely impact the Project; (iii) Due to Routine Shutdowns; and (iv) Upon mutual agreement of the Parties to suspend production due to a decline in prices in the global market for the Product. <p>(b) The Project Company shall notify the relevant State Authority in the event of a Temporary Suspension of Production and is prohibited from temporarily suspending production except under the circumstances described in Clause 3.6(a) above.</p> <p>(c) In case of the suspension of production in accordance with Clause 3.6(a)(i) and (iv) above this Agreement shall be extended for a period equal to the duration of such suspension</p>

		without any penalty, fine, punishment, fee or other compensation claimed by any State Authority.
3.7 Засгийн газрын хяналт, шалгалт	<p>(a) Засгийн газар болон эрх бүхий Төрийн байгууллагууд нь Төрийн хяналт шалгалтын ухай хууль, Цөмийн энергийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмуудад заасны дагуу болон тухайн хууль, дүрэм журамд заасан хязгаарын хүрээнд аливаа хяналт шалгалтыг хийх эрхтэй.</p> <p>(b) Төсөл хэрэгжүүлэгч компанийн лаборатори, шинжилгээний үр дунгүүд нь Олон улсын стандартуудын дагуу “Геологийн судалгаа шинжилгээний төв” Төрийн өмчийт үйлдвэрийн газрын Цөмийн шинжилгээний лабораторийн тогтол хяналтад байна. Цаашид тус лабораторийн нэр, бүтэц, эсхүл харьялалт өөрчлөгдсөн тохиолдолд, Төсөл хэрэгжүүлэгч компанид мэдэгдсэний үндсэн дээр энэхүү заалт нь түүний хууль ёсны залгамжлагч байгууллага эсхүл ижил төстэй үүрэг гүйцэтгэх бусад төрийн лабораториод хамаарна.</p>	<p>3.7 Government Oversight and Inspection</p> <p>(a) The Government and relevant State Authorities each have the right to conduct inspections as defined in the Law of Mongolia on State Inspection, the Nuclear Energy Law, and other applicable laws and regulations, within the limits prescribed by such laws and regulations.</p> <p>(b) The laboratory and testing results of the Project Company shall be under the regular supervision of the Nuclear Analysis Laboratory of the “Geological Research and Exploration Center”, a State-owned Enterprise, in accordance with the International Standards. If the name, structure, or affiliation of this laboratory changes in the future, this provision shall apply to its <u>legal successor</u> or any other state laboratory performing similar functions as notified to the Project Company.</p>

<p>3.8 Зөвшөөрөл болон Ажиллах хүч</p> <p>(a) Хөрөнгө оруулалт болон Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой эрх бүхий Төрийн байгууллагаас олгодог шаардлагатай бүхий л эрх, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, ажлын виз, гаалийн бүрдүүлэлт, болон бусад зөвшөөрлүүд, болон дээрхтэй адилтгах бүхий л зөвшөөрлүүд (“Зөвшөөрөл”)-ийг авахаар холбогдох эрх бүхий Төрийн байгууллагад хүсэлт гаргах, тухайн зөвшөөрлүүдийг авах эрхтэй.</p>	<p>3.8 Permits and Workforce</p> <p>(a) The Project Company has the right to apply for and obtain from competent State Authority all necessary rights, licenses, permits, work visas, customs clearance, other approvals by the relevant State Authority and any other similar permits (“Permits”) required in connection with the Investment and implementation of the Project.</p>
--	---

(b)	Төрийн байгууллага нь ямар ч тохиолдолд тухайн Зөвшөөрлийг олгохоос үндэслэлгүйгээр татгалзах, удаах, хүлээлгэх, саатулахгүй.	(b)	No State Authority shall unreasonably deny, withhold or delay a Permit.
(c)	Засгийн газар нь Төслийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай аливаа Зөвшөөрлийг Монгол Улсын хуульд заасан үндэслэл, журмын дагуу олгох, сунгах болон шинэчлэхэд шаардлагатай бүх дэмжлэгийг үзүүлнэ.	(c)	The Government shall provide all necessary support in granting, extending and renewing any Permit required for conducting Project activities in accordance with grounds and procedures provided under Mongolian law.
(d)	Төсөл хэрэгжүүлэгч компани нь Төсөл хэрэгжих бүх үе шатанд Монгол Улсын хууль, тогтоомжид Зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээр заасан үйл ажиллагааг зохих Зөвшөөрлийг хуульд заасан үндэслэл, журам, нөхцөл, шаардлагыг биелүүлж, Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдээс олж авсны үндсэн дээр эрхэлнэ.	(d)	The Project Company shall conduct activities at all stages of the Project with the necessary Permits in compliance with the laws and regulations of Mongolia, and upon obtaining the Permits pursuant to the relevant legal grounds, procedures, conditions, and requirements from the competent authorities.
(e)	Дээр дурдсан Засгийн газрын үзүүлэх дэмжлэг нь ямар ч тохиолдолд Төсөл хэрэгжүүлэгч болон Хөрөнгө оруулагчийг тухайн Зөвшөөрлийг олж авах болон хүчин төгөлдөр байлгахтай холбоотой хуульд заасан журам, нөхцөл, шаардлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй бөгөөд Засгийн газар нь эрх бүхий байгууллагаас Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тэдгээрийн бүртгэл, хяналтыг явуулах чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь нелөөлөхгүй.	(e)	The aforementioned Government support shall not, under any circumstances, relieve the Project Company or the Investor from compliance with the laws, regulations, conditions, and requirements related to obtaining and maintaining such Permits. The Government shall not interfere in the functions of the relevant competent authorities regarding the issuance, renewal, suspension, reinstatement, or cancellation of Permits, and their registration and monitoring.
(f)	Төсөл хэрэгжүүлэгч компани нь Төсөл хэрэгжих бүх үе шатанд хууль тогтоомжид заасан Тусгай Зөвшөөрлүүдийн нөхцөл шаардлагыг хангаж ажиллах үүрэгтэй.	(f)	The Project Company is obligated to comply with the conditions and requirements for Permits as stipulated by the law at all stages of the Project.
(g)	Энэхүү Гэрээний 3.8 дугаар зүйлийн ерөнхий зохицуулалтыг хөндөхгүйгээр, Засгийн газар гадаад иргэдийг Төсөл дээр	(g)	The Government shall support foreign nationals to work on the Project, and to enter, stay in, or leave Mongolia based on the

<p>ажиллуулах, Монгол Улсын хуулийн хүрээнд шаардсан зөвшөөрөл, виз, холбогдох бичиг баримт дээр үндэслэн Монгол Улсын хилээр нэвтрэх, оршин суух эсхүл гарах зэрэгт дэмжлэг үзүүлнэ. Засгийн газар хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэдийн эхнэр, нөхөр, хамтран амьдрагч болон бусад хамаарал бүхий гэр бүлийн гишүүдэд нэгэн адил дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>permits, visas and other documents required by Mongolian Law. This support shall be provided without prejudice to the generality of this Clause 3.8. The Government shall provide the same level of support for spouses, partners and other dependents of the employed foreign nationals.</p>
---	--

<p>4. ТӨСЛИЙН ШУУД ҮР ӨГӨӨЖ</p> <p>4.1 Төслийн Шууд үр өгөөж</p> <p>(a) Засгийн газар нь Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн Төслийн шууд үр өгөөжийн дийлэнх буюу 51% (тавин нэгэн хувь)-аас доошгүй хувийг хуримтлагдах дүнгээр жил бүр хүртэх бөгөөд Гэрээний 4.2(е)-д заасан аргачлалын дагуу тооцно. (цаашид “Засгийн газрын Төслөөс хүртэх шууд үр өгөөж” гэх).</p> <p>(b) Хэрэв тухайн жилд Гэрээний 4.1(a)-д заасан Засгийн газрын Төслөөс хүртэх шууд үр өгөөж хангагдаагүй тохиолдолд Төсөл хэрэгжүүлэгч компани нь Засгийн газрын Төслөөс хүртэх шууд үр өгөөжийг Төслийн нийт шууд үр өгөөжийн 51% (тавин нэгэн хувь)-д хүргэхэд шаардлагатай нэмэлт төлбөрийг Засгийн газарт нөхөн төлөх үүрэгтэй (цаашид “Өгөөж тохируулах төлбөр”).</p> <p>(c) Гэрээний 4.1(a)-д заасан Засгийн газрын Төслөөс хүртэх шууд үр өгөөжид дараахыг оруулж тооцно:</p> <ul style="list-style-type: none"> (i) Гэрээний 5.5-д заасан Ашигт малтмалын неец ашигласны төлбөр; (ii) аж ахуй нэгжийн орлогын албан татвар; (iii) Гэрээний 7.2-д заасан Терийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд ногдох ногдол ашиг; (iv) ногдол ашгийн суутган татвар; (v) гаалийн албан татвар; (vi) ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл; 	<p>4. DIRECT BENEFITS OF THE PROJECT</p> <p>4.1 Direct Benefits of the Project</p> <p>(a) The Government shall receive no less than 51% (fifty-one percent) of the Project's direct benefits annually on a cumulative basis, starting from the Effective Date of the Agreement, as calculated in accordance with the methodology specified in Clause 4.2(e) of the Agreement (hereinafter referred to as the “Direct Benefits of the Project to the Government”).</p> <p>(b) If, in any given year, the Direct Benefits of the Project to the Government as specified in Section 4.1(a) of the Agreement fall short, the Project Company shall make additional payments to the Government to ensure the Direct Benefits of the Project to the Government reach 51% (fifty-one percent) of the Total Direct Benefits of the Project (hereinafter referred to as the “Benefit Adjustment Payment”).</p> <p>(c) The Direct Benefits of the Project to the Government referred to in Clause 4.1(a) of the Agreement shall include the following:</p> <ul style="list-style-type: none"> (i) Royalties referred to in Clause 5.5 of the Agreement; (ii) Corporate Income Tax; (iii) Dividends on State-Owned Preferred Shares referred to in Clause 7.2 of the Agreement;
--	---

(vii)	Гэрээний 11.2(а)-д заасан Орон нутагт оруулах хөрөнгө оруулалт;	(iv)	Withholding Tax on Dividends;
(viii)	Усны нөөц ашигласны төлбөр;	(v)	Customs Duties;
(ix)	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар;	(vi)	Employer Social Security Contributions
(x)	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр;	(vii)	Local Investment referred to in Clause 11.2(a) of the Agreement;
(xi)	Гадаад ажилтны ажлын байрны татвар;	(viii)	Fees for Use of Water Resources;
(xii)	Хүүгийн орлогын суутган татвар;	(ix)	Immovable Property Tax;
(xiii)	Гэрээний 4.1(b)-д заасан Өгөөж тохируулах төлбөр;	(x)	Minerals Licence Fees;
(xiv)	НӨАТ; болон	(xi)	Foreign Employee Workplace Fee;
(xv)	Гэрээний 7.1(d)(vi)-д заасан Бүтээгдэхүүнд хамаарах Маркетингийн төлбөр.	(xii)	Withholding Tax on Interest Income;
		(xiii)	Benefit Adjustment Payment referred to in Clause 4.1(b) of the Agreement;
		(xiv)	VAT; and
		(xv)	Marketing Fees applicable to the Products set forth in Clause 7.1(d)(vi) of the Agreement.

<p>(d) Хөрөнгө оруулагчийн Төслээс хүртэх шууд үр өгөөж гэдэгт дараахыг ойлгоно:</p> <ul style="list-style-type: none"> (i) Татварын дараах ногдол ашгийн; (ii) Маркетингийн төлбөр; (iii) Ноу-хауны төлбөр; болон (iv) зээлийн хүүгийн суутган татварын дараах хүүгийн төлбөр (Хувьцаа эзэмшигчдийн зээл байх тохиолдолд хамаарна) <p>(e) Эдийн засгийн нөхцөл байдал Төсөлд бодитоор буюу ноцтойгоор нелөөлөхүйц материаллаг сөрөг өөрчлөлт орсон тохиолдолд болон энэхүү Гэрээний тогтвортжуулалттай холбоотой бусад заалтуудыг хөндөхгүйгээр Талууд Засгийн газар болон Хөрөнгө оруулагчийн Төслээс хүртэх шууд үр өгөөжийн тэнцвэрийг олох/сэргээх зорилгоор аль нэг Талын гаргасан хүсэлтээр энэхүү Гэрээний нөхцөлүүдийг шударгаар дахин хэлэлцэх бөгөөд үүнд Уурхайн ашиглалтын үйл ажиллагаа нь Төсөл хэрэгжүүлэгч компанийн хувьд ашиггүй болсон нөхцөл мөн хамаарна.</p>	<p>(d) The Direct Benefits of the Project to the Investor shall include the following:</p> <ul style="list-style-type: none"> (i) After-tax dividends; (ii) Marketing Fees; (iii) Know-How Fees; and (iv) After-tax loan interest payments (applicable in case of Shareholder Loans). <p>(e) In the event of a material change in economic circumstances materially impacting the Project, and without prejudice to the other stabilization clauses in this Agreement, at the request of a Party, the Parties shall renegotiate in good faith the terms and conditions of this Agreement to establish/restore the balance of direct benefits of the Project between the Government and the Investor, including in the event that Mining Operations have become unprofitable for the Project Company.</p>
---	--

<p>4.2 Төслийн шууд үр өгөөжийн тайлан</p> <ul style="list-style-type: none"> (a) Талууд нь Төслийн нийт шууд үр өгөөжийг Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн хуримтлагдах дүнгээр жил бүр тооцно. (b) Төслийн нийт шууд үр өгөөж гэдэгт Гэрээний 4.1(c) болон 4.1(d)-д заасан үр өгөөжийн нийлбэрийг ойлгоно (цаашид "Төслийн нийт шууд үр өгөөж" гэх). (c) Төсөл хэрэгжүүлэгч компани нь санхүүгийн жил дууссанаас хойш 120 (нэг зуун хорь) хоногийн дотор Төслийн шууд үр өгөөжийг тооцоолсон тайланг Засгийн газарт жил бүр хүргүүлнэ (цаашид "Төслийн шууд үр өгөөжийн жилийн тайлан" гэх). (d) Төслийн шууд үр өгөөжийн жилийн тайландаа дараах тооцоолол, баримтыг тусгасан байна: <ul style="list-style-type: none"> (i) Төсөл хэрэгжүүлэгч компанийн тухайн жилд холбогдох аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан; (ii) Гэрээний 4.1(a)-д заасан хувийн тооцоолол, тайлбар; болон (iii) Төслийн нийт шууд үр өгөөжийн тооцоолол, задаргаа, тайлбар, танилцуулгын хамт. (e) Гэрээний 4.1(a)-д заасан Засгийн газрын Төслөөс хүртэх шууд үр өгөөжийг дараах аргачлалын дагуу тооцно: <ul style="list-style-type: none"> (i) Гэрээний 4.1(c)-д заасан Засгийн газрын Төслөөс хүртэх шууд үр өгөөжийн 	<p>4.2 Report on Direct Benefits of the Project</p> <ul style="list-style-type: none"> (a) The Parties shall calculate the total Direct Benefits of the Project annually on a cumulative basis starting from the Effective Date. (b) The total Direct Benefits of the Project shall be understood as the sum of the benefits specified in Clauses 4.1(c) and 4.1(d) of the Agreement (hereinafter referred to as the "Total Direct Benefits of the Project"). (c) The Project Company shall submit to the Government an annual report on the calculation of Direct Benefits of the Project within 120 (hundred and twenty) days of the end of the fiscal year (hereinafter referred to as the "Annual Report on Direct Benefits of the Project"). (d) The Annual Report on Direct Benefits of the Project shall include the following calculation and evidence: <ul style="list-style-type: none"> (i) The audited financial report of the Project Company for the relevant year; (ii) Calculation and explanation regarding the ratio set forth in Clause 4.1(a); (iii) Calculation, breakdown, and explanation of the Total Direct Benefits of the Project. (e) The amount of Direct Benefits of the Project to the Government stipulated in Clause 4.1(a) of this Agreement shall be calculated pursuant to the following methodology:
---	---

	хуримтлагдсан нийлбэр дүнг:	(i)	Aggregate amount of the accumulated Direct Benefits of the Project to the Government stipulated in Clause 4.1(c) divided by:
(ii)	Гэрээний 4.1 (c)-д тусгасан Засгийн газрын Төслөөс хүртэх шууд үр өгөөжийн хуримтлагдсан нийлбэр дүн дээр, Гэрээний 4.1(d)-д заасан Хөрөнгө оруулагчийн Төслөөс хүртэх шууд үр өгөөжийн хуримтлагдсан нийлбэрийг нэмсэн дунгээс Гэрээний 3.1(d)-д заасан Анхны хөрөнгө оруулалтын дунг хасаад гарсан дунд хувааж тооцоолно.	(ii)	the sum of the aggregate amount of the accumulated Direct Benefits of the Project to the Government set forth in Clause 4.1(c) and the accumulated Direct Benefits of the Project to the Investor set forth in Clause 4.1(d) less the Initial Investment set forth in Clause 3.1(d).

<p>4.3 Монгол Улсын хуульд орсон материаллаг сэргэг өөрчлөлт ба Дахин хэлэлцэх</p>	<p>4.3 Material Adverse Change in the Mongolian Law and Renegotiation</p>
<p>(a) Энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш хүчин төгөлдөр мөрдөгджөк буй Монгол Улсын хуульд орсон аливаа өөрчлөлтийн таван (5) жилийн хугацаанд хуримтлагдсан үр дагавар нь Төсөл хэрэгжүүлэгч компанийн зардлыг 10 (арав) буюу түүнээс дээш хувиар нэмэгдүүлэх тохиолдлыг "Монгол Улсын хуульд орсон материаллаг сэргэг өөрчлөлт" гэж үзнэ.</p> <p>(b) Монгол Улсын хуульд материаллаг сэргэг өөрчлөлт орсон тохиолдолд Төсөл хэрэгжүүлэгч компани нь энэхүү өөрчлөлтийн үр дагаврыг материаллаг сэргэг нөлөөллийг тогтоосон өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор Засгийн газарт бичгээр мэдэгдэнэ. Мэдэгдэлд дараах зүйлсийг тусгана:</p> <ul style="list-style-type: none"> (i) Сэргэг нөлөөлөл бүхий Монгол Улсын холбогдох хууль, түүний Төсөлд үзүүлж буй серег нөлөөллийн талаарх дэлгэрэнгүй тайлбар; болон (ii) Төсөл хэрэгжүүлэгч компанийн зардлын өсөлтийг харуулсан санхүүгийн тайлан эсхүл санхүүгийн төсөөлөл. 	<p>(a) For the purpose of this Agreement, any changes in the Mongolian Law enacted or enforced after the Date of Signature shall be considered as a "Material Adverse Change in the Mongolian Law" when their cumulative effect results in an increase of the Project Company costs by 10% (ten percent) or more over a duration of five (5) years.</p> <p>(b) In the event of a Material Adverse Change in the Mongolian Law, the Project Company shall provide written notice to the Government within 30 (thirty) days of determining the impact of such change, including:</p> <ul style="list-style-type: none"> (i) a detailed description of the relevant Mongolian Law and its impact on the Project; and (ii) financial statements or projections demonstrating the increase to the costs of the Project Company.

<p>(c) Дээрх 4.3(b)-д заасан мэдэгдлийг хүлээн авсны дараа Засгийн газар болон Хөрөнгө оруулагч талын эдийн засгийн үр өгөөжийн тэнцвэрт байдал, хувь хэмжээг Талууд шударгаар авч үзэж хянах ба шаардлагатай бол дахин хэлэлцэнэ. Дахин хэлэлцэх үйл явц нь:</p> <ul style="list-style-type: none"> (i) Засгийн газар мэдэгдэл хүлээн авснаас хойш 60 (жар) хоногийн дотор эхлэх; ба (ii) Монгол Улсын хуульд орсон сөрөг өөрчлөлтийн санхүүгийн сөрөг нөлөөллийг арилгах зорилгоор санхүүгийн үзүүлэлтүүд болон үйл ажиллагааны зохицуулалт, нөхөн олговрын талаар Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхийг хэлэлцэн тохиролцохыг зорино. <p>(d) Талууд 60 (жар) хоногийн дотор тохиролцоонд хурч чадаагүй бол энэ Гэрээний 18 дахь заалтыг хэрэглэнэ.</p>	<p>(c) Upon receipt of the notice, the Parties shall reconsider/review, in good faith, and if appropriate, renegotiate the balance and share of economic benefits between the Government and the Investor. The renegotiation process shall:</p> <ul style="list-style-type: none"> (i) Commence within 60 (sixty) days of the notice being received by the Government; and (ii) Aim to agree on amendments, including but not limited to, fiscal terms, operational adjustments, or compensation mechanisms, to offset the adverse financial impact of the Adverse Change in the Mongolian Law. <p>(d) If the Parties fail to reach an agreement within 60 (sixty) days, then Clause 18 of this Agreement shall apply.</p>
--	--

<p>4.4 Монгол Улсын хууль тогтоомжид таатай өөрчлөлт орох.</p>	<p>4.4 Beneficial Change in the Mongolian Law</p>
<p>Энэхүү Гэрээний 4.3 дүгээр зүйлийг үл харгалзан, Төсөл хэрэгжүүлэгч компанид аливаа байдлаар таатайгаар нөлөөлөх энэхүү Гэрээнд зааснаас бага татварын хувь хэмжээ болон үндсэн хөрөнгөд элэгдэл хорогдол тооцох, алдагдал шилжүүлэх хугацаа тогтоосон эсхүл Төсөл хэрэгжүүлэгч компанийн энэхүү Гэрээнд заасны дагуу төлбөл зохих татварын хэмжээг ямар нэг байдлаар бууруулсныг оруулаад зөвхөн үүгээр хязгаарлагдахгүйгээр Монгол Улсын хууль тогтоомжид орсон өөрчлөлтийн аливаа таатай нөхцөлийг Төсөл хэрэгжүүлэгч компани нь тийнхүү таатай өөрчлөлтийг эдлэх хүсэлтээ Засгийн газарт бичгээр илэрхийлэн мэдэгдэх замаар уг таатай нөхцөлүүдийг эдлэх эрхтэй болно. Энэ тохиолдолд:</p>	<p>Notwithstanding Clause 4.3 of this Agreement, the Project Company shall be entitled to benefit from any Change in the Mongolian Law that positively impacts the Project Company, including but not limited to, a lower tax rate than that specified in this Agreement, a depreciation period for fixed assets, a loss carryforward period, or any reduction in the amount of tax payable by the Project Company under this Agreement, by notifying the Government in writing of its request to benefit from such favorable changes. In such cases:</p>

<p>(c) Уг Монгол Улсын хууль тогтоомжид орсон өөрчлөлт нь хүчин төгөлдөр болсон өдрөөсөө эхлэн Төсөл хэрэгжүүлэгч компанийд үйлчилж эхлэх ба тухайн холбогдох Монгол Улсын хууль тогтоомжид орсон өөрчлөлтэд заасан хугацаагаар үйлчилнэ.</p> <p>(d) Хожим Монгол Улсын хууль тогтоомжид орсон өөрчлөлт нь өмнөх Монгол Улсын хууль тогтоомжид орсон өөрчлөлтийг Төсөл хэрэгжүүлэгч компанийн хувьд ашиггүй болгосон гэж Төсөл хэрэгжүүлэгч компанийн үзвэл Төсөл хэрэгжүүлэгч компани нь холбогдох Монгол Улсын хууль тогтоомжид орсон өөрчлөлтөөс өмнө үйлчилж байсан хамгийн таатай эрх зүйн байдалд буцах тухай шийдвэрээ Засгийн газарт бичгээр мэдэгдсэнээр холбогдох Монгол Улсын хууль тогтоомжид орсон өөрчлөлтөөс өмнө үйлчилж байсан хамгийн таатай эрх зүйн байдлыг буцаан эдлэх эрхтэй бөгөөд хамгийн таатай эрх зүйн байдал нь хожим Монгол Улсын хууль тогтоомжид орсон өөрчлөлт үйлчилж эхлэх өдрөөс эхлэн үйлчилнэ.</p>	<p>(a) Such Change in the Mongolian Law shall be applicable to the Project Company from the date it comes into force, and for the duration specified in the relevant Change in the Mongolian Law if any.</p> <p>(b) If there is a further Change in the Mongolian Law that results in the previous Change in the Mongolian Law no longer benefiting the Project Company in their view, the Project Company shall have the right to be returned to the most favorable legal regime prior to the relevant Change in the Mongolian Law upon notification in writing to the Government of its decision to return to the most favorable legal regime prior to the relevant Change in the Mongolian Law, in which case the most favorable legal regime shall apply from the further Change in the Mongolian Law.</p>
--	--

5. ТАТВАР	5. TAXATION
5.1 Тогтвортжуулсан татварын орчин	5.1 Stabilized Tax Environment
(a) Тогтвортжуулах хугацааны туршид Талууд нь Гарын үсэг зурсан өдрийн байдлаар хучин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Төсөл хэрэгжүүлэгч компаниас төлөх энэ Гэрээний 5.2-д заасан Тогтвортжуулсан татваруудын хувь хэмжээ болон үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол тооцох хугацаа, татварын албаны баталгаажуулсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох хугацааг тогтвортжуулахаар харилцан тохиролцсон болно.	(a) The Parties mutually agree to stabilize, during the Stabilization Period, the Stabilized Tax rates, the asset depreciation and amortization period and the loss carry forward period for losses approved by tax authorities listed in Clause 5.2 of this Agreement to be paid by the Project Company in accordance with the Mongolian Law in force as of the Date of Signature.
(b) Тогтвортжуулах хугацаанд Тогтвортжуулсан татварын хувь хэмжээ, үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол тооцох хугацаа, татварын албаны баталгаажуулсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох хугацааг Монгол Улсын хууль тогтоомжоор өөрчилсөн аливаа өөрчлөлт нь Төсөл хэрэгжүүлэгч компанийд сергээр нэлэөлөх тохиолдолд Төсөл хэрэгжүүлэгч компанийд үйлчлэхгүй.	(b) Any Change in the Mongolian Law regarding the Stabilized Tax rates, asset depreciation and amortization period and the loss carry forward period for losses approved by tax authorities occurring during the Stabilization Period that negatively affect the Project Company shall not be applicable to the Project Company.
(c) Төсөл хэрэгжүүлэгч компанийн харьяалах татварын албаар баталгаажуулсан ирээдүйд шилжүүлэн тооцох алдагдлыг тухайн алдагдал гарсан татварын жилийн дараах дараалсан дөрвөн (4) жилийн хугацаанд Монгол Улсын холбогдох татварын хууль, тогтоомжийн дагуу хасаж тооцно.	(c) The loss carried forward, as approved by the relevant tax authority, shall be applied in accordance with the relevant tax laws and regulations of Mongolia for a period of four (4) consecutive years following the tax year in which the loss was incurred.

<p>(d) Төсөл хэрэгжүүлэгч компанийн хувьд Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасан үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол тооцох хугацааг Тогтвортжуулах хугацааны туршид тогтвортжуулна.</p>	<p>(d) For the Project Company, the depreciation and amortization period specified in Article 17.1 of the Law on Corporate Income Tax shall be stabilized during the Stabilization Period.</p>
<p>(e) Гарын үсэг зурсан өдрийн байдлаар Монгол Улсын хуульд заасан албан татваруудаас бусад өөр шинэ төрлийн албан татварыг төлөх үүрэг Төсөл хэрэгжүүлэгч компанийд үүсэхгүй болохыг Талууд хүлээн зөвшөөрч байна.</p>	<p>(e) The Parties agree that the Project Company shall not be subject to any new Tax other than the ones set out in the Mongolian Law as of the Date of Signature.</p>
<p>5.2 Тогтвортжуулсан татвар</p> <p>(a) Төсөл хэрэгжүүлэгч компанийд хамаарах Тогтвортжуулсан татвар нь дараах татварууд байна:</p> <ul style="list-style-type: none"> (i) аж ахуйн нэгжийн орлогын албан татвар; (ii) НӨАТ; (iii) Гэрээний 5.5(b)-д заасан Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрүүдийн нийлбэр; болон (iv) гаалийн тариф, гаалийн татвар. 	<p>5.2 Stabilized Taxes</p> <p>(a) The Stabilized Taxes in relation to the Project Company shall be the taxes listed below:</p> <ul style="list-style-type: none"> (i) corporate income tax; (ii) VAT; (iii) A sum of Royalties set forth in Clause 5.5(b) of this Agreement; and (iv) customs tariffs and customs duties;
<p>5.3 Татвар тогтвортжуулах хугацаа</p> <p>Тогтвортжуулах хугацаа нь Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн Анхны хугацаа болон Гэрээг сунгах хугацааг оролцуулан энэхүү Гэрээний Хүчин төгөлдөр үйлчлэх хугацаатай тэнцүү байна.</p>	<p>5.3 Duration of Tax Stabilization</p> <p>The Stabilization Period shall be equal to the Term of this Agreement, including the Initial Term and extended Term starting from the Effective Date.</p>
<p>5.4 Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн эсрэг дүрэм</p>	<p>5.4 The Inclusive Framework on Base Erosion and Profit Shifting</p>

<p>(a) Монгол Улс нь ЭЗХАХБ-ийн Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн эсрэг санаачилгын гишүүн орон болохын хувьд энэхүү Төслийн хүрээнд хийгдэх аливаа ажил гүйлгээ нь ЭЗХАХБ-ийн зөвлөмж, татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн эсрэг дүрэмд нийцсэн байх ёстой гэдгийг Хөрөнгө оруулагч болон Төсөл хэрэгжүүлэгч компани хүлээн зөвшөөрч байгаа болно. Энэ явдлыг хангах зорилгоор энэхүү Гэрээнд тохирсон аливаа нөхцөл нь татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн эсрэг дүрэм, ЭЗХАХБ-ийн зөвлөмжтэй зөрчилдөх тохиолдолд тухайн зөрчлийг шийдвэрлэхэд ЭЗХАХБ-ийн зөвлөмж, татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн эсрэг дүрэм, Монгол Улсын татварын хууль тогтоомжийг баримтлахаар Талууд тохиролцов.</p>	<p>(a) Both the Investor and the Project Company acknowledge that, for Mongolia, as a member country of the Inclusive Framework on Base Erosion and Profit Shifting (BEPS) of the OECD, any transactions under this Project shall comply with the tax laws of Mongolia, OECD guidelines and BEPS actions. In case any terms in this Agreement conflict with the OECD guidelines and actions against BEPS, the Parties agree to apply the OECD guidelines and actions against BEPS, along with the tax laws of Mongolia, to resolve such conflict.</p>
--	--

	<p>(b) Төсөл хэрэгжүүлэгч компани нь харилцан хамаарал бүхий этгээдтэй хийсэн ажил гүйлгээний үнэ, нөхцөлийг, Know-How-ны төлбөр болон Маркетингийн төлбөрүүдийг оруулан, Бодит үнэ тодорхойлох зарчимд (arm's length principle) нийцүүлэх үүрэгтэй бөгөөд үнэ шилжилтийн тайланг холбогдох хууль тогтоомж, ЭЗХАХБ-ийн үнэ шилжилтийн зөвлөмж, татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн эсрэг дүрмийн дагуу харьяалах татварын албанад тухай бүр тайлагнана.</p> <p>(c) Энэхүү Гэрээнд заасан Ноу Хау-ийн төлбөр болон Маркетингийн төлбөрүүдийн хувь хэмжээ нь татварын зорилгоор бодит үнэ тодорхойлоход ашиглагдахгүй.</p>	<p>(b) The Project Company is obligated to comply with the Arm's Length Principle when determining the price and conditions of transactions with related parties, including, the Know-How Fee and the Marketing Fee, and shall submit the transfer pricing documentation to the relevant tax authority in accordance with applicable legislation, OECD guidelines, and actions against BEPS.</p> <p>(c) The Know-How Fee and the Marketing Fees specified in this Agreement shall not be used to determine the arm's length prices for tax purposes.</p>
5.5	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	5.5 Royalties
	<p>(a) Төсөл хэрэгжүүлэгч компанийд эзэмшиж буй терийн эзэмшлийн 34% (гучин дөрвөн хувь)-тай тэнцэх энгийн хувьцааг Төсөл хэрэгжүүлэгч компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 10% (арван хувь)-тай тэнцэх давуу эрхийн хувьцаа болгон хөрвүүлснийг харгалzan Төсөл хэрэгжүүлэгч компани нь Цөмийн энергийн хуульд заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийг Хавсралт 1-д заасны дагуу төлнө.</p>	<p>(a) In consideration of the conversion of the state's equity interest in the Project Company from 34% (thirty-four percent) ordinary shares to preferred shares equal to 10% (ten percent) share capital of the Project Company, the Project Company shall, pay the Base Royalties, Special Royalties and additional Progressive Royalties under the Law on Nuclear Energy as set forth in the Appendix 1.</p>

	<p>(b) Төсөл хэрэгжүүлэгч компанийн төлөх Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь дараах төлбөрүүдийн нийлбэр байна:</p> <ul style="list-style-type: none"> (i) ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр; (ii) ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөр; болон (iii) ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр. 	<p>(b) Therefore, the Royalties to which the Project Company is subject is the sum of the following:</p> <ul style="list-style-type: none"> (i) the Base Royalties; (ii) the additional Progressive Royalties; and (iii) the Special Royalties.
	<p>(c) Гэрээний 5.5(b)-д заасан Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрүүдийг энэхүү Гэрээний Хавсралт 1-т заасан хувь хэмжээгээр тооцно.</p>	<p>(c) The rates of the Base Royalties, the additional Progressive Royalties and the Special Royalties specified in Clause 5.5(b) are set out in Appendix 1 of this Agreement.</p>
5.6	<p>Гаалийн хяналт шалгалтын тогтолцоо</p> <p>Төсөл хэрэгжүүлэгч компани нь гаалийн хяналт, шалгалтын тогтолцоог ОУАЭА-ийн зөвлөмж болон олон улсын практик, туршлагын дагуу хөгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>5.6 Customs control and inspection system</p> <p>The Project Company shall support the Government in developing the corresponding customs control and inspection regime in accordance with IAEA guidelines and international market practice.</p>

<p>5.7 Татвар ногдох орлогоос хасагдах зардлууд</p> <p>(a) Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн зарчим, шаардлагад нийцсэн, хязгаарлалт хориглолтод хамаарахгүй дараах зардлуудыг татвар ногдох орлогоос хасаж тооцно:</p> <ul style="list-style-type: none"> (i) Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийн зардал; (ii) Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн зардалд хуримтлуулах мөнгөн хөрөнгө (уурхайн ашиглалтын хугацаанд жил бүр тэнцүү дүнгээр); (iii) Ноу-Хау-ийн төлбөр; болон (iv) зээлийн хүү. 	<p>5.7 Deductible Expenses</p> <p>(a) The following expenses, which comply with the principles and requirements of the Law on Corporate Income Tax and are not subject to any restrictions or prohibitions, shall be deductible from taxable income:</p> <ul style="list-style-type: none"> (i) Depreciation and amortization of fixed assets; (ii) Mine Closure and Rehabilitation financial provision (in equal annual amounts over the life of the Mine); (iii) Know-How Fees; and (iv) loan interest.
---	--

5.8 НӨАТ	5.8 VAT
<p>(a) Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдан авсан болон гадаад улсаас Монгол Улсад импортоор оруулсан бүх төрлийн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын үнэлгээнд 10% (арван хувь)-ийн НӨАТ-ыг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу ногдуулна.</p> <p>(b) Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 12.1.7-д заасан бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын үнэлгээнд тэг хувь (0%)-ийн НӨАТ-ыг ногдуулах бөгөөд энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 12.5 дахь хэсгийг үл хөндөнө.</p> <p>(c) Засгийн газар нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 12.5-д заасныг хэрэгжүүлэхэд Тесэл хэрэгжүүлэгч компанийг Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй бусад уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс үл ялгаварлах зарчмыг баримтална.</p>	<p>(a) VAT of 10% (ten percent) shall be imposed in accordance with the Value Added Tax Law on the sales value of the works, products, and services purchased in Mongolia and imported to Mongolia.</p> <p>(b) VAT of zero percent (0%) shall be imposed on the sales value of the works, products, and services specified in Article 12.1.7 of the Value Added Tax Law, without prejudice to Article 12.5 of the Value Added Tax Law.</p> <p>(c) For the purposes of implementing Article 12.5 of the Value Added Tax Law, the Government shall ensure that the Project Company shall be treated on a non-discriminatory basis in comparison to other mining companies.</p>

6. САНХҮҮГИЙН ГОРИМ	6. FINANCIAL REGIME
6.1 Нягтлан бодох бүртгэл	6.1 Accounting
(a) Төсөл хэрэгжүүлэгч компани нь санхүү, нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад заасны дагуу хетелж, тайлagnах бөгөөд ажил, гүйлгээгээ үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр бүртгэж, тайлagnана.	(a) The Project Company shall maintain and report its financial, and accounting records in accordance with the Law on Accounting and international accounting standards, and shall record and report its transactions in MNT.
(b) Төсөл хэрэгжүүлэгч компаниас гуравдагч этгээдтэй хийх аливаа төлбөр нь баталгаажуулах, аудит хийх боломжтой зардал дээр суурилсан байна.	(b) Any payment made by the Project Company to a third party shall be based on verifiable, auditable expenses.
(c) Төсөл хэрэгжүүлэгч компанийн Тусгай зөвшөөрөл бүхий талбай нь хоорондоо хиллэдэг болон ашиглах бүтээгдэхүүний нэр төрөл ижил байх тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн системтэй байх эрхтэй.	(c) The Project Company shall have the right to have a single accounting reporting system provided that the sites under the Licenses border with each other and concern the same commodity.

<p>6.2 Банкны данс, валют, хөрөнгө шилжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> (a) Төсөл хэрэгжүүлэгч компани нь Бүтээгдэхүүний борлуулалтын орлогын 50% (тавин хувь)-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкин дахь дансандаа хүлээн авна. (b) Төсөл хэрэгжүүлэгч компани нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн худалдан авах ажиллагаатай холбоотой төлбөр тооцоог Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкин дахь дансаар хийх үүрэгтэй. (c) Төсөл хэрэгжүүлэгч компани нь дараах эрх эдэлнэ: <ul style="list-style-type: none"> (i) гадаад улсад бүртгэлтэй гэрээт гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч этгээдүүдтэй хийх төлбөр тооцоог гадаад валютаар хийх; болон (ii) дээрх 6.2(a)-д заасан нэхцэл хангагдсан тохиолдолд, Бүтээгдэхүүний борлуулалтаас гадаад улсад олсон орлогыг гадаад улсад нь хадгалах, захиран зарцуулах. (d) Хөрөнгө оруулагч нь ногдол ашиг, шимтгэл, хураамж, ажил 	<p>6.2 Bank Accounts, Currency, Asset Transfers</p> <ul style="list-style-type: none"> (a) The Project Company shall receive cash assets equivalent to at least 50% (fifty percent) of the Product sales revenue in a bank account at a commercial bank registered in Mongolia. (b) The Project Company is required to make payments related to procurement activities conducted within Mongolia through an account at a commercial bank registered in Mongolia. (c) The Project Company shall have the following rights: <ul style="list-style-type: none"> (i) to make payments to contractors and subcontractors registered in foreign countries in foreign currency; and (ii) If the conditions specified in 6.2(a) are met, to retain and dispose of revenue earned from Product sales abroad in the foreign country. (d) The Investor has a right to convert and transfer all legally entitled income and cash assets, such as dividends, fees, payments for work performed and services provided, and principal and interest on loans, into freely convertible foreign currency in foreign countries after paying related taxes on such income and assets.
---	---

гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсний төлбөр, зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр зэрэг хууль ёсны өөрт ногдох бүх орлого, мөнгөн хөрөнгийг тухайн орлого болон хөрөнгөд хамаарах татварыг төлсний үндсэн дээр гадаад улсад, өөрийн сонгосон олон улсад чөлөөтэй хөрвөх гадаад валютад хөрвүүлж, шилжүүлэх эрхтэй.

7. ТӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ХУВЬЦАА	7. STATE-OWNED SHARES
7.1 Төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаа	7.1 State-Owned Preferred Shares
(a) Монгол Улсын Их Хурал нь Цөмийн энергийн хууль болон Компанийн тухай хуульд үндэслэн гаргасан 2024 оны [●]-р сарын [●]-ны өдрийн [●] тоот тогтоолоор, Төсөл хэрэгжүүлэгч компанийд эзэмшиж буй Засгийн газрын эзэмшлийн 34% (гучин дөрвөн хувь)-ийн энгийн хувьцааг Төсөл хэрэгжүүлэгч компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 10% (арван хувь)-тай тэнцэх давуу эрхийн хувьцаанд хөрвүүлэхээр шийдвэрлэснийг Талууд хүлээн зөвшөөрч байна.	(a) Based on the resolution of the State Great Khural of Mongolia dated [●] of [●], 2024, issued pursuant to the Nuclear Energy Law and the Company Law, the Project Company agrees to convert the 34% (thirty-four percent) of common shares owned by the Government into preferred shares equivalent to 10% (ten percent) of the share capital of the Project Company.
(b) Засгийн газар нь Төсөл хэрэгжүүлэгч компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 10% (арван хувь)-тай тэнцэх давуу эрхийн хувьцааг үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ (цаашид “Төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаа” гэх).	(b) The Government shall directly own preferred shares equal to 10% (ten percent) of the share capital of the Project Company free of charge (hereinafter referred to as “State-Owned Preferred Shares”).
(c) Төсөл хэрэгжүүлэгч компанийн нийт гаргасан давуу эрхийн болон энгийн хувьцаанд эзлэх Төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцааны хувь хэмжээг ямар ч нөхцөлд 10% (арван хувь)-аас бууруулахгүй. Эргэлзээг арилгах үүднээс, Төсөл хэрэгжүүлэгч компани дахь Засгийн газар болон Хөрөнгө оруулагчийн хувь эзэмшил нь 10:90 (арвыг харьцах нь ер) байна.	(c) The proportion of State-Owned Preferred Shares in the preferred and common total shares issued by the Project Company shall not be diluted below 10% (ten percent) under any circumstances. For the avoidance of doubt, the ownership ratio of the Government and the Investor in the Project Company shall be 10:90 respectively (ten-ninety).
(d) Төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд дараах онцгой эрхүүд дагалдана. Үүнд:	(d) The State-Owned Preferred Shares shall carry the following special rights: <ul style="list-style-type: none"> (i) The Government shall receive dividends based on the conditions set forth in Clause 7.2 of the Agreement; (ii) The Government shall not be obligated to provide any form of equity or loan

(i)	Засгийн газар нь Гэрээний 7.2-т заасан нөхцөлөөр ногдол ашиг хүртэнэ;		financing to the Project Company.
(ii)	Засгийн газар нь Төсөл хэрэгжүүлэгч компанид аливаа хэлбэрээр өөрийн хөрөнгийн (equity financing) болон зээлийн санхүүжилт хийх үүрэг хүлээхгүй;	(iii)	The Government shall appoint one (1) member out of the 9 (nine) members of the Board of Directors of the Project Company, and the appointed member shall serve as a member of the audit committee;
(iii)	Засгийн газар нь Төсөл хэрэгжүүлэгч компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нийт 9 (ес) гишүүнээс нэг (1) гишүүнийг томилох, ийнхүү томилсон гишүүн нь аудитын хорооны гишүүн байна;	(iv)	In the event of the liquidation of the Project Company, 10% (ten percent) of the distributed assets shall be allocated to the Government;
(iv)	Төсөл хэрэгжүүлэгч компани татан буугдахад хуваарилагдах хөрөнгийн 10% (арван хувь)-тай тэнцэх хувь нь Засгийн газарт ногдоно;	(v)	The Government shall receive any and all information regarding the Project Company as specified in the Company Law, under the same conditions, terms, and content as provided to the Investor, without any confidentiality limitations;
(v)	Засгийн газар нь Компанийн тухай хуульд заасан Төсөл хэрэгжүүлэгч компанийн бүх мэдээллийг “нууцлал”-ын хязгаарлалтгүйгээр, Хөрөнгө оруулагчтай ижил нөхцөл, болзол, агуулгаар хүлээн авна;	(vi)	The Government may purchase 10% (ten percent) of the Product under the same terms and conditions as those of the Investor. Both shareholders of the Project Company shall provide their purchase intention by written notice to the Project Company before the beginning of the fiscal year; and
(vi)	Засгийн газар нь Бүтээгдэхүүний 10 (арв) хувийг Хөрөнгө оруулагчтай ижил нөхцөл, болзлын дагуу худалдан авна. Төсөл хэрэгжүүлэгч компанийн	(vii)	The Government has a right to veto any changes and modifications to the Project Company's charter and ownership structure, reorganization, liquidation,

<p>хоёр хувьцаа эзэмшигчид нь хоёул санхүүгийн жил эхлэхээс өмнө худалдан авах саналаа Төсөл хэрэгжүүлэгч компанийд бичгээр ирүүлнэ; мөн</p> <p>(vii) Засгийн газар нь Төсөл хэрэгжүүлэгч компанийн дүрэм болон хувь эзэмшилд аливаа өөрчлөлт орох, өөрчлөн байгуулах, татан буулгах, Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барыцаалах, баталгаа гаргах түүнд орох нэмэлт, өөрчлөлт зэрэг асуудлаар хориг тавих эрхтэй байна.</p>	<p>transfer or pledge of the Licenses, issuance of guarantees by the Project Company and any changes of modifications thereto.</p>
---	--

<p>7.2 Төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд ногдох ногдол ашиг</p> <p>(a) Өмнөх жилийн 12 сарын 31-ны өдрийн байдааар аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн нийт цэвэр ашгийн 10% (арван хувь)-тай тэнцэх хэмжээний ногдол ашиг жил бур хуваарилах бөгөөд төлөлт хуваахгүй, хойшлууллахгүйгээр хийгдэнэ.</p> <p>(b) Төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох ногдол ашгийг төлөх мянган хөрөнгө дутагдалтай тохиолдолд Засгийн газарт төлөх ногдол ашгийн өглөгөөр хуримтлуулан бүртгэх ба ногдол ашгийн төлбөр хийх боломжтой болмогц тэр даруй Засгийн газарт ногдол ашгийн төлбөрийг хийнэ.</p> <p>(c) Төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд хуваарилсан зарласан болон хуримтлагдсан бүх ногдол ашгийг төлөх хүртэл энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахыг хориглоно.</p>	<p>7.2 Dividends on State-Owned Preferred Shares</p> <p>(a) Dividends equal to 10% (ten percent) of the total net profits based on the audited financial statements as of December 31 of the preceding year, shall be distributed annually to the State-Owned Preferred Shares and paid in full, without division or delay.</p> <p>(b) If there is a shortage of cash preventing the payment of dividends on the State-Owned Preferred Shares, the dividends shall be recorded as accrued dividends payable to the Government and paid as soon as funds are available.</p> <p>(c) No dividends shall be distributed to the common shares until all declared and accrued dividends on the State-Owned Preferred Shares have been fully paid.</p>
--	--

<p>8. БАЙГАЛЬ ОРЧИН, ЭРҮҮЛ АХУЙ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА</p> <p>8.1 Байгаль орчныг хамгаалах</p> <p>(а) Төсөл хэрэгжүүлэгч компани нь Уурхайн талбайд болон Төслийн үйл ажиллагааг явулахдаа Монгол Улсын олон улсын гэрээ, Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Олон улсын стандартад нийцүүлэн, байгаль орчин, хүн, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах үүрэгтэй.</p>	<p>8. ENVIRONMENT, HEALTH, AND SAFETY</p> <p>8.1 Environmental Protection</p> <p>(a) The Project Company shall protect the environment, as well as the health of people, livestock, and animal, when conducting the Project activities and within the Mine Area in compliance with international treaties of Mongolia, the Minerals Law, the Nuclear Energy Law, the Law on Environmental Protection, the Law on Environmental Impact Assessments, the Law on Hazardous and Toxic Chemicals, and other relevant legislation and International Standards.</p> <p>(b) The Project Company shall utilize state of the art equipment and technology with minimal adverse effects on human, livestock, and animal health and the environment throughout all phases of the Project.</p> <p>(c) The Parties shall conduct environmental monitoring, geo-ecological studies, and take radiation control measures using the baseline indicators specified in the Feasibility Study and the Detailed Environmental Impact Assessment throughout all phases of the Project.</p>
--	--

<p>(b) Төсөл хэрэгжүүлэгч компани нь төслийн бүх үе шатанд хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нэлээ хамгийн багатай хамгийн сүүлийн үеийн техник, технологийг (state of the art techniques) ашиглана.</p>	
<p>(c) Талууд нь Техник, эдийн засгийн үндэслэл, Байгаль орчны нэлэөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон суурь үзүүлэлтүүдийг ашиглан Төслийн бүх үе шатанд байгаль орчны мониторинг, геоэкологийн судалгаа, цацрагийн хяналтыг хэрэгжүүлнэ.</p>	
<p>(d) Төсөл хэрэгжүүлэгч компани нь дараах баримт бичгийг Уурхайн ашиглалтын үе шат эхлэхээс өмнө Монгол Улсын хууль тогтоомж, Дүрэм журам болон Олон улсын стандартын дагуу боловсруулж, эрх бүхий байгууллагаар хянуулж, батлуулсан байна:</p>	
<p>(i) Стандарт ажиллагааны үйл жurmuyd (Standard Operating Procedures);</p> <p>(ii) Цацрагийн хамгаалалтын хетелбер;</p> <p>(iii) Уурхайн хаалтын төлөвлөгөө;</p> <p>(iv) Цацраг идэвхт хаягдлын менежментийн төлөвлөгөө;</p> <p>(v) Гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайлан;</p>	<p>(d) Before the Mining Operation Phase begins, the Project Company shall develop the following documents in compliance with the Mongolian Law and the International Standards, and have them reviewed and approved by a competent authority:</p> <ul style="list-style-type: none"> (i) Standard Operating Procedures (SOP); (ii) Radiation Protection Program; (iii) Mine Closure Plan; (iv) Radioactive Waste Management Plan; (v) Disaster Risk Assessment Report; (vi) Health Impact Assessment report; (vii) Environmental Management Plan; (viii) Accident Prevention, Preparedness, Response, and Recovery Plan; (ix) Livestock and Animal Health Impact Assessment; and (x) other documentation required to commence the Mining Operation Phase as stipulated by relevant laws and regulations. <p>(e) The Project Company shall bear all costs necessary to implement the programs, plans, and activities outlined in the documents specified in Clause 8.1(d), and shall submit relevant implementation reports to the competent authority within the timeframe stipulated by relevant laws.</p>

	(vi) Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний тайлан;	(f) The Project Company shall allocate cash reserves as guarantees for implementing the annual Environmental Management Plan in accordance with the procedures specified in the Law on Environmental Impact Assessment.
	(vii) Байгаль орчны менежментийн төлөвлөгөө;	
	(viii) Ослоос сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах, сэргээн босгох төлөвлөгөө;	(g) The Project Company shall be responsible for the costs required to carry out cumulative impact assessments every 10 (ten) years in the local area and the impact zone as stipulated by relevant laws.
	(ix) Мал, амьтны эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний тайлан; болон	(h) The Project Company shall keep all reports related to the Environmental Management Plan, Radiation Protection Program, and other necessary environmental compliance reports publicly accessible, and shall regularly consult with local communities regarding the environmental impacts of Project activities, including effects on water resources, humans, livestock, flora and fauna.
	(x) холбогдох хууль, журамд заасны дагуу Уурхайн ашиглалтын үе шатыг эхлүүлэхэд шаардагдах бусад баримт бичиг.	
(e)	Төсөл хэрэгжүүлэгч компани нь Гэрээний 8.1(d)-д заасан баримт бичгүүдэд тусгасан хетэлбэр, төлөвлөгөө, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх зардлыг хариуцах бөгөөд холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд хэрэгжилтийн тайланг эрх бүхий байгууллагад хүргүүлж баталгаажуулна.	(i) The Project Company shall ensure the general public representation in the environmental and water control and monitoring activities.
(f)	Төсөл хэрэгжүүлэгч компани нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх баталгаа болгож байршуулах мөнгөн хөрөнгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасан журмын дагуу төвлөрүүлнэ.	

<p>(g) Төсөл хэрэгжүүлэгч компани нь холбогдох хууль, тогтоомжид заасан журмын дагуу орон нутаг, нэлөөллийн бүсэд хуримтлагдах нэлөөллийн үнэлгээг 10 (арав) жил тутамд хийлгэж шаардлагдах зардлыг хариуцна.</p> <p>(h) Төсөл хэрэгжүүлэгч компани нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Цацрагийн хамгаалалтын хөтөлбөр болон бусад шаардлагатай байгаль орчны хэрэгжилтийн тайланг олон нийтэд нээлттэй байлгах ба Төсөл хэрэгжих орон нутгийн иргэдтэй Төслийн үйл ажиллагааны байгаль орчин, усны нөөц, хүн, ургамал, ан амьтан, малд үзүүлж буй нелөөллийн талаар тогтмол зөвлөлдөх үүрэгтэй.</p> <p>(i) Төсөл хэрэгжүүлэгч компани нь байгаль орчин, усны хяналт мониторингийн үйл ажиллагаанд олон нийтийн төлөөллийн оролцоог хангах үүрэгтэй.</p>	
---	--

<p>8.2 Байгаль орчныг хамгаалах үүргийн баталгаа</p> <p>Төсөл хэрэгжүүлэгч компани нь Цөмийн энергийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.9 болон 28.10 дахь хэсгийн дагуу байгаль орчныг хамгаалах болон цацрагийн ослоос сэргийлэх үүргээ биелүүлэх баталгаа болгож Зөөвч овоо ордын туршилтын үйлдвэрийн үйл ажиллагааны "Болзошгүй цацрагийн ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө"-нд тодорхойлсон хүний эрүүл мэнд болон байгаль орчинд нэлвөлж болзошгүй эрсдэлийн дагуу тодорхойлсон мөнгөн хөрөнгийг 2019 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Төсөл хэрэгжүүлэгч компани хооронд байгуулсан "Зөөвч овоо ордын үйлдвэрлэлийн туршилттай холбогдуулан Төрийн санд мөнгөн хөрөнгө байршуулах тухай гэрээ"-нд заасны дагуу 900,000 (есен зуун мянган) ам.доллартой тэнцэх хэмжээний мөнгөн дүнг байршуулсан.</p> <p>Төсөл хэрэгжүүлэгч компани нь "Зөөвч овоо ордын үйлдвэрлэлийн туршилттай холбогдуулан Төрийн санд мөнгөн хөрөнгө байршуулах тухай гэрээ"-г дүгнэсэн холбогдох ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу буцаан олгох мөнгөн хөрөнгийг Цөмийн энергийн тухай хуулийн 28.9 болон 28.10 дахь хэсэгт заасан үүргийн баталгааны дүнд оруулан тооцож болно. Эргэлзээг арилгах үүднээс, ийнхүү тооцож шилжүүлсэн мөнгөн хөрөнгө нь Төсөл хэрэгжүүлэгч компанийн зүгээс Цөмийн энергийн тухай хуулийн 28.9-д заасан үүргийг бүрэн биелүүлсэн гэж үзэхгүй бөгөөд мөнгөн хөрөнгийн хэмжээг Засгийн газар тогтооно.</p>	<p>8.2 Guarantee of Environmental Protection Responsibilities</p> <p>In accordance with Articles 28.9 and 28.10 of the Nuclear Energy Law, the Project Company has deposited, as guarantee of implementing its obligations on protection of environment and prevention from radiation accident, a monetary fund determined in accordance with potential risks to human health and environment as defined in the "Plan of actions to take in case of a potential radiation incident" for the operation of the pilot plant on Zuuvch-Ovoo deposit site. The monetary fund corresponds to the monetary sum in MNT equivalent to USD nine hundred thousand (US\$ 900,000) in 2019, as per the "Agreement on the Deposit of Funds to the State Treasury in relation to the Production Trial of the Zuuvch Ovoo Deposit" signed in 2019 and executed between the Ministry of Mining and Heavy Industry and the Project Company.</p> <p>The monetary funds to be returned to the Project Company based on the conclusions of the relevant working group that reviewed performance of the "Agreement on the Deposit of Funds to the State Treasury in relation to the Production Trial of the Zuuvch Ovoo Deposit" may be re-directed as part of the guarantee for the obligations specified under Articles 28.9 and 28.10 of the Law on Nuclear Energy. For the avoidance of doubt, any funds so calculated and transferred shall not constitute full satisfaction of the obligations under Article 28.9 of the Law on Nuclear Energy, and the final amount of such funds shall be determined by the Government.</p>
---	--

<p>8.3 Байгаль орчинд учирсан хохирлыг арилгах</p> <p>(a) Төсөл хэрэгжүүлэгч компани нь Төсөл хэрэгжих бүх үе шатанд хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хохирол учруулсан болох нь үнэлгээгээр тогтоогдвол, байгаль орчинд үзүүлсэн серөг нөлөөллийг арилгах болон алдагдсан экологийн тэнцвэр мөн байгалийн нөөцийг сэргээхийн тулд сөрөг нөлөөллийг Байгаль орчны нарийвчилсан нөлөөллийн үнэлгээнд туссан зорилтот түвшин хүртэл бууруулах шаардлагатай нэмэлт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.</p> <p>(b) Төсөл хэрэгжих бүх үе шатанд Төслийн үйл ажиллагаанаас бий болсон байгаль орчны хортой нөлөөллийн улмаас хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгөд болон мал, амьтны эрүүл мэндэд учирсан хохирол, мөн байгаль орчныг нөхөн сэргээх зардлыг Төсөл хэрэгжүүлэгч компани нь бүрэн хариуцна.</p> <p>(c) Байгаль орчин, хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгөд болон мал, амьтны эрүүл мэндэд учирсан хохирлыг нөхөн төлөх харилцааг Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн дагуу зохицуулна.</p>	<p>8.3 Compensation for Environmental Damage</p> <p>(a) In the event that it is determined by an assessment that the Project Company has caused any harm to human health or the environment at all stages of the Project, the Project Company shall take necessary measures to minimize the negative impact to achieve the target indicators as defined in the Detailed Environmental Impact Assessment, and to remedy the harmful effects on the environment and restore lost ecological balance and natural resources.</p> <p>(b) The Project Company shall be fully responsible for any damage to human health, life, property, or livestock and animal health caused by harmful environmental impacts resulting from Project activities at any stage of Project implementation, as well as for the costs of environmental rehabilitation.</p> <p>(c) Matters related to compensation for damages to the environment, human health, life, property, and livestock or animal health shall be regulated in accordance with the Law of Mongolia on Environmental Protection.</p>
--	---

8.4 Ус ашиглах	8.4 Water Usage
(a) Төсөл хэрэгжүүлэгч компани нь Төсөл хэрэгжихээс өмнөх үеийн орон нутаг, нөлөөллийн бүсэд амьдардаг иргэд, мал, амьтны ундын болон ахуйн хэрэглээний ус, хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд ашиглах усны нөөц, чанарт нөлөөлөхгүй байх шаардлагыг ханган ажиллах үүрэгтэй.	(a) The Project Company is responsible for ensuring that the drinking and domestic water for residents, livestock, and animal residing in or inhabiting the Project implementation locality and impact zone from before the implementation of the Project, as well as water resources intended for agricultural activities, are not affected.
(b) Уран агуулж буй давхаргын дээр орших уст давхарга (цаашид дээд уст давхарга гэх)-ыг Уурхайн ашиглалтын үйл ажиллагаанд ашиглахыг хатуу хориглоно.	(b) The aquifer located above the uranium-containing layer (hereinafter referred to as the "upper aquifer") shall not be used for Mining Operations.
(c) Төсөл хэрэгжүүлэгч компани нь зөвхөн Уран агуулж буй уст давхарга (цаашид "доод уст давхарга" гэх)-ын усыг олборлолт болон технологийн зориулалтаар ашиглах үүрэгтэй.	(c) The Project Company is obligated to use only the water from the uranium-containing aquifer (hereinafter referred to as the "lower aquifer") for extraction and technological purposes.
(d) Төсөл хэрэгжүүлэгч компани нь ус ашиглалтын хэмжээг бууруулах, усны нөөцийг зохицой болон дахин ашиглах, ижил төрлийн уурхайн ашиглалтын үйл ажиллагаанд ашигладаг хамгийн суулийн үеийн (state of the art) технологи, горимыг хэрэглэх үүрэгтэй.	(d) The Project Company shall reduce the volume of water usage, manage responsibly and re-use water resources, and utilize state of the art technologies and methods used in similar mining operations.
(e) Төсөл хэрэгжүүлэгч компани нь усны нөөц, горим, чанарын төлөв байдлын өөрчлөлтөд байнгын ажиглалт, хяналт-шинжилгээ хийх хөтөлбөрийг холбогдох Териин эрх бүхий байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх бөгөөд хяналт-	(e) The Project Company shall implement a constant control and monitoring program for changes in water resources, treatment, and quality, which shall be approved by the relevant State Authority, and connect monitoring points to the national unified network.
	(f) The Project Company is required to regularly calculate and monitor the water balance in the Mine Area taking into account that the groundwater is being recirculated in

	шинжилгээний цэгүүдийг улсын нэгдсэн сүлжээнд холбоно.		a closed circuit through the ISR Method.
(f)	Төсөл хэрэгжүүлэгч компани нь Газрын доор уусган олборлолтын аргаар битүү эргэлтэнд орж байгаа газрын доорх усыг харгалзан үзэж Уурхайн талбайд усны балансын тооцоог тогтмол хийж хянаж байх үүрэгтэй.	(g)	The Project Company shall obtain a water usage permit and use the water based on the contractual agreement in accordance with the Law on Water, and the Law on Payment for the Use of Natural Resources.
(g)	Төсөл хэрэгжүүлэгч компани нь Усны тухай болон Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээний үндсэн дээр ашиглана.	(h)	If the Project Company discovers groundwater resources in its License area at its own cost, it has the right to use them in accordance with the procedures stipulated in the Law on Water.
(h)	Төсөл хэрэгжүүлэгч нь Тусгай зөвшөөрлийн талбайд өөрийн хөрөнгөөр доод уст давхаргад усны нөөц илрүүлсэн бол тэдгээрийг Усны тухай хуульд заасан журмын дагуу ашиглах эрхтэй байна.	(i)	The Project Company shall conduct a safety assessment specified in the Feasibility Study to confirm the absence of vertical water movement penetrating into the upper aquifer.
(i)	Төсөл хэрэгжүүлэгч компани нь дээд уст давхарга руу нэвтрэх доороос дээш чиглэлтэй усны хөдөлгөөн байхгүй болохыг тогтоох зорилгоор Техник эдийн засгийн үндэслэлд заасан аюулгүй ажиллагааны үнэлгээ /safety assessment/-г хийх үүрэгтэй.	(j)	The Project Company shall carry out inspections to identify the risk of contamination of the upper aquifer in accordance with relevant laws and regulations, the Feasibility Study and the International Standards.
(j)	Төсөл хэрэгжүүлэгч компани нь холбогдох хууль тогтооомж, дүрэм журам, Техник, эдийн засгийн үндэслэл болон Олон улсын стандартад заасны дагуу дээд уст давхаргад бохирдол дамжих эрсдэлийг тодорхойлох үүрэгтэй.	(k)	The Project Company is required to establish monitoring wells near the wells used by herders inside the impact zone as determined by the Detailed Environmental Impact Assessment, equipped with online and automated devices, and connect them to the national unified network.
(k)	Төсөл хэрэгжүүлэгч компани нь Байгаль орчны нэлэөллийн нарийвчилсан үнэлгээгээр	(l)	The Project Company shall take technical and organizational measures to prevent the contamination of soil and water by technological solutions (such as those containing uranium, sulfuric acid, etc.), including installing automatic shutoff valves that close

	<p>тодорхойлсон нэлөөллийн бүсийн дотор байгаа малчдын ашигладаг худгуудын ойролцоо мониторингийн цооногийг байгуулж, онлайн болон автомат багажаар тоноглон улсын нэгдсэн сүлжээтэй холбоно.</p> <p>(I) Төсөл хэрэгжүүлэгч компани нь технологийн уусмал (уран, хүхрийн хүчил гэх мэт агуулсан) хөрс, усанд тархаж бохирдуулахаас сэргийлэхийн тулд уусмал урсаж буй хоолойн даралт алдагдахад автоматаар хаагдаж нээгдэх хавхлаг суурилуулах зэрэг техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээ авах үүрэгтэй.</p>	<p>when pressure drops in pipes carrying the solution.</p>
--	---	--

<p>8.5 Олон улсын аудит</p> <p>(a) Төсөл хэрэгжүүлэгч компани нь Уурхайн ашиглалтын үе шат эхэлснээс хойших гурав (3) дахь жилээс эхлэн турван (3) жил тутамд Төслийн үйл ажиллагаа болон технологидоо ОУАЭА-ийн шинжээчдээр хөндлөнгийн аудит хийлгэх ба холбогдох зардлыг хариуцна. (цаашид “Олон улсын аудит” гэх).</p> <p>(b) Засгийн газар нь Олон улсын аудитыг товлох ажлыг зохион байгуулна. Төсөл хэрэгжүүлэгч компани нь Олон улсын аудит хийгдэхэд шаардлагатай мэдээллээр хангаж, бүх талын дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.</p> <p>(c) Төсөл хэрэгжүүлэгч компани болон хэрэв хамааралтай бол аливаа зохицуулагч байгууллага нь Олон улсын аудитын дүгнэлт, зөвлөмжид тусгагдсан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, Олон улсын аудитын тайлан гарснаас хойш зургаан (6) сарын дотор хэрэгжилтийн явцын тайланг Цөмийн энергийн комисст ирүүлэх үүрэгтэй.</p>	<p>8.5 International Audit</p> <p>(a) The Project Company shall be subject to an external audit every three (3) years, starting from three (3) years after the start of the Mining Operation Phase, by experts from the IAEA on its activities including its technology and shall be responsible for covering the related costs. (hereinafter referred to as the “International Audit”).</p> <p>(b) The Government shall organize the scheduling of the International Audit. The Project Company shall provide all necessary information and support for the International Audit.</p> <p>(c) The Project Company and any relevant regulator, are required to fully implement the measures outlined in the conclusions and recommendations of the International Audit, and within six (6) months of the issuance of the International Audit report, shall submit a report on the status of implementation to the Nuclear Energy Commission.</p>
---	---

<p>8.6 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа</p> <p>(a) Төсөл хэрэгжүүлэгч компани нь Төсөл хэрэгжих бүх үе шатанд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай Монгол Улсын хууль, цөмийн аюулгүй байдал, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны холбогдолтой дүрэм, журам, норм болон Олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэгтэй.</p> <p>(b) Төсөл хэрэгжүүлэгч компани нь дээрх 8.6(а)-д заасан үүргээ зохих ёсоор биелүүлж ажиллаагүй тохиолдолд энэхүү Гэрээний 8.3 дугаар заалт үйлчилнэ.</p> <p>(c) Төсөл хэрэгжүүлэгч компани нь химийн хорт болон аюултай бодис ашиглах, хадгалах, тээвэрлэх, экспортлох, импортлохтой холбоотой үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, олон улсын болон үндэсний дүрэм, стандартыг дагаж мөрднө.</p> <p>(d) Төсөл хэрэгжүүлэгч компани нь үйлдвэрлэлийн аюулгүй байдал, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах, цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх талаар сургалтын хөтөлбөрийг хууль тогтоомж, Олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулж хэрэгжүүлнэ.</p>	<p>8.6 Labor Safety, Hygiene, and Operational Safety</p> <p>(a) The Project Company shall comply with the Law of Mongolia on Labor Safety and Hygiene, rules, regulations, norms and International Standards related to nuclear safety, radiation protection and operational safety throughout all phases of the Project.</p> <p>(b) In the event the Project Company fails to properly fulfill its obligations stipulated in Clause 8.6(a), Clause 8.3 of this Agreement shall apply.</p> <p>(c) The Project Company shall follow the relevant legislation, international and national regulations, and standards with regard to the use, storage, transportation, export, and import of hazardous and toxic chemicals.</p> <p>(d) The Project Company is required to develop and implement a training program on industrial safety, radiation protection and safety, prevention of radiation accidents and safety practices in accordance with legal requirements and International Standards, and to have it approved by the competent authority.</p>
--	---

9. ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ	9. WASTE MANAGEMENT
9.1 Энгийн хог хаягдлын менежмент <p>Төсөл хэрэгжүүлэгч компани нь уурхайн үйл ажиллагаа болон ахуйн хэрэглээнээс үүсэх ахуйн хог хаягдлын хэмжээг бууруулах, эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, дахин боловсруулах менежментийг хийх хамгийн сүүлийн үеийн (state of the art) технологийг нэвтрүүлэн хэрэгжүүлнэ.</p>	9.1 Management of General Waste <p>The Project Company shall implement the state of the art technology for managing the reduction of domestic waste generated from mining activities and domestic use by sorting and recycling waste at the source.</p>
9.2 Аюултай хог хаягдлын менежмент <ul style="list-style-type: none"> (a) Төсөл хэрэгжүүлэгч компани нь Хог хаягдлын тухай хуулийн дагуу аюултай хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх, холбогдох зардлыг бүрэн хариуцах үүрэгтэй. (b) Төсөл хэрэгжүүлэгч компани нь өөрийн үйл ажиллагаанаас үүссэн аюултай хог хаягдлыг дахин боловсруулах, устгуулах зорилгоор холбогдох үйлдвэрлэлийн салбарт тусгай зөвшөөрөл бүхий этгээдэд шилжүүлэн егч болно. Монгол Улсад тухайн аюултай хог хаягдлыг дахин боловсруулах, устгах, хадгалах тусгай зөвшөөрөлтэй этгээд байхгүй тохиолдолд аюултай хог хаягдлыг дахин боловсруулах, устгах үйл ажиллагааг Уурхайн талбайд хэрэгжүүлнэ. 	9.2 Management of Hazardous Waste <ul style="list-style-type: none"> (a) The Project Company is responsible for implementing hazardous waste management in accordance with the Law on Waste and fully covering the associated costs. (b) The Project Company may transfer hazardous waste generated from its activities to a licensed company in the corresponding industrial sector for the purpose of recycling or disposal. If there is no licensed company in Mongolia for recycling, disposal, or storage of such hazardous waste, the Project Company shall carry out recycling and disposal operations in the Mine Area.

<p>9.3 Цацраг идэвхт хаягдлын менежмент</p> <ul style="list-style-type: none"> (a) Төсөл хэрэгжүүлэгч компани нь цацраг идэвхт хаягдлыг Уурхайн талбайд ангилах, ялгах, боловсруулах, аюулгүй булшлах, эдгээр үйл ажиллагаатай холбоотойгоор байгаль орчныг нөхөн сэргээх асуудлыг бүрэн хариуцаж гүйцэтгэх үүрэгтэй. (b) Төсөл хэрэгжүүлэгч компани нь "Цацраг идэвхт хаягдлын менежментийн төлөвлөгөө"-г Уурхайн ашиглалтын үе шат эхлэхээс өмнө холбогдох хууль тогтоомж, дүрэм, Олон улсын стандартын дагуу боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх үүрэгтэй. (c) Төсөл хэрэгжүүлэгч компани нь Төсөл хэрэгжих бүх үе шатанд бага цацраг идэвхт хаягдлын менежментийг хэрэгжүүлэх бөгөөд холбогдох хууль тогтоомж болон Олон улсын стандартыг баримтлан шилдэг туршлагыг нэвтрүүлэх үүрэгтэй. 	<p>9.3 Management of Radioactive Waste</p> <ul style="list-style-type: none"> (a) The Project Company shall take the full responsibility for sorting, separation, processing, and safe disposal of radioactive waste in the Mine Area, as well as for environmental remediation related to these activities. (b) Before the commencement of the Mining Operation Phase, the Project Company is required to develop a "Radioactive Waste Management Plan" in accordance with relevant legislation, regulations, and International Standards, and to have it approved by the competent authority. (c) The Project Company shall implement low radioactive waste management at all phases of the Project, and ensure application of best practices in accordance with the relevant legislation and International Standards.
--	--

<p>10. УУРХАЙН ХААЛТ БОЛОН ХААЛТЫН ДАРААХ МОНИТОРИНГ, ЗАСВАР АРЧИЛГАА</p> <p>10.1 Уурхайн хаалт</p> <ul style="list-style-type: none"> (a) Төсөл хэрэгжүүлэгч компани нь байгаль орчны нөхөн сэргээлтийг хэрэгжүүлэх үеэр холбогдох хууль тогтоомж болон ОУАЭА-ийн зөвлөмжүүдийг оролцуулан Олон улсын стандартын дагуу нөхөн сэргээлт, мониторинг хийж гүйцэтгэнэ. (b) Хөрөнгө оруулагч болон Төсөл хэрэгжүүлэгч компани нь Уурхайг түр болон хэсэгчлэн хаах бодит нөхцөл байдал үүссэн үед хүсэлтийг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ. (c) Төсөл хэрэгжүүлэгч компани нь нөхөн сэргээлтийг Уурхайн ашиглалтын үе шатанд хэрэгжүүлж эхлэх нөхцөл бүрдсэн бол ашиглаж дууссан шахалтын болон олборлолтын цооногуудыг газрын доорх усыг нөхөн сэргээх зорилгоор нээлттэй үлдээх тохиолдолд цооногийн хийцийн бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавих, мониторинг хийх үүрэгтэй. (d) Төсөл хэрэгжүүлэгч компани нь Уурхайн ашиглалтын үе шат эхлэхээс өмнө Уурхайн хаалтын төлөвлөгөөг холбогдох хууль тогтоомж болон ОУАЭА-ийн зөвлөмжүүдэд нийцүүлж боловсруулах бөгөөд холбогдох журам, нөхцөлийн дагуу эрх бүхий байгууллагаар батлуулна. Уурхайн хаалтын төлөвлөгөөг таван (5) жил 	<p>10. MINE CLOSURE, POST-CLOSURE MONITORING AND MAINTENANCE</p> <p>10.1 Mine Closure</p> <ul style="list-style-type: none"> (a) The Project Company shall carry out rehabilitation and monitoring in accordance with relevant legislation and International Standards, including IAEA guidelines. (b) If a justifiable situation arises where a temporary or partial Mine Closure is necessary, the Investor and the Project Company shall notify the competent authority in accordance with the procedures specified in relevant legislation. (c) If the conditions are met to begin rehabilitation during the Mine Operation Phase, the Project Company shall commence rehabilitation, and if it is necessary for rehabilitation purpose to leave used injection and extraction wells open for groundwater remediation, the Project Company shall regularly monitor and check the integrity of such boreholes. (d) The Project Company is required to develop a Mine Closure Plan in accordance with relevant legislation and IAEA guidelines before the Mining Operation Phase begins, and to obtain approval from the competent authority in accordance with relevant procedures and conditions. The Mine Closure plan shall be updated and approved every five (5) years and finalized at least five (5) years before the commencement of the Mine Closure and Rehabilitation Phase begins.
---	---

тутам шинэчлэн батлуулах
бөгөөд Уурхайн хаалт, нөхөн
сэргээлтийн үе шат эхлэхээс
тав (5)-аас доошгүй жилийн
өмнө эцэслэн батлуулна.

<p>10.2 Уурхайн хаалт, нөхөн сэргээлт дуусах</p> <p>(a) Төсөл хэрэгжүүлэгч компани нь Уурхайн хаалт, нөхөн сэргээлт, хяналт мониторинг явуулах ажлыг Уурхайн хаалтын төлөвлөгөөнд заасны дагуу зохих ёсоор, бүрэн гүйцэт хийж гүйцэтгэх үүрэгтэй.</p> <p>(b) Төсөл хэрэгжүүлэгч компани нь ОУАЗА-ийн ТЕКДОК-1239 (Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 160 дугаар тогтоолын хавсралт)-д заасан олон улсын сайн туршлагад нийцсэн, эсхул Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн үе шат хэрэгжих үед үйлчилж буй аливаа бусад холбогдох аргачлалд үндэслэсэн технологийн шийдлүүдийг ашиглан газрын доорх усны чанарыг нөхөн сэргээх үүрэгтэй. Газрын доорх усны нөхцөлийг ОУАЗА-ийн зөвлөмжийн дагуу Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнөх үеийн буюу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон шатлал бүхий түвшинд, усны хэрэглээний анхны ангилал хүртэл нөхөн сэргээж, 10 (арав)-аас доошгүй жилийн хугацаанд хяналт тавих үүрэгтэй. Холбогдох Төрийн эрх бүхий байгууллагуудаар хянуулан баталгаажуулсны дараа Уурхайн хаалтын төлөвлөгөөг хэрэгжүүлж дууссан гэж үзэж, холбогдох Төрийн эрх бүхий байгууллага нь Төсөл хэрэгжүүлэгч компанид Уурхайн нөхөн сэргээлт дууссан тухай тодорхойлолт олгоно.</p>	<p>10.2 Completion of Mine Closure and Rehabilitation</p> <p>(a) The Project Company shall carry out the Mine Closure, rehabilitation, and monitoring tasks in a proper and complete manner in accordance with the Mine Closure Plan.</p> <p>(b) The Project Company shall remediate groundwater quality using technology solutions corresponding to international best practices, specified in the IAEA-TECDOC-1239 (annex of the Cabinet Resolution No.160 of 20 April 2015) or any appropriate methodologies in force at the time of the Mine Closure and Rehabilitation Phase. Groundwater conditions shall be remediated in accordance with IAEA guidelines to the original or pre-Project commencement category of groundwater usage at the grade level specified in the Environmental Impact Detailed Assessment and monitored over a period of not less than 10 (ten) years. After review and approval by the relevant State Authority, it shall be deemed that the Mine Closure Plan is completed, and the relevant State Authority shall provide the Project Company with a certificate of completion of Mine rehabilitation.</p>
--	--

(c)	Төсөл хэрэгжүүлэгч компани нь аливаа цооногийг хаах эсхүл нээлттэй үлдээх асуудлыг Орд ашиглах гэрээгээр нарийвчлан тусгаж зохицуулна.	(c)	The Project Company shall address in detail the concerns related to closing or leaving any borehole open in the Deposit Development Agreement.
(d)	Төсөл хэрэгжүүлэгч компани нь уурхай, үйлдвэрийн хаалт, нехэн сэргээлт, хаалтын дараах засвар арчилгаанд зарцуулах мөнгөн хөрөнгийг Цөмийн энергийн тухай хуульд нийцүүлэн тооцож, бурдуулна. Төсөл хэрэгжүүлэгч компани нь энэ мөнгөн хөрөнгийг Техник, эдийн засгийн үндэслэлд заасан жилийн үйлдвэрлэлийн хэмжээнд хувь тэнцүүлэн тогтоохыг эрмэлзэнэ.	(d)	The Project Company shall calculate and allocate funds for mine and plant closure, rehabilitation, and post-closure maintenance in compliance with the Nuclear Energy Law. The Project Company shall endeavour to calculate these funds proportionally to the annual Production Volume specified in the Feasibility Study.

<p>11. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ</p> <p>11.1 Нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах</p> <ul style="list-style-type: none"> (a) Төсөл хэрэгжүүлэгч компани нь Дорноговь аймгийн Засаг дарга, Төсөл хэрэгжих Улаанбадрах сумын Засаг даргатай энэ Гэрээ болон хууль, тогтоомжид заасан нехцөлөөр гурван талт хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллана (цаашид "Хамтын ажиллагааны гэрээ" гэх). (b) Хамтын ажиллагааны гэрээгээр энэхүү гэрээнд заасан чиглэл болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд талуудын нээлттэй ил тод байдлыг хангах, олон нийтийн итгэлийг даах нехцөлийг бүрдүүлэх, иргэдийн үзэл бодолд хүндэтгэлтэй хандаж асуудлыг шийдвэрлэх, тухайн бүс нутагт иргэд ажиллаж амьдрахад тулгамдаж буй болон нэн шаардлагатай байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөн хандив, тусламж үзүүлэх замаар орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих асуудлыг зохицуулна. (c) Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд Дорноговь аймаг, Улаанбадрах сум орон нутгийн хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх, зохион байгуулах, түүнийг дараах байдлаар санхүүжүүлэхэд чиглэнэ: <ul style="list-style-type: none"> (i) орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, боловсрол, эрүүл мэнд, соёл болон дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх; 	<p>11. LOCAL DEVELOPMENT</p> <p>11.1 Collaboration with Local Administrative Organizations</p> <ul style="list-style-type: none"> (a) The Project Company shall establish a trilateral cooperation agreement with the Governor of Dornogovi aimag and the Governor of Ulaanbadrakh Soum, where the Project will be implemented, in accordance with this Agreement and the conditions outlined in laws and regulations (hereinafter referred to as the "Cooperation Agreement"). (b) The Cooperation Agreement shall ensure openness and transparency among the parties within the scope of this Agreement and relevant legislation, create conditions to obtain public trust, respectfully address issues regarding the opinions of the citizens, plan projects and activities necessary for the livelihood of the citizens in the region, and promote local economic development through contributions and assistance. (c) Within the framework of the Cooperation Agreement, efforts shall be directed toward organizing and implementing local development objectives in Dornogovi aimag and Ulaanbadrakh Soum as well as financing them in the following ways: <ul style="list-style-type: none"> (i) Improving the quality of life for local residents, investing in education, health, culture and infrastructure; (ii) Training and qualifying personnel necessary for local needs and increasing job opportunities;
---	---

	<p>(ii) орон нутагт шаардлагатай боловсон хүчнийг бэлтгэх, мэргэшүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх;</p> <p>(iii) Төсөл хэрэгжих бус нутгийн эдийн засгийг хөгжүүлэх;</p> <p>(iv) иргэдийн итгэлцлийг нэмэгдүүлж, төсөл хэрэгжих явцад ил тод байдлыг хангах; болон</p> <p>(v) хандив тусlamж, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх замаар орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах мөн Дорноговь аймгийн тогтвортой, урт хугацааны хөгжил, Дорноговь аймаг, тэр тусмаа Улаанбадрах сумын иргэдийн амьжиргааг дээшлүүлэх төсөл хөтөлбөрүүдийг дэмжих.</p>	<p>(iii) Developing the economy of the region where the Project is implemented;</p> <p>(iv) Increasing public trust and ensuring transparency during Project implementation; and</p> <p>(v) Contributing to local development through funding for donations, projects, and activities, and supporting projects and programs towards the sustainable and long-term development of Dornogovi aimag and improving the livelihoods of the people of Dornogovi aimag and Ulaanbadrakh soum in particular.</p>
(d)	Төсөл хэрэгжүүлэгч компани нь өөрийн ажилчдыг гэр бүлийн хамтаар Дорноговь аймаг болон Улаанбадрах суманд шилжин сурьших нөхцөлийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлнэ.	(d) The Project Company shall create and support conditions for its employees to relocate to Dornogovi aimag and Ulaanbadrakh Soum with their families.
(e)	Төсөл хэрэгжүүлэгч компани нь төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг дэмжихдээ үр нөлөө, өгөөжийг үндсэн шалгуур болгон санхүүжүүлнэ.	(e) The Project Company shall finance projects, programs, and activities based on the effectiveness and benefits as the primary criteria.
(f)	Төсөл хэрэгжиж дууссаны дараа ашиглагдах дэд бүтцийг орон нутагт үнэ төлбөргүйгээр шилжүүлнэ.	(f) The infrastructure that can be used after completion of the Project, shall be transferred to the local community free of charge.
		(g) The Project Company shall deliver an annual report within 30 (thirty) days after the end of the financial year regarding the work completed and the implementation of selected projects under the Cooperation Agreement to the parties of the Cooperation Agreement and make this information publicly available.

<p>(g) Төсөл хэрэгжүүлэгч компани нь санхүүгийн жил дууссанаас хойш 30 (гуч) хоногийн дотор Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд сонгогдсон төслийдтэй холбогдуулан хийж гүйцэтгэсэн ажил болон эдгээр төслийдийн хэрэгжилтийн талаарх жилийн тайланг Хамтын ажиллагааны гэрээний талуудад хүргүүлж, олон нийтэд ил тод мэдээлнэ.</p> <p>(h) Төсөл хэрэгжүүлэгч компани нь байгаль орчны нэлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон мал, амьтны эрүүл мэндийн нэлөөллийн үнэлгээгээр Төслийн нэлөөлөлд өртөх бүсийг малгүй бус болгох шаардлагатай гэж тодорхойлсон тохиолдолд малчдыг нүүлгэн шилжүүлэхэд туслах, нэхэн олговор олгоно.</p>	<p>(h) The Project Company shall provide assistance and compensation for the relocation of herders if the Detailed Environmental Impact Assessment and Livestock and Animal Health Impact Assessment determine that the Project impact zone is required to be designated as livestock-free zone.</p>
--	--

<p>11.2 Орон нутагт хийх хөрөнгө оруулалт</p> <ul style="list-style-type: none"> (a) Төсөл хэрэгжүүлэгч компанийн жил тутамд Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хийх хөрөнгө оруулалтын хэмжээ нь: (i) Бүтээн байгуулалтын үе шатанд USD300,000 (гурван зуун мянган ам.доллар); (ii) Уурхайн ашиглалтын үе шатанд USD1,000,000 (нэг сая ам.доллар); болон (iii) Уурхайн ашиглалтын үе шат дууссанаас хойш 10 (арав) жилийн хугацаанд USD1,100,000 (нэг сая нэг зуун мянган ам.доллар). (цаашид “Орон нутагт оруулах хөрөнгө оруулалт” гэх) 	<p>11.2 Local Investment</p> <ul style="list-style-type: none"> (a) The annual investment amount to be made by the Project Company under the Cooperation Agreement shall be: <ul style="list-style-type: none"> (i) USD300,000 (three hundred thousand) during the Construction Phase; (ii) USD1,000,000 (one million) during the Mining Operation Phase; and (iii) USD1,100,000 (one million one hundred thousand) during a period of 10 (ten) years from the end of the Mining Operation Phase. <p>(hereinafter referred to as "Local Investment")</p>
---	---

<p>11.3 Үндэсний ханган нийлүүлэгчдийг дэмжих</p> <p>(a) Төсөл хэрэгжүүлэгч компани нь Төсөл хэрэгжих бүх үе шатанд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, туслан гүйцэтгэгч сонгоход тэргүүн ээлжид техник, чанар, аюулгүй байдлын, байгаль орчны стандартын шаардлага, хүний эрх, комплаенс ба гадаад өрсөлдөгчидтэй харилцан өрсөлдөхүйц үнэ, хүргэлтийн нехцелийг хангасан бараа, ажил, үйлчилгээ бүхий Монгол Улсад бүртгэлтэй татвар төлөгч аж ахуйн нэгжид давуу эрх олгож худалдан авалт хийнэ.</p> <p>(b) Монгол Улс дотооддоо элементийн хүхэр үйлдвэрлэж боломжит үнээр борлуулсан тохиолдолд Төсөл хэрэгжүүлэгч компани нь тэргүүн ээлжид дотоодын зах зээлээс худалдан авна.</p>	<p>11.3 Supporting National Suppliers</p> <p>(a) The Project Company shall prioritize purchasing goods, works, and services from, or selecting as subcontractors, registered taxpayer entities in Mongolia that meet the required technical, quality, safety, environmental, human rights, compliance standards and offer competitive prices and delivery conditions in comparison with foreign competitors, and give them preference when procuring throughout all phases of the Project.</p> <p>(b) If elemental sulfur is produced domestically in Mongolia and sold at reasonable price, the Project Company shall in priority purchase it from the domestic market.</p>
---	---

<p>(c) Төсөл хэрэгжүүлэгч компани нь Уурхайн ашиглалтын үе шатанд дараах нөхцөлийг хангаж ажиллана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> (i) нийт туслан гүйцэтгэгчдийн 60% (жаран хувь) -аас доошгүй нь Монгол Улсад бүртгэлтэй, татвар төлөгч хуулийн этгээд байх; болон (ii) жилийн нийт худалдан авалтын үнийн дүнгийн 40% (дөчин хувь)-аас доошгүй нь Монгол Улсад бүртгэлтэй, татвар төлөгч хуулийн этгээдээс авсан үйлчилгээ, хийсэн худалдан авалт байх. <p>(d) Төсөл хэрэгжүүлэгч компани нь ханган нийлүүлэгчдийг өөрийн худалдан авах ажиллагааны бодлогын дагуу сонгон шалгаруулах бөгөөд худалдан авах ажиллагааны бодлого нь Төслийн зардлыг оновчтой болгох, Төслийн эдийн засгийн тогтвортой байдал болон олон улсын комплайнсын стандартыг хангах зарчимд нийцсэн байна.</p> <p>(e) Төсөл хэрэгжүүлэгч компани нь жилийн санхүүгийн тайландаа энэ Гэрээний 11.3(с)-д заасан шаардлагыг хэрхэн хангаж ажилласан талаар мэдээллийг тусгасан байна.</p> <p>(f) Аудитын тухай хуульд заасны дагуу жилийн санхүүгийн тайланд олон улсын аудитын стандартыг дагаж мөрддөг бүртгэлтэй хөндлөнгийн аудиторууд аудит хийлгэнэ.</p>	<p>(c) The Project Company shall ensure that the following conditions are met during the Mining Operation Phase:</p> <ul style="list-style-type: none"> (i) At least 60% (sixty percent) of the total subcontractors must be taxpayer entities registered in Mongolia; and (ii) At least 40% (forty percent) of the total annual procurement value must be purchased from taxpayer entities registered in Mongolia. <p>(d) The Project Company shall select suppliers in accordance with its procurement policy, which shall aim to optimize Project costs, ensure the economic sustainability of the Project, and meet the international compliance standards.</p> <p>(e) In its annual financial report, the Project Company shall include information on how it has complied with the requirements set forth in Clause 11.3(c) of this Agreement.</p> <p>(f) The annual financial statements shall be audited by registered external auditors who comply with international auditing standards, as required by the Audit Law.</p>
--	--

<p>12. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, СУРГАЛТ</p> <p>12.1 Хөдөлмөр эрхлэлт</p> <ul style="list-style-type: none"> (a) Төсөл хэрэгжүүлэгч компани нь ажлын байрны сүл орон тоо (удирдах албан тушаалыг оролцуулан)-д мэргэжлийн шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг тэргүүн эзлжид ажиллуулна. Ижил үнэлэмж бүхий хөдөлмөрт эдил цалин, хөлс, урамшуулалт олгоно. (b) Төсөл хэрэгжүүлэгч компани нь холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ, олон улсын болон үндэсний стандарт, нормд нийцсэн хөдөлмөрлөх нөхцөл, хангамжийг бүх ажилчдадаа олгох үүрэгтэй бөгөөд гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирсон цалин, хөлс, урамшууллыг үл ялгаварлах зарчмын дагуу олгоно. (c) Төсөл хэрэгжүүлэгч компани нь ажилчдыг эвлэлдэн нэгдэх, хөдөлмөрийн хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, дэмжих ажиллах бөгөөд аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхал, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт, хөдөлмөрийн мөлжлэг, албадан хөдөлмөр эрхлэлт, хүүхдийн хөдөлмөр эрхлэлтээс ангид байх зэрэг холбогдох хууль, журам, стандартад бүрэн нийцсэн хөдөлмөрийн нөхцөл, орчныг бий болгох үүрэгтэй. 	<p>12. EMPLOYMENT AND TRAINING</p> <p>12.1 Employment</p> <ul style="list-style-type: none"> (a) The Project Company shall prioritize employing citizens of Mongolia who meet the professional qualifications for vacant positions (including managerial positions). Equal pay, wages, and incentives shall be provided for work of equal value. (b) The Project Company shall provide all employees with working conditions and provisions that comply with relevant legislation, international agreements of Mongolia, and applicable international and national standards and norms, and to provide wages and incentives based on the principle of non-discrimination, adequate for the duties performed. (c) The Project Company shall create and support conditions for employees to exercise their rights to unionize, and to enter into labor agreements and negotiations, ensuring a work environment that is free from any form of discrimination, harassment, violence, sexual harassment, labor exploitation, forced labor, and child labor, and that is fully compliant with relevant laws, regulations, and standards.
---	--

(d)	Төсөл хэрэгжүүлэгч компани нь ажилтнуудын санал хүсэлт, гомдол, маргааныг шуурхай хүлээн авч шийдвэрлэх механизмтай байх бөгөөд хөдөлмөрийн бүхий л стандартыг мөрдөж ажиллана.	(d)	The Project Company shall have a mechanism for promptly receiving and addressing employees' suggestions, complaints, and disputes, and shall operate in accordance with all labor standards.
(e)	Уурхайн ашиглалтын үе шатанд Төсөл хэрэгжүүлэгч компанийн нийт ажилчдын 90 (ер) ба түүнээс дээш хувь нь Монгол Улсын иргэн байна. Төсөл хэрэгжүүлэгч компанийн авч ажиллуулах гадаад ажилтны тоо нийт ажилтны 10% (арван хувь)-аас хэтэрсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гадаад ажилтны ажлын байрны төлбөр төлнө. Бутээн байгуулалтын үе шатанд Төсөл хэрэгжүүлэгч компанийн нийт ажилчдын хамгийн багадаа 60% (жаран хувь) нь Монгол Улсын иргэн байна.	(e)	During the Mining Operation Phase, at least 90 (ninety) percent of the total employees of the Project Company shall be citizens of Mongolia. If the number of foreign employees exceeds 10 (ten) percent of the total staff, the Project Company shall pay the necessary fees for foreign workers' positions as stipulated in the relevant legislation. During the Construction Phase, at least 60% (sixty percent) of the total employees of the Project Company shall be citizens of Mongolia.
(f)	Төсөлд гадаад иргэдийг ажиллуулах, Монгол Улсын хилээр нэвтрэх, оршин суух, эсхүл гарах зэрэгт шаардлагдах зөвшөөрөл, визний асуудлыг Гэрээний 3.8-д заасны дагуу шийдвэрлэнэ.	(f)	Issues regarding hiring foreign nationals for the Project, as well as matters related to obtaining necessary permits, visas for entry, residence, or exit from Mongolia, shall be resolved in accordance with Clause 3.8 of this Agreement.
(g)	Уурхайн ашиглалтын үе шатанд Төсөл хэрэгжүүлэгч компани нь Төсөл дээр ажиллаж байгаа нийт Монгол ажилчдын (туслан гүйцэтгэгч компанийн ажилчдыг оруулан) тав (5) ба түүнээс дээш хувийг Дорноговь аймгийн, болон холбогдох сумын оршин сугуч байх шаардлагыг хангаж ажиллана. Төсөл хэрэгжүүлэгч компани нь энэхүү шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд ажлын байраар хангаагүй орон	(g)	During the Mining Operation Phase, the Project Company shall ensure that at least five percent (5%) of all Mongolian employees (including employees of subcontractor companies) working on the Project are residents of Dornogovi aimag and the relevant soums. If the Project Company fails to comply with this requirement, it shall pay a monthly fee to the relevant State Authority for each unfilled position in accordance with the terms and conditions specified in the relevant legislation.

	тоо тутамд ногдох төлбөрийг холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл, журмын дагуу сар бүр холбогдох Төрийн эрх бүхий байгууллагад төлнө.	
(h)	Төсөл хэрэгжүүлэгч компани нь хууль тогтоомжид заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настныг авч ажиллуулах эсхүл холбогдох журмын дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настныг ажиллуулаагүй орон тоо тутамд ногдох төлбөрийг эрх бүхий байгууллагад төлнө.	(h) The Project Company shall employ citizens with disabilities and the elderly in accordance with the law, or, if unable to fill positions with such individuals, shall pay the established fees to the relevant competent authorities for each unfilled position.
12.2	Үндэсний мэргэжилтэн бэлтгэх	12.2 Training of National Professionals
(a)	Төсөл хэрэгжүүлэгч нь Монгол Улсын уул уурхайн салбар, нэн ялангуяа Говийн бус нутаг болон Төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах ур чадвартай, өөрийн Монгол ажилтнуудыг бэлтгэх талаар хүний нөөц, сургалтын цогц төлөвлөгөө хэрэгжүүлж ажиллах бөгөөд энэ талаар Орд ашиглах гэрээнд нарийвчлан зохицуулна.	(a) The Project Company shall implement a comprehensive human resources and training plan aimed at equipping its Mongolian employees with the skills required for the mining sector in Mongolia, particularly in the Gobi region, and for the implementation of the Project, and this shall be detailed in the Deposit Development Agreement.

<p>(b) Төсөл хэрэгжүүлэгч компани нь өөрийн ажилтныг бэлтгэх хүрээнд дараах үүрэг хүлээнэ:</p> <p>(i) тээвэрлэлт, борлуулалт, хог хаягдын менежмент, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа, байгаль орчны хамгаалал, нехен сэргээлт, усны нөөц, хяналт, мониторинг зэрэг чиглэлээр монгол ажилчдын ур чадварыг дээшлүүлэх, мөн практик туршлага олгох сургалтыг ижил төстэй гадаадын төсөл болон Уурхайн талбай дээр зохион байгуулах; мөн</p>	<p>(b) The Project Company undertakes the following responsibilities regarding training its employees:</p> <p>(i) To enhance the skills of Mongolian employees in the areas such as development of radioactive mineral drilling sites, extraction, processing, transportation, sales, waste management, radiation protection, operational safety, environmental protection, rehabilitation, water resources, control and monitoring, and organize practical experience training on similar foreign projects and Mine Areas.</p>
<p>(c) Төсөл хэрэгжүүлэгч компани нь Монгол Улсын хөдөлмөрийн хууль тогтоомжид заасны дагуу тухайн жилд хийгдэх сургалтын иж бүрэн, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ (цаашид "Жилийн сургалтын төлөвлөгөө" гэх).</p> <p>(d) Төсөл хэрэгжүүлэгч компани нь Жилийн сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлыг бүрэн хариуцна.</p> <p>(e) Төсөл хэрэгжүүлэгч компани нь ажилчдаа Монгол Улсын хөдөлмөрийн хууль тогтоомжид заасны дагуу сургалтад хамрагдах боломжоор хангах үүрэгтэй.</p>	<p>(c) The Project Company shall develop and submit a comprehensive training program and plan for the current year to the relevant state administrative central authority (hereinafter referred to as the "Annual Training Plan") in accordance with Mongolia's labour legislation.</p> <p>(d) The Project Company shall be fully responsible for the costs incurred in implementing the Annual Training Plan.</p> <p>(e) The Project Company shall ensure that its employees have access to training opportunities in accordance with Mongolia's labor legislation.</p>

<p>12.3 Инновацын хөтөлбөр</p> <ul style="list-style-type: none"> (a) Төсөл хэрэгжүүлэгч компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд Төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор өөрийн зардааар цацраг идэвхт ашигт малтмал хайх, олборлох буюу ашиглах, боловсруулах чиглэлээр сургалт, судалгаа, хөгжил болон инновацын хөтөлбөрийг бий болгохыг дэмжих ажиллана (цаашид "Инновацын хөтөлбөр"). (b) Уурхайн ашиглалтын үе шат эхэлснээс хойш тав (5) жилийн дотор орон нутгийн боловсролын байгууллагуудтай хамтран Инновацын хөтөлбөрийг боловсруулна. 	<p>12.3 Innovation Program</p> <ul style="list-style-type: none"> (a) The Project Company shall foster the establishment of an innovation program which includes training, research, and development, and innovation center (hereinafter referred to as the "Innovation Program") at its own expense, in the field of exploration, extraction, use, and processing of radioactive minerals to support the Project activities within the framework of social responsibility. (b) This Innovation Program shall be developed in collaboration with local academic institutions within five (5) years after the start of the Mining Operation Phase.
---	---

<p>12.4 Нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн нийтийн зориулалттай өмч ашиглах</p> <p>(a) Төсөл хэрэгжүүлэгч компани нь одоо байгаа болон ирээдүйд бий болох нийтийн зориулалттай дэд бүтэц (эрчим хүч, зам, ус, харилцаа холбоо болон аливаа бусад нийтийн аж ахуйн үйлчилгээ)-ийг Гэрээний 3.8-д заасныг баримтлан холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу үл ялгаварлах зарчимд нийцүүлэн ашиглах эрхтэй байна.</p> <p>(b) Төсөл хэрэгжүүлэгч компани нь Төслийн хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор нийтийн зориулалтаар ашиглах боломжтой аливаа дэд бүтцийн барилга байгууламж, авто зам зэргийг өөрийн хөрөнгөөр барьж байгуулсан бол Төслийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх нэхцэлд орон нутгийн иргэд, олон нийт болон Засгийн газарт ашиглуулна.</p> <p>(c) Засгийн газар нь Төслийг амжилттай хэрэгжүүлэх боломжийг Хөрөнгө оруулагчид олгох зорилгоор Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд хамаарах газрыг улсын тусгай хэрэгцээнд авах эрхээ хэрэгжүүлэхгүй байх үүргийг хүлээж байгаа болно. Засгийн газар нь Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай дээгүүр бус нутагт зайлшгүй хэрэгцээтэй нийтийн зориулалттай зам, дэд бүтцийн барилга байгууламжийг барьж байгуулах тохиолдолд Төсөл хэрэгжүүлэгч компанийтай зөвшилцөх бөгөөд Төсөл хэрэгжүүлэгч компани нь</p>	<p>12.4 Use of Public Infrastructure and State Public Property</p> <p>(a) The Project Company shall have the right to use existing and future public infrastructure (such as energy, roads, water, communications, and any other public utility services) in accordance with the provisions of Clause 3.8 (Permits) of the Agreement, based on the principles of non-discrimination as stipulated in the relevant legislation.</p> <p>(b) If the Project Company builds any infrastructure or roads that can be used for public purposes at its own expense to meet the Project's needs, it shall allow local residents, the public, and the Government to use them without interfering with the Project operations.</p> <p>(c) The Government shall refrain from exercising its right to take land for state special needs within the areas designated by Licenses to ensure the Investor's ability to successfully implement the Project. In the event that the Government constructs public roads and infrastructure facilities that are essential for the region over the area granted under the Licenses, the Government shall consult with the Project Company and the Project Company shall not unreasonably obstruct such constructions.</p>
---	---

үндэслэлгүйгээр саад учруулахгүй.		
12.5 Бүтээгдэхүүнийг экспортлох	Энэ Гэрээний 5.1-р зүйлийг хөндөхгүйгээр хувьцаа эзэмшигчид болон Төсөл хэрэгжүүлэгч компани нь Бүтээгдэхүүнийг Монгол Улсаас экспортлоходоо Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Олон улсын стандарт болон Үндэсний стандарт, дүрэм, журмыг мөрдөх үүрэгтэй.	12.6 Exporting Products Without prejudice to Clause 5.1 of this Agreement, the shareholders and the Project Company are obligated to comply with the Customs Law, Customs Tariffs Law, Customs Duties Law, the Nuclear Energy Law, as well as international agreements of Mongolia, and the International Standards, and the National Standards, Regulations, and Rules when exporting Products from Mongolia.
13. АВЛИГААС СЭРГИЙЛЭХ	УРЬДЧИЛАН	13. PREVENTION OF CORRUPTION
13.1 Төсөл хэрэгжүүлэгч компани болон Хөрөнгө оруулагчийн үүрэг		13.1 Obligations of the Project Company and Investor

	<p>Төсөл хэрэгжүүлэгч компани, Хөрөнгө оруулагч болон тэдний Хамаарал бүхий этгээдүүд, тэдгээрийн албан тушаалтан, захидал, ажилтнууд нь Авлыгын эсрэг Монгол Улсын хууль, түүнд нийцүүлж гаргасан дүрэм, журам болон үүгээр хязгаарлагдахгүйгээр өөрсдийн бүртгэлтэй, үйл ажиллагаагаа явуулж буй улс орнууд болох Бүгд Найрамдах Франц Улс, Европын Холбоо болон бусад холбогдох орны авлигын эсрэг хууль тогтоомж, Санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын зөвлөмжк, хориглолтуудыг (цаашид “Авлыгын эсрэг хууль тогтоомж” гэх) дагаж мөрдөх үүрэгтэй.</p>	<p>The Project Company, the Investor, their respective Affiliates and their officers, directors and employees shall be subject to the Anti-corruption laws of Mongolia and the regulations established in accordance with these laws, as well as those of France, the European Union, and other relevant countries where they operate, including recommendations and prohibitions of the Financial Action Task Force (FATF) (hereinafter referred to as "Anti-Corruption Laws and Regulations").</p>
13.2 Засгийн газрын үүрэг	<p>Төрийн бүх шатны байгууллага, албан хаагчид нь Авлыгын эсрэг хууль, тогтоомжийг үйл ажиллагаандaa чанд дагаж мөрдөх үүрэгтэй болохыг Засгийн газар нь хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд төрийн үйл ажиллагааг Авлыгын эсрэг хууль, тогтоомжийг дагаж мөрдөж ажиллана.</p>	<p>Obligations of the Government</p> <p>The Government acknowledges and agrees that all levels of State agencies and officials are subject to the Anti-corruption Laws and Regulations in their operations and to ensure that Government activities are conducted in accordance with the Anti-Corruption Laws and Regulations.</p>

<p>13.3 Авлигаас урьдчилан сэргийлэх амлалт</p> <p>(a) Төсөл хэрэгжүүлэгч компани, Хөрөнгө оруулагч болон Хамаарал бүхий этгээдүүдээс аливаа бүх шатны төрийн байгууллага, албан тушаалтанд төлсөн бүхий л төлбөр (татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хэлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусlamж зэрэг), улсын болон орон нутгийн төсөвт төвлөрч байгаа орлогын мэдээлэл нь ОҮИТБС-ын дагуу олон нийтэд нээлттэй байх бөгөөд олон нийтэд нээлттэй тавихыг Талууд бүрэн хүлээн зөвшөөрч байна.</p>	<p>13.3 Commitments on Prevention of Corruption</p> <p>(a) The Parties fully agree that all payments (such as taxes, fees, charges, service fees, dividends, penalties, contributions, and donations) made by the Project Company, the Investor, and its Affiliates to any Government agency or official, at any level, including revenue information collected in the state and local budgets, shall be public information and made public in accordance with the EITI.</p>
---	---

<p>(b) Энэхүү Гэрээгээр зохицуулсан эрх, үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан Гэрээний аль нэг Тал нь нөгөө Талдаа дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:</p> <p>(i) албан үүргээ гүйцэтгэх эсхүл гүйцэтгэхгүй байхтай нь холбогдуулан аливаа шан харамж, бэлэг, урамшуулал өгөх, өгөхөөр амлах, зуучлах, эсхүл аливаа хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, аливаа хэлбэрээр хууль бусаар нөлөөлөх; болон</p> <p>(ii) Авлигын эсрэг хууль, тогтоомжоор хориглосон эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжид ял, шийтгэл оногдуулахаар заасан бусад үйлдэл, эс үйлдэхүйг үйлдэх, үйлдэхээр тохиролцох, өдөөн хатгах, зохион байгуулах.</p>	<p>(b) In relation to the fulfillment of rights and obligations governed by this Agreement, either Party shall not undertake the following actions with respect to the other Parties:</p> <p>(i) To offer, promise, or facilitate any bribes, gifts, rewards, or advantages in connection with the performance or non-performance of official duties, or to obtain any advantage for any person or legal entity, or to promise, or offer any illegal influence in any form; and</p> <p>(ii) To engage in committing, agreeing to commit, inciting, or organizing other acts or omissions that are prohibited by the Anti-corruption Laws and Regulations and are punishable by criminal or minor offences laws.</p>
<p>(c) Гэрээний аль нэг Тал энэхүү 13 дугаар зүйлд заасан үүргийг зөрчсөн бол энэхүү Гэрээг 14.1(c)-д заасан үндэслэлээр цуцлах эрхтэй.</p>	<p>(c) If either Party violates the obligations stated in Clause 13, the other Parties have the right to terminate this Agreement on the grounds specified in Clause 14.1(c).</p>

13.4 НУУЦЛАЛ	13.4 CONFIDENTIALITY
(a) Нууц мэдээллийг Засгийн газар, Хөрөнгө оруулагч болон Төсөл хэрэгжүүлэгч компани чандлан хадгалах бөгөөд энэхүү Нууц мэдээллийн эзэн эсхүл энэхүү Гэрээний хүрээнд тус мэдээллийг гарган өгсөн аль нэг Талын урьдчилан бичгээр өгсөн тусгайлсан зөвшөөрөлгүйгээр аливаа гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно. Ийм зөвшөөрлийг олгохоос үндэслэлгүйгээр татгалзах, олгохдоо нехцэл тавих, эсхүл удаахыг хориглоно. Хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор зайлшгүй ил болгох шаардлагатай онцгой нехцэл байдал үүссэн талаар Засгийн газар нь Төсөл хэрэгжүүлэгч компани болон Хөрөнгө оруулагч нарт бичгээр мэдэгдэл хүргүүлснээс хойш хорин дөрвөн (24) цагийн дотор Хөрөнгө оруулагч болон Төсөл хэрэгжүүлэгч компани нь татгалзсаная мэдэгдээгүй бол Хөрөнгө оруулагч болон Төсөл хэрэгжүүлэгч компанийг зөвшөөрөл өгсөнд тооцно.	(a) Confidential Information shall be retained by the Government and the Investor and the Project Company in strictest confidence and shall not be disclosed to any third party without the express prior written consent of the other Party to which the Confidential Information belongs or which has disclosed such Confidential Information within this Agreement, which consent shall not be unreasonably withheld, conditioned or delayed, provided that the Investor and the Project Company's consent shall be deemed given if not withheld in writing within 24 (twenty four) hours after the Government notifies the Investor and the Project Company in writing of an emergency situation where disclosure is required to protect the health, safety, and security of citizens.
(b) "Нууц мэдээлэл" гэдэгт дараах мэдээллийг ойлгоно:	(b) "Confidential Information" shall mean:
(i) Монгол Улсын хуулийн дагуу хуулиар нууцад хамаарах мэдээлэл;	(i) Confidential Information as defined in the Mongolian Laws;
(ii) Ажилтнуудын аливаа хувийн мэдээлэл, эрүүл мэндийн мэдээлэл болон хувийн нууцыг агуулсан, тийнхүү нууцад хамаарна гэж ажилтнууд болон бусад хүмүүсийн	(ii) Personnel matters, health records of individual employees, or other documents in which employees or others have a reasonable expectation of privacy and other matters that involve the privacy of individuals;
	(iii) Confidential technical or proprietary information regarding equipment, process innovations;
	(iv) Business secrets;

	үндэслэлтэйгээр үзэхүйц бусад баримт бичгүүд;	(v)	Confidential legal matters, including advice from attorneys; or
(iii)	Тоног төхөөрөмж, процессын шийдэл, шинэ санаа зэргийн талаарх техникийн эсхул нууцын зэрэглэлтэй мэдээлэл;	(vi)	The Investor and the Project Company's intellectual property related to the Project, including geological information and mineral reserves.
(iv)	Бизнесийн нууц;		
(v)	Хуулийн зөвлөхийн зөвлөгөө зэргийг оруулан нууцлал бүхий хууль зүйн асуудлууд; эсхул		
(vi)	геологийн мэдээлэл болон ашигт малтмалын нөөц зэргийг оруулан Төсөлтэй холбоотой Хөрөнгө оруулагч болон Төсөл хэрэгжүүлэгч компанийн оюуны өмч.		

<p>(c) "Нууц мэдээлэл" гэсэн нэр томьёонд дараах мэдээлэл хамаарахгүй:</p> <ul style="list-style-type: none"> (i) Хууль бусаар задруулахгүйгээр олон нийтэд нээлттэй болсон; (ii) Аль нэг Талын гуравдагч этгээдээс хүлээн авсан буюу хүлээн авагч Тал нь ийм мэдээллийн талаар ямар нэгэн нууцлалыг хамгаалах үүрэг хүлээсэн гэдгийг мэдэлгүйгээр хүлээн авсан; (iii) Хөрөнгө оруулагч, Төсөл хэрэгжүүлэгч компани болон тэдгээрийн Хамаарал бүхий этгээдийн дагаж мөрддөг аливаа хуулийн болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагаа эсхул арбитрын шийдвэр эсхул хөрөнгийн биржийн холбогдох дүрэм журмын дагуу задруулах шаардлагатай болсон; (iv) Хамаарал бүхий этгээд, мэргэжлийн зөвлөхүүд, боломжит санхүүгийн дэмжлэг үзүүлэгчид болон боломжит жинхэнэ худалдан авагчдад задруулсан; эсхул (v) Энэхүү Гэрээний зүйлүүд хамаарахгүй болсон Ордын аль нэг хэсэгтэй тусгайлсан 	<p>(c) The term "Confidential Information" does not mean or include information that:</p> <ul style="list-style-type: none"> (i) becomes publicly available without wrongful disclosure; (ii) was obtained by a Party from a third party who is not known by the receiving Party to be under any obligation of confidentiality with respect to such information; (iii) is required to be disclosed by any law to which the Investor or Project Company or their Affiliates is subject, by any court proceeding or arbitral award, or by any applicable rule of a stock exchange; (iv) is disclosed to Affiliates, professional advisers, potential providers of finance, bona fide potential purchasers; or (v) Confidential Information specifically related to any part of the Deposit that is relinquished from the application of provisions of this Agreement.
---	--

холбоотой мэдээлэл.	Нууц	
14. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ ЦУЦЛАХ	14. TERMINATION OF THE AGREEMENT	
14.1 Гэрээ дуусгавар болох Энэхүү Гэрээ нь дараах тохиолдолд дуусгавар болж болно: (a) Талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгэсэн; (b) Гэрээний хугацаа дуусгавар болсон бөгөөд цаашид сунгагдаагүй; (c) 14.4, 14.5-р зүйлүүдэд заасан журмын дагуу 14.2, 14.3-р зүйлүүдэд заасан үндэслэлээр Талуудын аль нэг нь Гэрээг цуцлах эрхээ хэрэгжүүлсэн; болон (d) Талууд нь Гэрээг харилцан дуусгавар болгохоор бичгээр тохиролцсон.	14.1 Termination of the Agreement This Agreement may be terminated in the following cases: (a) The Parties have duly fulfilled their obligations under the Agreement; (b) The Term of the Agreement has expired and has not been extended; (c) One of the Parties has exercised its right to terminate the Agreement in accordance with Clause 14.2 or 14.3 and following the procedures specified in Clauses 14.4 and 14.5; and (d) The Parties have mutually agreed in writing to terminate the Agreement.	
14.2 Засгийн газар Гэрээг цуцлах эрх Засгийн газар нь дараах тохиолдолд зэнэхүү Гэрээг цуцлах эрхтэй байна: (a) Хөрөнгө оруулагч болон Төсөл хэрэгжүүлэгч компани нь энэхүү Гэрээгээр хүлээсэн үндсэн (материал) үүргээ зэрчсэн, үүнд дараахыг оруулах боловч үүгээр хязгаарлагдахгүй: (i) Энэхүү Гэрээний 3.1(d)-д заасны дагуу Төслийг хэрэгжүүлээгүй;	14.2 Termination rights of the Government The Government shall have the right to terminate this Agreement in the following circumstances: (a) The Investor and the Project Company have violated material obligations under this Agreement, including, but not limited to: (i) Failure to develop the Project in accordance with Clause 3.1(d) of this Agreement;	

	<p>(ii) 13-р зүйл (Авлигас сурьдчилан сэргийлэх);</p> <p>(iii) 16.1-р зүйл (Баталгаа, Мэдэгдэл);</p> <p>(iv) 17-р зүйл (Эрх шилжүүлэх); болон</p> <p>(v) Хөрөнгө оруулагч эсхүл Төсөл хэрэгжүүлэгч компани нь өөрчлөн байгуулагдах зорилгоос бусдаар төлбөрийн чадваргүй болсон, дамжуурсан, эсхүл татаан буугдсан тохиолдолд; эсхүл</p> <p>(vi) Төсөл хэрэгжүүлэгч компани буюу Хөрөнгө оруулагч нь 12 (арван хоёр) сар ба түүнээс дээш хугацаагаар Төслийг хэрэгжүүлэхгүй орхисон.</p> <p>(b) Гэрээний 15.3(е)-д заасан нөхцөл байдал үүссэн.</p>	<p>(ii) Clause 13 (Prevention of Corruption);</p> <p>(iii) Clause 16.1 (Representations and Warranties);</p> <p>(iv) Clause 17 (Transfer of rights); and</p> <p>(v) If the Investor or the Project Company becomes insolvent or bankrupt or is otherwise liquidated, other than for the purposes of corporate reorganization; or</p> <p>(vi) if the Project Company or the Investor abandons the Project for a continuous period of 12 (twelve months) or more.</p> <p>(b) A condition as specified in Clause 15.3(e) has arisen.</p>
14.3	<p>Хөрөнгө оруулагч Гэрээг цуцлах</p> <p>Хөрөнгө оруулагч нь Гэрээг дараах тохиолдолд цуцлах эрхтэй байна. Үүнд:</p> <p>(a) Засгийн газар нь энэ Гэрээгээр хүлээсэн дараах үндсэн (материал) үүргээ ноцтойгоор зөрчсөн:</p> <p>(i) Гэрээний 3.2-р зүйл (Хөрөнгө оруулалтыг хамгаалах баталгаа);</p>	<p>Investor's Right to Terminate the Agreement</p> <p>The Investor shall have the right to terminate the Agreement in the following cases:</p> <p>(a) The Government has materially violated the following material obligations under this Agreement:</p> <p>(i) Clause 3.2 (Guarantee to Protect Investment);</p>

	<p>(ii) Гэрээний 13-р зүйл (Авлигаас урьдчилан сэргийлэх); болон</p> <p>(iii) Гэрээний 16.2-р зүйл (Засгийн газрын мэдэгдэл, баталгаа),</p> <p>(b) Гэрээний 15.3(е)-д заасан нөхцөл байдал үүссэн.</p>	<p>(ii) Clause 13 (Prevention of Corruption); and</p> <p>(iii) Clause 16.2 (Representations and Warranties of the Government),</p> <p>(b) A condition as specified in Clause 15.3(e) has arisen.</p>
14.4 Гэрээ цуцлах мэдэгдэл	14.4 Termination Notice	<p>(a) Хэрэв холбогдох Тал нь энэ Гэрээний 14.2, 14.3-р зүйлд заасан үүргээ ноцтойгоор үл биелүүлсэн бөгөөд тухайн Тал нь үүргийн зөрчлийг арилгах ямар нэг арга хэмжээ аваагүй (цаашид "Үүргээ биелүүлээгүй тал" гэх) бол нөгөө Тал (цаашид "Гэрээг цуцлах эрх үүссэн" гэх) нь энэхүү Гэрээг цуцлах тухай мэдэгдэл ("Гэрээ цуцлах мэдэгдэл")-ийг Үүргээ биелүүлээгүй Тал руу хүргүүлж болно.</p>

<p>(b) Үүргээ биелүүлээгүй тал нь Гэрээ цуцлах мэдэгдлийг хүлээн авснаас хойш 180 (нэг зуун ная) хоногийн дотор үүргийн зөрчлийг арилгаагүй (цаашид "Үүргийн зөрчлийг арилгах хугацаа" гэх) бол Үүргийн зөрчлийг арилгах хугацаа дуусмагц энэ Гэрээг цуцлагдсанд тооцно.</p> <p>(c) Үүргээ биелүүлээгүй тал нь Үүргийн зөрчлийг арилгах хугацааны дотор үүргийн зөрчлийг арилгасан, үүргээ зохих ёсоор биелүүлсэн гэж Талууд хүлээн зөвшөөрсэн эсхүл бусад байдлаар тохиролцоонд хүрсэн бол Гэрээг цуцлах тухай мэдэгдэл нэн даруй хүчингүй болох бөгөөд Гэрээ хэвийн үргэлжилнэ.</p>	<p>(b) If the Defaulting Party fails to remedy the breach within 180 (one hundred and eighty) days upon receipt of the Termination Notice (hereinafter referred to as the "Remediation Period"), the Agreement shall be deemed terminated once the Remediation Period has expired.</p> <p>(c) If the Defaulting Party remedies the breach of obligation within the Remediation Period and the Parties agree that the obligation has been properly performed, or if other arrangements are made, then the Termination Notice shall immediately become void and the Agreement shall continue to be in effect.</p>
---	---

<p>14.5 Гэрээ дуусгавар болсны үр дагавар</p> <p>(a) Энэхүү Гэрээ нь 14.1(b), (c) эсхүл (d)-д заасан шалтгаанаар дуусгавар болсон тохиолдолд Хөрөнгө оруулагч болон Төсөл хэрэгжүүлэгч компани нь уурхайн хаалт, байгаль орчны нөхөн сэргээлт, уурхайн хаалтын дараах мониторинг, завсар арчилгаа, хяналт зэрэгт хамаарах Монгол Улсын хууль тогтоомж, Олон улсын стандартад заасны дагуу Уурхайн хаалтын төлөвлөгөөнд заасан үйл ажиллагааг зохих ёсоор хэрэгжүүлнэ.</p> <p>(b) Хөрөнгө оруулагч буюу Төсөл хэрэгжүүлэгч компани нь энэхүү Гэрээг 14.3-д заасан үндэслэлээр цуцалсан тохиолдолд энэхүү Гэрээнд заасан Хөрөнгө оруулагчийн эрхийг болон хуулиар шаардаж болох хохирол нөхөн төлөхийг шаардах эрхийг нь хөндөхгүйгээр энэхүү Гэрээ дуусгавар болно. Хөрөнгө оруулагчаас Гэрээг ийнхүү цуцалсан нь Тусгай зөвшөөрөл эсхүл Төсөл хэрэгжүүлэгч компанийн Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Ордыг үргэлжлүүлэн ашиглах эрхийг хөндөхгүй.</p> <p>(c) Засгийн газраас энэхүү Гэрээг 14.2(a)(i)-(ii) болон (b)-д заасан үндэслэлээр цуцалсан тохиолдолд энэхүү Гэрээнд заасан Засгийн газрын эрхийг болон хуулиар тогтоосон хохирлыг нөхөн төлөхийг шаардах эрхийг нь хөндөхгүйгээр энэхүү Гэрээ дуусгавар болно. Засгийн газар Гэрээг ийнхүү цуцалсан нь Тусгай зөвшөөрөл болон Төсөл</p>	<p>14.5 Consequences of Termination of the Agreement</p> <p>(a) If this Agreement is terminated for the reasons specified in Clauses 14.1(b), (c) or (d), the Investor and Project Company shall duly implement the activities specified in the Mine Closure Plan, in accordance with Mongolian laws and International Standards for mine closure, environmental rehabilitation, post-closure monitoring, maintenance, and oversight.</p> <p>(b) If this Agreement is terminated for cause by the Investor or the Project Company for the reasons specified in Clause 14.3, without prejudice to the Investor's rights under this Agreement or otherwise to claim damages by law, this Agreement shall cease to have effect. The termination by the Investor under such circumstances shall not affect the Licenses or the Project Company's right to continue to use the Deposits in accordance with Mongolian law.</p> <p>(c) If this Agreement is terminated for cause by the Government for the reasons specified in Clause 14.2 (a)(i)-(ii) or (b), without prejudice to the Government's rights under this Agreement or otherwise to claim damages by law, this Agreement shall cease to have effect. The termination by the Government under such circumstances shall not affect the Licenses or the Project Company's right to continue to use the Deposits in accordance with Mongolian law.</p> <p>(d) If this Agreement is terminated for cause by the Government for the reasons specified in Clause</p>
--	---

<p>хэрэгжүүлэгч компанийн Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Ордыг үргэлжлүүлэн ашиглах эрхийг хөндөхгүй.</p> <p>(d) Засгийн газар энэхүү Гэрээг 14.2(a)(iv), (v) буюу (vi)-д заасан үндэслэлээр цуцалсан тохиолдолд Засгийн газар Төслийг хяналтдаа авах эрхээ хэрэгжүүлэх бөгөөд Төсөл хэрэгжүүлэгч компани нь Орд болон холбогдох уул уурхайн барилаа байгууламжид хамаарах бүх эрх, өмчлөх эрх, ашиг сонирхлоо Засгийн газар эсхүл Засгийн газраас тогтоосон этгээдэд үнэ төлбөргүй шилжүүлнэ.</p>	<p>14.2(a)(iv), (v) or (vi), the Government shall have the right to exercise step-in rights in relation to the Project, and the Project Company shall transfer all right, title and interest in the Deposits and any associated mining facilities to the Government or its nominee for nil consideration.</p>
<p>14.6 Төслийн баримт бичиг, тайлан, бүртгэл</p> <p>Төсөл хэрэгжүүлэгч компани нь Компанийн тухай хуульд заасныг баримтлан компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, тооцоо, Төсөл болон Ордуудтай холбоотой бүх баримт бичиг судалгааг Монгол Улсын нутаг дэвсгэрт хадгална.</p>	<p>14.6 Project Documents, Reports, and Records</p> <p>The Project Company shall retain financial and operational reports and accounts of the company, along with all documents related to the Project and Deposits, on the territory of Mongolia, in compliance with the Company Law.</p>

<p>15. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС</p> <p>15.1 Давагдашгүй хүчин зүйлс</p> <p>(a) "Давагдашгүй хүчин зүйл" гэдэгт аль нэг Талын хяналтаас гадуур болсон, ямар нэг байдлаар урьдчилан таамаглах эсхүл урьдчилан сэргийлэх боломжгүй дараах үйл явдлын улмаас Гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор, заасан цаг хугацаанд биелүүлж чадахгүй болсныг буюу биелүүлэх хугацаагаа хэтрүүлснийг ойлгох боловч зөвхөн доорх тохиолдуудаар хязгаарлагдахгүй:</p> <p>(i) газар хедлэлт, үер, хүчтэй салхи шуурга, аянга цахилгаан, гол түймэр, цас, зуд, хэмжээний бороо гэх мэт байгалийн бүх төрлийн гамшиг;</p> <p>(ii) Монгол Улсын нутаг дэвсгэрт бий болсон дайн, зэвсэгт мөргөлдөөн, цэргийн ажиллагаа, бослого, хорлон сүйтгэх ажиллагаа;</p> <p>(iii) Засгийн газраас тогтоосон бүх төрлийн нийтийг хамарсан хязгаарлалт, хорио, цээр, өвчин тахал;</p> <p>(iv) нийт ажилчдыг хамарсан ажил хаялт, бүслэлт, суулт; болон</p> <p>(v) Монгол Улсын хилийн боомтуудыг хаах, худалдааны хориг тавигдах,</p>	<p>15. FORCE MAJEURE</p> <p>15.1 Force Majeure</p> <p>(a) "Force Majeure Events" shall mean an event beyond the control of a Party that could not have been anticipated or prevented in any way, resulting in the failure or delay to fulfill contractual obligations as stipulated in this Agreement. These events include but are not limited to:</p> <p>(i) Natural disasters of all kinds, including earthquakes, floods, strong winds, lightning, fires, snowfall, frost, heavy rain;</p> <p>(ii) Wars, armed conflicts, military operations, riots, and acts of sabotage occurring on the territory of Mongolia;</p> <p>(iii) Any Government-imposed restrictions, bans, quarantines, or epidemics affecting the public;</p> <p>(iv) Strikes, blockades, or sit-ins involving all employees; and</p> <p>(v) The closure of border checkpoints of Mongolia and imposition of trade embargo, transport restriction, ("Force Majeure Events").</p> <p>(b) A Party that is unable to fulfill its obligations under the Agreement due to Force Majeure Event shall be responsible for proving that such Force Majeure Event has occurred.</p> <p>(c) The occurrence of Force Majeure Event shall not exempt the Project Company or the Investor from the following obligations:</p>
---	--

	<p>тээвэрлэлтийн хязгаарлалт,</p> <p>(цаашид “Давагдашгүй хүчин зүйл” гэх).</p>	(i) Obligations related to scheduled monetary payments as stipulated in this Agreement; and
(b)	Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөлд өртсөний улмаас Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор, заасан цаг хугацаанд биелүүлж чадахгүй болсон Тал нь Давагдашгүй хүчин зүйл үүссэнийг нотлох үүрэг хүлээнэ.	(ii) Obligations related to environmental protection, occupational health and safety, nuclear safety, radiation protection, and mine closure and rehabilitation as required by this Agreement, Mongolian laws and regulations, and International Standards.
(c)	Давагдашгүй хүчин зүйл бий болсон нь Төсөл хэрэгжүүлэгч компани болон Хөрөнгө оруулагч нарыг дараах үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй. Үүнд:	
	<p>(i) энэхүү Гэрээнд заасны дагуу төлөгдөх хуваарьт мөнгөн төлбөрийн үүрэг; болон</p> <p>(ii) энэхүү Гэрээ, Монгол Улсын хууль тогтоомж болон Олон улсын стандартын дагуу хүлээсэн байгаль орчныг хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, цөмийн аюулгүй байдал, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа болон уурхайн хаалт, нөхөн сэргээлттэй холбоотой хүлээсэн үүрэг.</p>	

<p>15.2 Мэдэгдэл</p> <p>(а) Давагдашгүй хүчин зүйлийн улмаас энэхүү Гэрээгээр хүлээсэн үргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон Тал нь Давагдашгүй хүчин зүйл бий болсон эсхүл мэдсэнээс хойш 14 (арван дөрөв) хоногийн дотор негеэ Талд Давагдашгүй хүчин зүйл үссэн талаар, болон түүний нөхцөл байдал, үр дагавар болон Гэрээгээр хүлээсэн үргийн гүйцэтгэлд хэрхэн нөлөөлж буй талаар, холбогдох баримтын хамт бичгээр мэдэгдэнэ.</p>	<p>15.2 Notices</p> <p>(a) The Party that is unable to fulfill its obligations under this Agreement due to Force Majeure Event shall notify the other Party, within 14 (fourteen) days from the occurrence or knowledge of the Force Majeure Event, indicating that Force Majeure Event has occurred, along with its circumstances, nature and possible consequences, and how it will affect the performance of obligations under the Agreement.</p>
--	---

<p>15.3 Давагдашгүй хүчин зүйлийн үр дагавар</p> <p>(a) Давагдашгүй хүчин зүйлийн улмаас аль нэг Тал нь энэхүү Гэрээгээр хүлээсэн аль нэг үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон бөгөөд энэ талаар Гэрээний 15.2-д заасны дагуу цаг тухайд нь мэдэгдсэн бол үүргээ зерчsen гэж үзэхгүй бөгөөд энэхүү Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй болон үүргээ биелүүлэх хугацааг хэтрүүлсэнд буруутай гэж үзэхгүй.</p> <p>(b) Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөлд өртсөн Тал нь дараах арга хэмжээг авахаар боломжит хүчин чармайлт гаргана:</p> <ul style="list-style-type: none"> (i) Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс үүдсэн нөхцөл байдлыг хэвэнд нь оруулах; (ii) Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөлд өртөөгүй, биелүүлэх боломжтой үүргүүдийг зохих ёсоор үргэлжлүүлэн биелүүлэх; болон (iii) Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллийг багасгах, үр дагаврыг бүрэн арилгахын тулд боломжит бүх арга хэмжээг авах. 	<p>15.3 Consequences of Force Majeure</p> <p>(a) If a Party is unable to fulfill its obligations under this Agreement due to Force Majeure Event and has provided timely notification according to Clause 15.2, it shall not be considered in breach of obligation or responsible for failure to perform any obligation whatsoever or for any delay in performance of its obligations hereunder.</p> <p>(b) The Party affected by Force Majeure Event shall make all reasonable efforts:</p> <ul style="list-style-type: none"> (i) to cure the situation caused by the Force Majeure Event; (ii) to continue to the performance of the obligations that are possible and not affected by Force Majeure Event; and (iii) to take all possible measures to mitigate the effects of Force Majeure Event and eliminate consequences.
---	---

(c)	Энэ Гэрээний 15.2-р зүйлийн дагуу Давагдашгүй хүчин зүйлийн нэлэөллийн мэдэгдлийг хүргүүлснээс хойш Давагдашгүй хүчин зүйлийн нэлэөлөл 60 (жар) хоногоос дээш хугацаагаар үргэлжилсэн тохиолдолд Талууд аль болох шуурхай уулзалт зохион байгуулж, Давагдашгүй хүчин зүйл дуусгавар болох хүртэл авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар шийдвэр гаргах бөгөөд шаардлагатай бол тус уулзалтыг сард нэг удаа зохион байгуулна.	(c)	If the effects of Force Majeure Event persist for more than 60 (sixty) days, from Force Majeure notice as per Clause 15.2 of this Agreement, the Parties shall organize a meeting as soon as possible to decide on measures to be taken until the termination of the Force Majeure Event, and if necessary, hold such meetings once a month.
(d)	Давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Давагдашгүй хүчин зүйлийн нэлэөлөл нь зургаан (6) сараас дээш хугацаагаар үргэлжилсэн тохиолдолд Талууд өөрчлөгдсөн нөхцөл байдалд нийцүүлэн энэхүү Гэрээний нөхцөлийг шинэчлэх, өөрчлөх хэлэлцээ хийх бөгөөд тус хэлэлцээрийн хугацаанд Гэрээний нөхцөл хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.	(d)	If the effects of Force Majeure Event persist for more than six (6) months due to Force Majeure Event, the Parties shall negotiate in good faith to amend and revise the conditions of this Agreement according to the changed circumstances, during which the terms of the Agreement shall remain effective.
(e)	Давагдашгүй хүчин зүйлийн улмаас Төсөл хэрэгжүүлэгч компани нь үйл ажиллагаагаа хуанлийн нэг (1) жилээс дээш хугацаагаар зогсоох тохиолдолд Талууд нь энэхүү Гэрээг цуцлах эрхтэй байна.	(e)	The Parties shall have the right to terminate this Agreement if the Project Company suspends its operations for more than one (1) calendar year due to Force Majeure.

<p>15.4 Давагдашгүй хүчин зүйл дуусгавар болох</p> <p>(а) Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөлд өртсөн Талд Давагдашгүй хүчин зүйл нөлөөлөл үзүүлэхээ больсон бөгөөд энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад учруулах шалтгаан байхаа больсон даруйд тухайн Тал нь нөгөө Талдаа энэ талаар нэн даруй мэдэгдэж, энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ үргэлжлүүлэн биелүүлнэ.</p> <p>(б) Энэхүү Гэрээ болон Тусгай зөвшөөрлүүдийн хугацаа нь Давагдашгүй хүчин зүйл үргэлжлэх хугацаатай ижил хугацаагаар автоматаар сунгагдана.</p>	<p>15.4 Termination of Force Majeure</p> <p>a) As soon as the Force Majeure Event ceases to affect the Party affected by the Force Majeure Event and the Force Majeure Event is no longer a reason to prevent or delay it from fulfilling its obligations under this Agreement, the Party affected shall immediately notify the other Party and resume the performance of its obligations under this Agreement.</p> <p>b) The term of this Agreement and Licenses shall be automatically extended for the same period as the duration of the Force Majeure Event.</p>
---	--

<p>16. МЭДЭГДЭЛ БА БАТАЛГАА</p> <p>16.1 Хөрөнгө оруулагч болон Төсөл хэрэгжүүлэгч компанийн мэдэгдэл, баталгаа</p> <p>Хөрөнгө оруулагч болон Төсөл хэрэгжүүлэгч компани нь энэхүү Гэрээг байгуулсан өдөр болон Гэрээний хугацааны туршид Засгийн газарт дараах зүйлсийг мэдэгдэж, баталгаа гаргаж байна:</p> <ul style="list-style-type: none"> (a) (Хуулийн этгээдийн эрх зүйн чадвар) Хөрөнгө оруулагч нь Бүгд Найрамдах Франц Улсад улсад хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, тус улсын хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд мөн болно; (b) (Бүрэн эрх ба эрх мэдэл) энэхүү Гэрээг байгуулах, Гэрээгээр хулээсэн эрх, үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэх бүрэн эрх, эрх зүйн чадвартай болно; (c) (Бусад үүрэг хариуцлагатай зөрчилдөхгүй байх) энэхүү Гэрээг байгуулах болон Гэрээний дагуу хулээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэх нь Хөрөнгө оруулагч, болон Төсөл хэрэгжүүлэгч компанийн бусад этгээдтэй байгуулсан аливаа гэрээ, хэлцэл болон харьялагдах улсын хууль, тогтоомжтой зөрчилдөхгүй болно; (d) (Гураацагч этгээдийн зөвшөөрөл үл шаардах) энэхүү Гэрээг байгуулах, Гэрээгээр хулээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдээс зөвшөөрөл авах шаардлагагүй, хэрэв 	<p>16. REPRESENTATIONS AND WARRANTIES</p> <p>16.1 Representations and Warranties of the Investor and Project Company</p> <p>The Investor and the Project Company declare and warrant to the Government as of the date of this Agreement and throughout its duration the following:</p> <ul style="list-style-type: none"> (a) (<i>Legal Capacity of the Legal Entity</i>) The Investor is a legal entity established under the laws of the French Republic and operates in accordance with the laws of that country; (b) (<i>Authority and Power</i>) The Investor and the Project Company have the full authority and legal capacity to enter into this Agreement and duly perform the rights and obligations outlined herein; (c) (<i>No Conflicts with Other Obligations</i>) The conclusion of this Agreement and the exercise of the rights and obligations assumed under the Agreement shall not conflict with any agreements or transactions concluded by the Investor and the Project Company with other parties, or with the laws and regulations of the country of jurisdiction; (d) (<i>No Requirement for Third-Party Authorizations</i>) The conclusion of this Agreement and the performance of obligations under it require no approval from any third party, or if necessary, such approval has been duly obtained; (e) (<i>Creation of Binding Obligations</i>) This Agreement and the conditions stipulated therein shall create binding obligations;
--	--

	шаардлагатай бол түүнийг зохих ёсоор авсан болно;	(f) <i>(Use for Peaceful Purposes)</i> The Product shall be sold solely for peaceful purposes;
(e)	(Заавал биелэгдэх шинжтэй үүрэг үүсгэх) энэхүү Гэрээ болон Гэрээгээр тохиролцсон нэхцэлүүд нь заавал биелэгдэх шинжтэй үүрэг үүсгэж байгаа болно;	(g) <i>(Financial Capacity)</i> The Investor and the Project Company has the financial and economic capacity to fulfill its obligations under this Agreement, to make necessary investments, to mitigate potential losses from accidents, to provide compensation, and to conduct environmental and biological rehabilitation according to International Standards;
(f)	(Энхийн зорилгоор ашиглах) Бүтээгдэхүүнийг зөвхөн энхийн зорилгоор борлуулах болно;	(h) <i>(Legitimate Sources of Funds)</i> The funds for the Investment and other payments to be made under the Agreement must be from legal sources;
(g)	(Санхүүгийн чадавхтай) энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, шаардагдах хөрөнгө оруулалтыг хийх, болзошгүй ослын хохирлыг арилгах, нэхэн төлөх, байгаль орчны болон биологийн нэхэн сэргээлтийг зохих ёсоор Олон улсын стандартыг ханган хийх санхүү, эдийн засгийн чадавхтай болно;	(i) <i>(Compliance with Anti-Corruption Laws)</i> The Investor and the Project Company have not participated in any activities prohibited by Anti-Corruption Laws in relation to obtaining Permits, entering into this Agreement, or implementing it;
(h)	(Мөнгөн хөрөнгийн эх үүсвэр хууль ёсны байх) хөрөнгө оруулалт болон Гэрээний дагуу төлөгдөх бусад төлбөрүүдийн мөнгөн хөрөнгө нь хууль ёсны эх үүсвэрээс бүрдсэн болно;	(j) <i>(Transparency of Information)</i> All information provided to the Government in connection with the conclusion and implementation of this Agreement is factual and accurate, and there is no concealment or misrepresentation of any information or fact that is material to the conclusion and implementation of this Agreement.
(i)	(Авлигын эсрэг хууль үл зөрчих) Тусгай зөвшөөрлүүдийг олж авах, энэ Гэрээг байгуулах болон хэрэгжүүлэхтэй холбогдуулан Авлигын эсрэг хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцоогүй болно;	
(j)	(Мэдээллийн ил тод байдал) энэхүү Гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газарт гаргаж өгсөн бүх мэдээлэл нь бодит байдалд нийцэх, үнэн зөв мэдээлэл бөгөөд энэ Гэрээг байгуулах,	

	<p>хэрэгжүүлэхэд нөлөөлөх, ач холбогдол бүхий аливаа мэдээлэл, баримтыг нуун дарагдуулсан, худал мэдээлсэн зүйл байхгүй болно.</p>	
16.2 Засгийн газрын мэдэгдэл, баталгаа	<p>Засгийн газар нь энэхүү Гэрээг байгуулсан ёдрийн байдлаар болон Гэрээний хугацааны туршид Хөрөнгө оруулагчид дараах зүйлсийг мэдэгдэж, баталгаа гаргаж байна:</p> <ul style="list-style-type: none"> (a) (Заавал биелэгдэх шинжтэй үүрэг) Засгийн газар нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу энэхүү Гэрээг байгуулах, хэрэгжүүлэх бүрэн эрхтэй бөгөөд энэхүү Гэрээ нь заавал биелэгдэх шинжтэй үүрэг үүсгэж байгаа болно; (b) (Тусгай зөвшөөрлүүдийн хүчин төгөлдөр байдал) Гэрээний 16.1(i)-д заасан баталгаанд үндэслэн, Ордууд болон Тусгай Зөвшөөрлүүд нь Төсөл хэрэгжүүлэгч компанид хууль тогтоомжийн дагуу олгогдсон бөгөөд Төсөл хэрэгжүүлэгч компани нь Тусгай зөвшөөрлүүдийн үндсэн дээр холбогдох хууль тогтоомжид заасан эрхийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй болно; болон (c) (Хууль тогтоомжийг ул зөрчих) Засгийн газраас энэхүү Гэрээг байгуулах, Гэрээгээр хулээсэн үүргээ хэрэгжүүлэх нь Засгийн газраас гуравдагч этгээдийн өмнө хулээсэн аливаа үүрэг, Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжтой зөрчилдөөгүй болно. 	<p>16.2 Representations and Warranties of the Government</p> <p>The Government, as of the date of this Agreement and throughout its duration, declares and warrants to the Investor the following:</p> <ul style="list-style-type: none"> (a) (<i>Creation of Binding Obligations</i>) The Government has the authority to establish and implement this Agreement in accordance with applicable legislation, and this Agreement shall create binding obligations; (b) (<i>Validity of Permits</i>) The Deposits and Licenses have been granted to the Project Company in accordance with the law, based on the Representations and Warranties stipulated in clause 16.1(i) of this Agreement and the Project Company has full authority to exercise the rights specified in the relevant law on the basis of the Licenses and Permits; and (c) (<i>No Conflict with Laws</i>) The Government's conclusion of this Agreement and the implementation of its obligations under the Agreement shall not conflict with any obligations assumed by the Government to third parties, international treaties, or laws of Mongolia.

<p>16.3 Талуудын хариуцлага</p> <p>Хөрөнгө оруулагч, Төсөл хэрэгжүүлэгч компани болон Засгийн газар нь тус тусын мэдэгдэл болон баталгаануудын үнэн зөв, хүчин төгөлдөр байдалд бүрэн хариуцлага хүлээнэ. Хэрэв аль нэг Талын гаргасан мэдэгдэл болон баталгаа зөрчигдсөн нь тогтоогдвол, нөгөө Тал нь энэхүү Гэрээний 14-р зүйлийн дагуу энэхүү Гэрээг цуцлах эрхтэй байна.</p>	<p>16.3 Liabilities of the Parties</p> <p>The Investor, the Project Company, and the Government shall be fully liable for the accuracy and validity of their respective representations and warranties. If any declaration or warranty made by either Party is found to be breached, the other Party has the right to terminate this Agreement in accordance with Clause 14 of this Agreement.</p>
<p>17. Эрх шилжүүлэх</p> <p>17.1 Эрх шилжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> (a) Хөрөнгө оруулагч болон Төсөл хэрэгжүүлэгч компани нь Тусгай Зөвшөөрлүүд болон Уурхайн талбайг худалдах, бэлэглэх, барьцаалах болон өөр бусад хэлбэрээр бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлэхийг хориглоно. (b) Хөрөнгө оруулагч нь Гэрээний 17.1(а)-д зааснаас бусад энэхүү Гэрээгээр олж авсан эрхээ Засгийн газрын урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр шилжүүлж болно. (c) Энэ зүйлийг зөрчиж хийсэн аливаа эрх шилжүүлэх хэлцэл, гэрээ нь хууль зүйн хувьд хүчин төгөлдөр бус байна. 	<p>17. TRANSFER OF RIGHTS</p> <p>17.1 Transfer of rights</p> <ul style="list-style-type: none"> (a) The Investor and the Project Company are prohibited from selling, gifting, pledging, or otherwise transferring the Licenses and the Mine Area to the ownership, possession, or use of others. (b) The Investor may transfer rights obtained under this Agreement, except as provided in Clause 17.1(a), based on prior written consent from the Government. (c) Any transfer of rights or agreements made in violation of this provision shall be legally invalid.

<p>17.2 Хяналт өөрчлөгдхөх</p> <p>(a) Хөрөнгө оруулагч болон Төсөл хэрэгжүүлэгч компанийн хувьд тэдгээрийг Хяналтдаа байлгадаг, Хяналтыг эзэмшидэг этгээд өөрчлөгдхөх тохиолдолд Засгийн газарт урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авна.</p> <p>(b) Хөрөнгө оруулагч болон Төсөл хэрэгжүүлэгч компани нь энэ 17-р зүйлд заасныг зөрчсөн тохиолдолд Засгийн газар нь энэхүү Гэрээний 14.2(a)(iv)-д заасны дагуу энэ Гэрээг цуцлах эрхтэй байна.</p>	<p>17.2 Change of Control</p> <p>(a) The Investor and the Project Company shall notify the Government in advance and obtain approval in the event of a change in the person who Controls or holds the Control over them.</p> <p>(b) If the Investor or the Project Company violates the provisions of this Clause 17, the Government has the right to terminate this Agreement pursuant to Clause 14.2(a)(iv).</p>
<p>17.3 Мэдэгдэл</p> <p>(a) Энэхүү Гэрээний дагуу хийх болон түүнтэй холбоотой аливаа харилцаа холбоог албан бичгээр үйлдэх бөгөөд өөрөөр заагаагүй бол захидал эсхүл цахим шуудангаар хүргэж болно. Энэхүү Гэрээний дагуу хүргүүлсэн бүх мэдэгдэл, мэдэгдлийн хариу болон энэхүү Гэрээтэй холбогдуулан Талуудын албан бичгээр илгээсэн буюу харилцан солилцсон бусад бүх харилцаа холбоо нь Монгол болон Англи хэлээр хоёулангаар нь байна. Энэхүү Гэрээний дагуу болон түүнтэй холбоотой бүх уулзалт, бусад арга хэмжээг Монгол болон Англи хэлээр давхар явуулна.</p>	<p>17.3 Notices</p> <p>(a) All communications made under this Agreement and related matters shall be made in writing, and unless otherwise specified, may be delivered by letter or email. All notices, responses, and any other communications sent or exchanged in writing between the Parties under this Agreement shall be both in Mongolian and English. All meetings and other activities related to this Agreement shall also be conducted both in Mongolian and English.</p>

<p>(b) Энэхүү Гэрээний дагуу болон түүнтэй холбогдуулан хийх эсхүл хүргүүлэх аливаа харилцаа холбоо эсхүл баримт бичгийн Тал тус бүрийн хаяг нь дор дурдсан эсхүл таван (5) Ажлын өдрөөс доoshgүй өдрийн өмнө негөө Талуудад мэдэгдсэн орлох хаяг, эсхүл холбогдох нэгж, албан тушаалтан байна.</p> <p>(c) Энэхүү зүйлийн (b) хэсэгт заасан хаягууд нь доорх хаяг байна:</p> <p style="margin-left: 2em;">Засгийн газар: [хаяг] Хэнд: Цахим шуудан:</p> <p style="margin-left: 2em;">Цөмийн Энергийн Комисс: [хаяг] Хэнд: Цахим шуудан:</p> <p style="margin-left: 2em;">Хөрөнгө оруулагч: [хаяг] Хэнд: Цахим шуудан:</p> <p style="margin-left: 2em;">Хөрөнгө оруулагч: [хаяг] Хэнд: Цахим шуудан:</p> <p>(d) Энэхүү Гэрээний дагуу эсхүл түүнтэй холбогдуулан нэг Талаас негөө Талд захидал хэлбэрээр илгээсэн буюу хүргүүлсэн аливаа харилцаа холбоо эсхүл баримт бичгийг энэхүү гэрээний 17.2(c)-д заасан хаягаар хүргүүлнэ. Энэ тохиолдолд (i) биечлэн хүргүүлсэн эсхүл (ii)</p>	<p>(b) Each Party's address and email for communications or documents to be made or delivered under or in connection with this Agreement must be communicated or notified to the other at least five (5) Business Days in advance or replaced with another address provided to the corresponding unit or official.</p> <p>(c) The addresses mentioned in this paragraph (b) are as follows:</p> <p>Government: [Address] To: Email:</p> <p>Nuclear Energy Commission: [Address] To: Email:</p> <p>Investor: [Address] To: Email:</p> <p>Project Company: [Address] To: Email:</p> <p>(d) Any communication or document made or delivered by letter from one Party to another Party under or in connection with this Agreement shall be delivered to the address specified in Clause 17.2(c) of this Agreement and shall be deemed duly given (i) when it has been delivered in person or (ii) five (5) Business Days after being deposited in the post with postage prepaid.</p>
---	--

	<p>шуудангийн төлбөрийг урьдчилан төлж шуудангаар явуулхаар хүргүүлснээс хойш таван (5) ажлын өдөрт зохих ёсоор хүргүүлсэн гэж үзнэ.</p> <p>(e) Энэхүү Гэрээний 17.2(с)-д заасан хаяг өөрчлөгдсөн тохиолдолд тухайн Тал шинэ хаягаа бусад Талуудад аль болох боломжит үедээ бичгээр мэдэгдэх ба энэхүү Гэрээнд заасны дагуу хүргүүлсэн мэдэгдлийг аль нэг Тал хүлээн авахаас татгалзсан эсхүл хүлээн авах боломжгүй байсан нь бусад Талуудын эрхийг ямар нэгэн байдлаар хязгаарлах, хохироох үндэслэл болохгүй.</p>	<p>(e) If the addresses specified in Clause 17.2(c) change, the Party shall notify the other Parties of its new address in writing as soon as practicable, and the refusal or inability of any Party to receive an attempted notice delivered in accordance with this Agreement shall not restrict or prejudice any rights of the other Parties in any way.</p>
18. ҮЙЛЧЛЭХ ХУУЛЬ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ	18. GOVERNING LAW AND DISPUTE RESOLUTION	
18.1 Үйлчлэх хууль Энэхүү Гэрээг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулж, тайлбарлана.	18.1 Governing Law This Agreement shall be governed and construed in accordance with the Mongolian Law.	

<p>18.2 Маргааныг эвийн журмаар шийдвэрлэх</p> <p>(a) Энэхүү Гэрээгээр зохицуулсан харилцаатай холбоотой Талуудын хооронд аливаа шаардлага, санал зэрөлдөөн, маргаан үүссэн, эсхүл Гэрээг зөрчсөн, цуцалсан болон хүчин төгөлдөр бус болсон (цаашид "Маргаан" гэх) тохиолдолд аль ч Тал тус Маргаан үүссэн талаар бусад Талуудад мэдэгдэж болно (цаашид "Маргааны талаарх мэдэгдэл" гэх). Маргааны Талууд нь өөрсдийн эрх бүхий этгээдүүдээр дамжуулан хоорондын хэлэлцээ хийх замаар үүссэн Маргааныг шударгаар, эвийн журмаар шийдвэрлэнэ. Маргааны Талуудын эрх бүхий этгээдүүд нь Маргааны Мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 (гуч) хоногийн дотор уулзах газар, цагийг харилцан тохиролцож уулзалт хийх бөгөөд цаашид үүссэн Маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай гэж үзсэн давтамжтайгаар уулзалтыг хийнэ. Маргааны талаарх мэдэгдлийг хүргүүлснээс хойш 180 (нэг зуун ная) хуанлийн хоногийн дотор Маргааныг шийдвэрлэж чадаагүй эсхүл уг мэдэгдлийг хүргүүлснээс хойш 30 (гуч) хоногийн дотор Маргааны Талууд уулзаагүй бол, Маргааны аль ч Тал энэхүү Гэрээний 18.3 дугаар зүйлд заасны дагуу олон улсын арбитрын ажиллагааг эхлүүлж болно.</p> <p>(b) Гэрээний 18.2(a)-р заалтын дагуу явагдсан бүхий л тохиролцоо нь бүхэлдээ энэхүү</p>	<p>18.2 Amicable Settlement of Disputes</p> <p>(a) In the event of any claims, disputes, disagreements, or breaches related to this Agreement between or among any of the Parties arising out of or in connection with this Agreement, including termination or invalidation (hereinafter referred to as "Dispute"), either Party may notify the other Party about the Dispute (hereinafter referred to as the "Notice of Dispute"). The Parties to the Dispute shall, in good faith, attempt to settle the Dispute amicably through negotiations between their authorized representatives. The authorized representatives of the Parties to the Dispute shall meet within 30 (thirty) calendar days of receiving the Notice of Dispute at a mutually acceptable time and place, and shall hold meetings as often as deemed necessary to try to resolve the Dispute. If the Dispute has not been resolved within 180 (one hundred eighty) calendar days from the delivery of the Notice of Dispute, or if the Parties have not met within 30 (thirty) days after the delivery of the Notice of Dispute, then any of the Parties to the Dispute may initiate international arbitration proceedings as specified in Clause 18.3 of this Agreement.</p> <p>(b) All agreements reached under Clause 18.2(a) shall be considered Confidential Information under this Agreement and shall be treated as negotiations conducted with the aim of resolving the Dispute amicably in all aspects.</p>
---	--

Гэрээний хүрээнд Нууц
мэдээлэлд тооцогдох бөгөөд
Маргааныг эвийн журмаар
шийдвэрлэх буюу
тохиролцоонд хүрэх зорилгоор
хийгдсэн хэлэлцээр гэж үзнэ.

18.3 Олон улсын арбитр	18.3 International Arbitration
(a) Энэхүү Гэрээнээс үүдэн гарсан болон холбогдон үссэн аливаа маргааныг Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төв (цаашид "Төв" гэх)-ийн арбитраар, Улс болон Гадаад Улсын Иргэний Хоорондын Хөрөнгө Оруулалтын Маргааныг Шийдвэрлэх Тухай Конвенцын (цаашид "Конвенц" гэх) дагуу шийдвэрлүүлэхийг Талууд үүгээр хүлээн зөвшөөрч байна.	a) The Parties hereby consent to submit to the International Centre for Settlement of Investment Disputes (hereinafter the "Centre") any dispute arising out of or relating to this Agreement for arbitration pursuant to the Convention on the Settlement of Investment Disputes between States and Nationals of Other States (hereinafter the "Convention")
(b) Энэхүү Гэрээнд хамаарах хэлцэл нь хөрөнгө оруулалт болохыг Талууд хүлээн зөвшөөрч байна.	b) It is hereby confirmed by the Parties that the transaction to which this Agreement relates is an investment.
(c) Хөрөнгө оруулагч нь Бугд Найрамдах Франц Улс (БНФУ)-д бүртгэлтэй компани болно.	c) The Investor is a company incorporated in France.
(d) Төсөл хэрэгжүүлэгч компани нь Монгол Улсад үүсгэн байгуулагдсан боловч Хөрөнгө оруулагчийн Хяналтад байдаг, мөн Конвенцын зорилгын Үүднээс БНФУ-ын иргэн харьят гэж үзэхийг үүгээр зөвшөөрч байна.	d) It is hereby agreed that, although the Project Company is incorporated in Mongolia, it is Controlled by the Investor and shall be treated as a national of France for the purposes of the Convention.
(e) Энэхүү Гэрээний дагуу явагдах аливаа арбитрын ажиллагаа нь уг ажиллагаа эхэлсэн өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Төвийн Арбитрын журмын дагуу явагдана.	e) Any arbitration proceeding pursuant to this Agreement shall be conducted in accordance with the Arbitration Rules of the Centre in effect on the date on which the proceeding is instituted.
(f) Конвенцын 62, 63 дугаар зүйлд заасны дагуу арбитрын ажиллагааг Төвийн арбитрын ажиллагаа явуулах газар (Вашингтон, ДС) явуулна.	f) Under Articles 62 and 63 of the Convention, arbitration proceedings shall be held at the seat of the Centre (in Washington, D.C.).
(g) Энэхүү Гэрээний дагуу байгуулагдах аливаа Арбитрын бүрэлдэхүүн нь гурван	g) Any Arbitral Tribunal constituted pursuant to this Agreement shall consist of three arbitrators, one appointed by each of the Investor and the Government, and an arbitrator, who shall be President of the Tribunal, appointed by agreement of the Investor and the Government. Article 37(2) of the Convention shall apply to the appointment of arbitrators by the Parties. If the Government and the Investor are unable to agree on the

	<p>арбитрчаас бүрдэх бөгөөд Хөрөнгө оруулагч болон Засгийн газраас тус бүр нэг арбитрч томилно, харин арбитрийн бүрэлдэхүүнийг даргалах арбитрчийг нь Хөрөнгө оруулагч болон Засгийн газар харилцан тохиролцож томилно. Талууд арбитрчдийг томилоход Конвенцын 37 дугаар зүйлийн 2 дахь заалтыг баримтална Хэрэв Хөрөнгө оруулагч болон Засгийн газар нь Конвенцын 38 дугаар зүйлд заасны дагуу 90 (ер) хоногийн дотор арбитрийн бүрэлдэхүүнийг Даргалагч арбитрчийг зөвшилцэн томилж чадаагүй бол Талуудын аль нь ч Төвийн Захиргааны зөвлөлийн даргаас Даргалагч арбитрчийг томилохыг хүсэж болно.</p>	<p>President of the Tribunal within the 90-day period provided in Article 38 of the Convention, either Party may request the Chairman of the Administrative Council of the Centre to appoint the President of the Tribunal.</p>
(h)	<p>Энэхүү Гэрээний дагуу байгуулагдсан аливаа Арбитрын бүрэлдэхүүн нь Монгол Улсын хууль, түүний дотор Монгол Улсын холбогдох олон улсын гэрээг хэрэглэж маргааныг шийдвэрлэнэ.</p>	<p>h) Any Arbitral Tribunal constituted pursuant to this Agreement shall apply Mongolian Law, including all relevant International Treaties of Mongolia.</p>
(i)	<p>Хөрөнгө оруулагч буюу Төсөл хэрэгжүүлэгч компани нь гагцхүү татвартай холбоотой Монгол Улсын Татварын алба болон Төсөл хэрэгжүүлэгч компанийн хооронд үүссэн маргааны хувьд Конвенцын дагуу арбитрын ажиллагаа эхлүүлэхээс өмнө, Засгийн газар энэхүү шаардлагаас бичгээр татгалзсанаас бусад тохиолдолд, Монгол Улсын хуульд заасан захиргааны болон шүүхийн маргаан шийдвэрлэх бүх шатны</p>	<p>i) Before the Investor or the Project Company institutes an arbitration proceeding under the Convention with respect to a dispute between the Project Company and the Mongolian Tax Authority relating solely to tax matters, the Investor or the Project Company must have taken all steps necessary to exhaust the administrative and judicial remedies available to it under Mongolian Law in respect of such matters, unless the Government waives that requirement in writing.</p> <p>j) The Government agrees not to exercise any influence (including, without limitation, seeking to undue delay or procure the undue delay of proceedings) in the due process of the Mongolian administrative or judicial procedures relating to any Tax dispute.</p> <p>k) Without prejudice to the power of the Arbitral Tribunal to recommend provisional measures, either Party hereto may request judicial or other authority in Mongolia to order any provisional or conservatory measure, including attachment, prior to the institution of the arbitration proceeding, or during the proceeding, for the preservation of its rights and interests.</p>

	<p>ажиллагааг дуусгасан байхыг шаардана.</p>
(j)	<p>Засгийн газар Татварын аливаа маргаантай холбоотой Монгол Улсын захиргааны болон шүүхийн зохих журмын дагуу ажиллагаанд ямар нэгэн нөлөөлөл үзүүлэхгүй (үүнд ямар нэгэн байдлаар, үндэслэлгүйгээр хойшлуулах, үндэслэлгүй хойшлуулахыг оролдох гэх мэт) зөвшөөрөхгүй байх үүрэгтэй.</p>
(k)	<p>Арбитрын бүрэлдэхүүнээс арбитрийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах түр арга хэмжээ санал болгох эрх мэдлийг хөндөхгүйгээр, аль нэг Тал нь өөрийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахын тулд арбитрын ажиллагаа эхлэхээс өмнө, эсхүл арбитрийн ажиллагааны явцад арбитрийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах түр болон хамгаалах арга хэмжээ, түүний дотор хөрөнгө битүүмжлэх шийдвэр гаргахыг Монгол Улсын шүүхийн болон бусад эрх бүхий байгууллагаас хүсэж болно.</p>

<p>18.4 Бүрэн эрхт халдашгүй дархан эрхээс татгалзах тухай</p> <p>Талууд тус бүр нь энэхүү Гэрээтэй холбоотой аливаа бүрэн эрхт халдашгүй дархан эрхээсээ болзолгүйгээр татгалзаж байгаагаа үүгээр баталгаажуулж, энэхүү Гэрээнээс үүдэн гарсан буюу түүнтэй холбоотой аливаа хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бүрэн эрхт халдашгүй дархан эрхээ дараахтай холбогдуулан хэрэгжүүлэхгүй, шаардахгүй байхаа хүлээн зөвшөөрч байна: Үүнд (i) энэхүү Гэрээний 18.3 дугаар зүйлд заасны дагуу хийгдэх аливаа арбитрын ажиллагаа эсхүл түүнээс гарах арбитрын шийдвэр, (ii) арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн буюу биелүүлэх тухай гарсан аливаа шүүхийн шийдвэр, (iii) арбитрын шийдвэрийг арилжааны зориулалтаар ашигладаг эд хөрөнгөтэй холбогдуулан хэрэгжүүлэх зэрэг хамаарна. Дээр дурдсан бүрэн эрхт халдашгүй дархан эрхийн татгалзал нь тухайн хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж болох аль ч улсад хүчинтэй байна.</p>	<p>18.4 Waiver of Sovereign Immunity.</p> <p>Each of the Parties hereby provides its unconditional waiver of any sovereign immunity as relates to this Agreement, and agrees not to assert or claim a sovereign immunity in or in respect of any proceedings arising out of or in connection with this Agreement, including in or in respect of (i) any arbitration proceedings or award pursuant to Clause 18.3 of this Agreement, (ii) any court judgment acknowledging or enforcing the award or (iii) any enforcement of such award in respect of the assets used for commercial purposes. The foregoing waiver of any sovereign immunity shall be valid in any jurisdiction in which such proceedings may occur.</p>
---	--

<p>19. БУСАД</p> <p>19.1 Холбогдох баримт бичиг болон үйл ажиллагаа</p> <p>(a) Хөрөнгө оруулагч, Тесөл хэрэгжүүлэгч компани болон холбогдох Төрийн байгууллага нь энэ Гэрээгээр тохиролцсон нехцелүүдэд нийцүүлэн дараах баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэгтэй:</p> <ul style="list-style-type: none"> (i) Хувьцаа эзэмшигчдийн гэрээ; (ii) Орд ашиглах гэрээ; болон (iii) Тесөл хэрэгжүүлэгч компанийн дүрэм <p>(b) Хөрөнгө оруулагч болон Тесөл хэрэгжүүлэгч компани нь дараах баримт бичгүүдийг эрх бүхий холбогдох Төрийн байгууллагуудад хүргүүлж, батлуулна:</p> <ul style="list-style-type: none"> (i) Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу боловсруулан бэлтгэсэн, эдийн засгийн үр өгөөжийг нь баталж Монгол Улсын Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлөөс хүлээн авсан Техник эдийн засгийн үндэслэлийн тодотгол; болон (ii) Байгаль орчны нэлэөллийн үнэлгээ. <p>(c) Эрх бүхий холбогдох Төрийн байгууллагууд дараахыг баталсан байна:</p>	<p>19. MISCELLANEOUS</p> <p>19.1 Related Documents and Actions</p> <p>a) The Investor, the Project Company and the relevant State Authorities shall amend the following documents to comply with the provisions of this Agreement:</p> <ul style="list-style-type: none"> (i) Shareholders' Agreement; (ii) Deposit Development Agreement; and (iii) The Charter of the Project Company. <p>b) The Investor and the Project Company shall further submit and have approved by the relevant State Authority, the following documents:</p> <ul style="list-style-type: none"> (i) The updated Feasibility Study prepared in accordance with Mongolian Laws and accepted by the Minerals Professional Council of Mongolia for confirmation of economic viability; and (ii) The Environmental Impact Assessments; <p>c) The relevant State Authorities shall have approved:</p> <ul style="list-style-type: none"> (i) the transfer of the Project Company's shares held by Areva Mongol to Orano Mining Expansion S.A.S. on a Tax-free basis as provided under Article 30.8 of the Corporate Income Tax Law; (ii) The conversion of 34% ordinary shares of MonAtom LLC in the Project Company to preferred shares in the Project Company
---	--

	(i) Арева Монголын эзэмшдэг Төсөл хэрэгжүүлэгч компанийн хувьцааг Орано Майнинг Экспанши С.А.С-д Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.8-д заасны дагуу татваргүй шилжүүлэх;	representing 10% of the total issued and outstanding shares of the Project Company on a Tax-free basis as provided under the Corporate Income Tax Law; and
	(ii) Мон-Атом ХХК-ийн эзэмшдэг Төсөл хэрэгжүүлэгч компанийн 34%-тай тэнцэх энгийн хувьцааг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу Төсөл хэрэгжүүлэгч компанийн нийт гаргасан хувьцааны 10%-тай тэнцэх давуу эрхийн хувьцаанд татваргүй хөрвүүлэх; болон	(iii) The determination by the Government of the amount to be deposited in accordance with Articles 28.9 and 28.10 of the Nuclear Energy Law.
	(iii) Цөмийн энергийн тухай хуулийн 28.9 болон 28.10-д заасны дагуу байршуулах мөнгөн хөрөнгийн хэмжээг Засгийн газраас тогтоосон байх.	d) Following the completion of each of the steps set out above, the Parties shall agree in writing that the Effective Date ("Effective Date") has occurred. Each Party shall take all efforts and necessary steps to implement the above actions within a maximum of twelve (12) months after the Date of Signature.
(d)	Дээр дурдсан алхмууд бүрэн хэрэгжиж дууссаны дараа Талууд Гэрээ хүчин төгөлдөр болох өдрийг бичгээр тохиролцож тогтооно ("Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр"). Тал тус бүр Гарын үсэг зурсан өдрөөс хойш хамгийн ихдээ авсан хоёр (12) сарын дотор дээр дурдсан зүйлсийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л алхмуудыг авч, зохих	

хүчин чармайлтыг гаргах үүрэгтэй.	
19.2 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах Зөвхөн Төсөл хэрэгжүүлэгч компани, Хөрөнгө оруулагч болон Засгийн газрын эрх олгогдсон төлөөлөгчдөөс зөвшөөрсөн тохиолдолд тэдгээрээс Гэрээнд бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.	19.2 Amendment to the Agreement This Agreement may be amended, modified or supplemented only in writing if agreed and executed by the authorised representatives of the Project Company, the Investor and the Government.
19.3 Тогтвортжуулалтад үл хамаарах Энэ Гэрээний зүйл, заалтуудад Монгол Улсын хууль, тогтоомжийг иш татсан нь тухайн хууль, тогтоомжийн үйлчлэлийг Гэрээ байгуулсан өдрөөр тогтвортжуулж буй утгаар тайлбарлагдахгүй бөгөөд эшилсэн хууль тогтоомжид цаашид хийгдэх нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулга эсхүл тухайн харилцааг зохицуулахаар шинээр батлагдан гарсан хууль тогтоомжийг хамруулан ойлгож, хэрэгжүүлнэ.	19.3 Exception for Stabilization References to the Mongolian laws in the clauses and provisions of this Agreement shall not be interpreted as stabilizing the validity of such laws as of the date of execution of this Agreement, and shall be understood and applied to include any future amendments, changes, revisions or newly enacted laws to regulate the relevant relationship.
19.4 Гэрээнд үйлчлэх хэл Энэхүү Гэрээг Монгол болон Англи хэл дээр үйлдсэн болно. Англи болон Монгол хэл дээрх бичвэрүүд нь хоорондоо утга болон агуулгын хувьд зөрүүтэй байвал Англи хэл дээрх хувийг баримтална.	19.4 Language This Agreement has been executed in the English and Mongolian languages. If there is any discrepancy or inconsistency between the English and Mongolian versions, the English version shall prevail.

19.5 Эрхээс үл татгалзах Энэхүү Гэрээний дагуу эдлэх эрхээ хэрэгжүүлэхээс татгалзсан талаар гэрээний Тал нь бичгээр мэдэгдсэнээс бусад тохиолдолд тухайн этгээдийг эрхээсээ татгалзсан гэж үзэхгүй. Аль нэг Тал нь энэхүү Гэрээний аль нэг заалтыг хэрэгжүүлээгүй нь тухайн заалт буюу түүний аль нэг хэсгээс татгалзсан эсхул нэгээ Талын ирээдүйд гаргах аливаа зөрчилтэй холбоотойгоор тухайн заалтыг эсхул тухайн заалтын аль нэг хэсгээс татгалзсандаа тооцогдохгүй. Аливаа эрхийг хэрэгжүүлэхээ хойшилуулах, эсхул хэрэгжүүлэхгүй байхыг уг эрхээсээ татгалзсан гэж үзэхгүй.	19.5 No Waiver A Party shall not be deemed to have waived its rights under this Agreement unless it has provided written notice of such waiver. The failure of any Party to enforce at any time any of the provisions of this Agreement shall in no way be construed to be a waiver of the provision or any part thereof or the right of any Party thereafter to enforce each and every part of the provision in respect of any subsequent default or breach. Delay in exercising or non-exercise of any such right is not a waiver of that right.
19.6 Гэрээний хувь Энэхүү Гэрээг хэд хэдэн хувь үйлдэж, хувь тус бүр дээр гарын үсэг зурсан бөгөөд хувь тус бүрийг эх хувь гэж үзэх бөгөөд бүгд хамтдаа нэг адил гэрээнд тооцогдоно	19.6 Counterparts This Agreement is executed in several copies, each signed, and each copy shall be deemed an original copy but all of which taken together shall constitute one and the same agreement.
(a) Энэхүү Гэрээ нь Талууд, тэдгээрийн эрх залгамжлагч болон зөвшөөрөгдсөн эрх хүлээн авагчдын хувьд заавал биелэгдэх шинжтэй байна. (b) Бусдад эрх шилжүүлэх нь энэхүү Гэрээний дагуу Талуудын хүлээсэн эрх, үүргийг өөрчлөх буюу нэмэгдүүлэх үндэслэл болохгүй.	19.7 Assignment of Rights (a) This Agreement shall be binding upon the Parties, their successors and authorised assignees. (b) An assignment of rights shall not expand or alter the rights of the Parties under this Agreement.

<p>19.8 Эрхээс үл татгалзах</p> <p>Энэхүү Гэрээний дагуу эдлэх эрхээ хэрэгжүүлэхээс татгалзсан талаар гэрээний Тал нь бичгээр мэдэгдсэнээс бусад тохиолдолд тухайн этгээдийг эрхээсээ татгалзсан гэж үзэхгүй. Аль нэг Тал нь энэхүү Гэрээний аль нэг заалтыг хэрэгжүүлээгүй нь тухайн заалт буюу түүний аль нэг хэсгээс татгалзсан эсхул негee Талын ирээдүйд гаргах аливаа зөрчилтэй холбоотойгоор тухайн заалтыг эсхул тухайн заалтын аль нэг хэсгээс татгалзсандаа тооцогдохгүй. Аливаа эрхийг хэрэгжүүлэхээ хойшилуулах, эсхул хэрэгжүүлэхгүй байхыг уг эрхээсээ татгалзсан гэж үзэхгүй.</p>	<p>19.8 Entire Agreement</p> <p>This Agreement supersedes any and all other prior understandings and agreements, either oral or in writing, between the Parties with respect to the subject matter hereof. Each Party to this Agreement acknowledges that no representation, inducement, promise, or agreement, orally or otherwise, have been made by any Party or by anyone acting on behalf of any Party, which are not embodied in this Agreement and that any agreement, statement or promise that is not contained in this Agreement shall not be valid or binding or of any force or effect.</p>
<p>19.9 Гэрээний хувь</p> <p>Энэхүү Гэрээг хэд хэдэн хувь үйлдэж, хувь тус бүр дээр гарын үсэг зурсан бөгөөд хувь тус бүрийг эх хувь гэж үзэх бөгөөд бүгд хамтдаа нэг адил гэрээнд тооцогдоно</p>	<p>19.9 Severability</p> <p>If any provision in this Agreement shall be invalid, illegal or held to be void, restricted, prohibited or unenforceable in any jurisdiction, the validity, legality and enforceability of the remaining provisions shall not in any way be affected or impaired thereby and such provision shall be ineffective only to the extent of such restriction, prohibition or unenforceability without invalidating the remaining provisions of this Agreement and without affecting the validity or enforceability of such provision in any other jurisdiction or without affecting its application to the other Party or circumstances.</p>

<p>19.10 Хүчин төгөлдөр хэвээр үйлчлэх.</p> <p>Энэхүү Гэрээг аль нэг Тал эсхүл ямар нэгэн шалтгаанаар цуцалсан, тухайлбал энэхүү Гэрээ эсхүл түүний зарим хэсгийг хүчингүй, хүчин төгөлдөр бус, хэрэгжих боломжгүй гэж үзсэний улмаас цуцалсан эсэхээс үл хамаарч энэхүү Гэрээний 14, 15, 16, 18, 19 дүгээр зүйлүүд нь тийнхүү цуцалсны дараа ч хүчин төгөлдөр хэвээр, энэхүү Гэрээгээр зохицуулах зүйл болон энэхүү Гэрээний дагуу болон түүнтэй холбоотой үүсэх аливаа асуудлын тухайд хүчинтэй байна. Түүнчлэн, тийнхүү цуцалсан нь Гэрээг цуцлахаас өмнө бий болсон эрх, үүрэг, хариуцлагыг аливаа хэлбэрээр хөндөхгүй ба тийнхүү цуцалсан эсэхээс үл хамаарч тухайн эрх, үүрэг, хариуцлагыг бүрэн эдлэх эсхүл хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай энэхүү Гэрээний заалтууд нь Гэрээг цуцалсны дараа шаардлагатай хугацаагаар хүчинтэй байна.</p>	<p>19.10 Survival</p> <p>Notwithstanding termination of this Agreement by either Party or for any reason, including a termination due to a finding that this Agreement or a portion thereof is void, invalid, or unenforceable, Clauses 14, 15, 16, 18 and 19 of this Agreement shall survive such termination and shall remain effective as to any matters which are the subject of this Agreement or which arise out of, in relation to or in connection with this Agreement. Moreover, any such termination shall be without prejudice to rights, duties and obligations that have accrued prior to termination and, notwithstanding such termination, such provisions of this Agreement as are reasonably necessary for the full enjoyment and enforcement of such rights, duties and obligations shall survive such termination for the period necessary.</p>
<p>Гарын үсэг зурах хуудас</p> <p>ДЭЭРХИЙГ НОТЛОН, Талууд өөрсдийн эрх олгогдсон төлөөлөгчөөрөө дамжуулж дээр заасан он, сар, өдөр гарын үсэг зурав.</p>	<p>Signature Page</p> <p>IN WITNESS WHEREOF, the Parties have executed this Agreement through their authorized representatives on the date first written above.</p>
<p>Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж:</p> <p>.....</p>	<p>On behalf of the Government of Mongolia:</p> <p>.....</p>
<p>Орано Майнинг САС-ийг төлөөлж:</p> <p>.....</p>	<p>On behalf of Orano Mining S.A.S:</p> <p>.....</p>
<p>Бадрах Энержи ХХК-г төлөөлж:</p> <p>.....</p>	<p>On behalf of Badrakh Energy LLC:</p> <p>.....</p>

Хавсралт 1 / Appendix 1.

Royalties rates

ROYALTIES PRODUCT SALES VALUE OF (U_3O_8 (USD/LB U_3O_8)	BASIC ROYALTIES RATE	SPECIAL ROYALTIES RATE	PROGRESSIVE ROYALTIES RATE
0 up to 40	5%	0%	0%
40 up to 50	5%	0.5%	0%
50 up to 60	5%	5%	1%
60 up to 70	5%	5%	2%
70 up to 80	5%	5%	3%
80 up to 90	5%	5%	4%
90 up to 100	5%	5%	5%
100 up to 110	5%	5%	6%
110 up to 120	5%	5%	7%
120 up to 130	5%	5%	8%
Above 130	5%	5%	9%

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ

Ураны хүдрийн баяжмал (ураны исэл U_3O_8) (ам.доллар/фунт/ U_3O_8)	АМНАТ-ын хувь	Тусгай АМНАТ-ын хувь	Нэмэлт АМНАТ-ын хувь
0-40 хүртэл	5%	0%	0%
40-50 хүртэл	5%	0.5%	0%
50-60 хүртэл	5%	5%	1%
60-70 хүртэл	5%	5%	2%
70-80 хүртэл	5%	5%	3%
80-90 хүртэл	5%	5%	4%
90-100 хүртэл	5%	5%	5%
100-110 хүртэл	5%	5%	6%
110-120 хүртэл	5%	5%	7%
120-130 хүртэл	5%	5%	8%
130 ба түүнээс дээш	5%	5%	9%

ХАВСРАЛТ 2 / Appendix 2

Тусгай зөвшөөрлийн газрын зураг
Licenses Map